

ӨМНӨТГӨЛ

1990 оны цагаан морин жилийн Ардчилсан Хувьсгалын өөрчлөлтүүдийн үр дүнд монголчуудын улстөр, эдийн засгийн ухамсар сэтгэлгээ гүн нойрноосоо сэргэж, их өөрчлөлтүүдийн жилүүд эхлэв. Хөрөнгө мөнгө, амьдрал ахуйгаа нам засагт даатгадаг цаг нэгэнт өнгөрч, хэн юу хийж чаддаг, мэдлэг мэддэгээрээ хүссэн газраа хангалуун амьдрах эрх чөлөөтэй болов.

Төр засгийн хатуу хяналтын дор байсан эдийн засаг зах зээлийн цоо шинэ харилцаа руу шилжиж, түүний зэрэгцээгээр оюун санаа, сэтгэхүй, соёл боловсролжилтийн түвшинд гүнзгий нөлөөлж, үе үеийн үндэсний ухамсарын мандан бадралын шинэ цагийг эхлүүлсэн билээ. Социализмийн жилүүдэд эцэг өвгөдийнхөө тухай байтугай эзэн Чингисээ хүртэл дурсаж үндэсний үзэлтэн гэгдэхээс эмээж сэтгэл зүрхэндээ битүүхэн тээж явсан үндэснийхээ арвин өв сан, ёс заншил, бахархалт түүхээ өнөөгийн монголчууд ил тодоор сэргээж бахархан бичиж байна.

Монгол угсаатны нэгэн салаа мөчир буриадууд эрүүл саруул шинэ цагийн ачаар туулж өнгөрүүлсэн ээдрээт түүх, соёл, ёс заншлаа үнэн зөвөөр нь сэргээн сурталчлах сэтгэл зүрхний хүсэл тэмүүлээ хэрэгжүүлж эхлэв. “Буриадын өв соёлын нийгэмлэг”, “Буриад ардын өв соёлыг сэргээн хөгжүүлэх сан” байгуулагдаж, “Угай бэшэг” сонин гаргаж, “www.toonto.mn”, “www.buryatia.org”, “www.buriat-mongolia.info” зэрэг мэдээллийн портал, сайтууд нээн ажиллуулж, төв, орон нутгийн байгууллагууд нутгийн иргэдээ цуглуулан уулзах зэрэг янз бүрийн ажлуудыг зохион явуулах болсны зэрэгцээ дэлхийн улс орнуудад (Орос, Хятад, Австрали, Америк, Япон, Энэтхэг зэрэг болон бусад) таран байрласан буриадуудтайгаа холбоо тогтоон хамтран ажиллах боллоо.

1994 оноос гараагаа эхэлж хоёр жил тутамд буюу 8 удаа зохион байгуулагдсан буриад түмний соёл, ардын язгуур урлагын “Алтаргана” олон улсын их наадмын хүрээнд эрдэм шинжилгээний бага хурлууд зохион явагдаж, буриадын түүх, зан заншил, угсаатны соёлын өвийг бүх талаас нь сэргээн баяжуулж, хойч үедээ өвлүүлэх болов.

Эдгээр үйл ажиллагааны шууд үргэлжлэл болох бидний хэсэг нөхөд (М.Одмандах, Б.Ширнэн, Г.Гантогтох, Г.Цэрэнханд, Г.Батцэрэн, Б.Чинзориг, Д.Ариунаа, Б.Ууганбаяр)-ийн санаачлан зохион байгуулсан эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилго бүхий Буриад Судлалын

Академи өдөр ирэх тутам өргөжин тэлсээр 2008 оны 5-р сарын 23-ны өдөр “Буриад судлалын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлаа зохион явууллаа.

Эрдэм шинжилгээний бага хуралд Буриад Ардын Өв Соёлыг Сэргээн Хөгжүүлэх сан, ШУА-ийн ХЗХ, Биологийн хүрээлэн, МУИС, МУБИС, ШУТИС, ЭМШУИС, СУИС, “Идэр” дээд сургууль, “Сутай” дээд сургууль, Плехановын нэрэмжит УААДС, Буриадын Их Сургуулийн Улаанбаатар хот дахь салбар, МАА-ын эрдэм шинжилгээний хүрээлэн, НСИСОУХ зэрэг төрийн болон төрийн бус олон нийтийн, хөдөө орон нутгийн, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөгчид оролцож буриад судлалын асуудлаар санал бодлоо солилцлоо.

Хуралд оролцогчид Монгол Улсын ястан үндэстний нэгэн төлөөлөл болох буриадуудын хэл соёл, түүх, зан заншил, угсаатан зүйн судалгааны ажлыг эрчимжүүлэх, эх хэлний сэтгэлгээг хөгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэв.

“Буриад судлал” (I) хэмээх энэхүү хамтын бүтээл нь Сибирийн уугуул үндэстнүүдийн томоохон төлөөллийн үр сад, өнөөгийн монголын буриад угсаатнуудын талаар Буриад Судлалын Академиас гаргаж буй эрдэм шинжилгээний бичлэгийн цувралын анхны оролдлого бөгөөд уг товхимолд “Буриад судлалын тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл, буриад судлалын чиглэлээр бичсэн өгүүлэл, буриадын түүх угсаатан, хэл, соёл, иргэншил, хүн амзүй, генетик, социологийн зэрэг холбогдох зарим байгууллагын ажилтнуудын мэдээлэл зэргийг эмхэтгэн нийтэлж Та бүхэнд толилуулж байна.

Буриад Судлалын Академийн үйл ажиллагааг дэмжиж, сэтгэл санааны урам дэм өгч, эд материалын болон номын хандив өргөж, биднийг байнга дэмжин ажилладаг Буриад Ардын Өв Соёлыг Сэргээн Хөгжүүлэх Сангийн хамт олон, ерөнхийлөгч ноён С.Билэгсайхан, эрдэм шинжилгээний бага хурлыг хийхэд тусламж хандив өргөсөн бизнесмен М.Одончимэг, энэхүү эмхэтгэлийг хэвлүүлэхэд сэтгэл санаа, эд хөрөнгийн дэмжлэг, хандив өгсөн “Улз” төвийн захирал, ноён Г.Эрдэнэбилэг, үйл ажиллагааг маань дэмжиж хэвлэхэд тусалсан “Бемби сан” хэвлэх үйлдвэрийн захирал Н.Ганболд нарт гүн талархал илэрхийлье.

Доктор /Ph.D/ Б.Ширнэн

BURIAD STUDIES

I Боть

1 (001)

2008

*Худанц шарайд Б.Чинзориг
Буриад Судлалын Академийн
гүйцэтгэх захирал*

“БУРИАД СУДЛАЛЫН АКАДЕМИ”-ИАС ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ АЖЛЫН ТУХАЙ

Академийн товч танилцуулга

2007 оноос М.Одмандах буриад судлалын төв байгуулах талаар анхлан санаачилж, 3-р сараас нэр бүхий эрдэмтэдтэй санал солилцож, анхны хурлыг 2007 оны 5-р сарын 26-ны өдөр МУБИС-ийн А байрны 307 тоот өрөөнд Г.Цэрэнханд, Г.Гантогтох, Б.Ширнэн, Г.Батцэрэн, М.Одмандах, Б.Ууганбаяр, Б.Чинзориг, Д.Ариунаа нарын бүрэлдэхүүнтэй хийж, бичиг баримт, дүрэм журам боловсруулах, ТББ болгон хуулийн дагуу бүртгүүлэх ажлыг М.Одмандах, Б.Чинзориг, Б.Ууганбаяр нарт даалгасан юм.

Анхлан Буриад Судлалын Төв байгуулахаар ярилцаж байсан боловч нэр давхардсан тул 2007 оны 11-р сард Буриад Судлалын Төвийн дүрмийг хэлэлцэж явцад Академи гэж нэрлэхээр тогтож, “Буриад Судлалын Академи” үүсгэн байгуулж, 2008 оны 3-р сарын 5-нд хуулийн дагуу бүртгүүлж, ТББ-ын гэрчилгээ, тамга тэмдэгээ авч, хийх ажлын үндсэн чиглэлийг тодорхойлж, ажлын төлөвлөгөөгөө нарийвчлан гаргаж ажиллаж байна.

Академийн зорилго нь “Буриад судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний ажил эрхэлж буй Монгол улсын иргэн судлаач, эрдэмтэд бүх талын дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, гадаад орнуудын энэ чиглэлийн байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах, гадаад дотоодод мэргэжил дээшлүүлэх, сурч боловсрох, эрдэм судлалын ажил эрхлэхэд туслах ба мөн буриадын түүх, хэл соёл, угсаатан, зан заншил, аман болон утга зохиолыг шинжлэх ухааны аргазүйн үүднээс сурвалжлан цуглуулж, судлан тодорхойлох, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд оршино” гэж тодорхойлсон бөгөөд ашгийн төлөө бус нийгэмд үйлчилдэг, эрдэм судлалын ажил эрхлэх төрийн бус байгууллага юм.

Тус байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүдээр доктор, профессор Г.Гантогтох, Г.Цэрэнханд, доктор, дэд профессор, Г.Батцэрэн, Р.Чүлтэмсүрэн, доктор Б.Ширнэн, докторант Д.Ариунаа, магистр Б.Ууганбаяр нар, Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Ерөнхийлөгчөөр доктор М.Одмандах, Гүйцэтгэх захирлаар магистрант Б.Чинзориг, Зөвлөхөөр доктор, профессор Г.Цэрэнханд, Нарийн бичгийн даргаар магистр П.Нармандах нар сонгогдон ажиллаж байгаа ба академийн дэмжигч гишүүнээр 90 гаруй, гишүүнээр 20 гаруй хүн бүртгүүлээд байна.

Хийж буй ажлын тухай

Бид 2008 оны 3-р сарын 28-нд “Буриад судлалын өнөөгийн байдал, хөгжүүлэх чиг хандлага” сэдэвт дугуй ширээний ярилцлагыг буриад судлаачид, эрдэмтэн мэргэдийг оролцуулан хийсэн бөгөөд академийн хийх ажлын төлөвлөгөөг танилцуулж, санал солилцон, үндсэн чиглэлээ нарийвчлан тодорхойлж авлаа.

Энэ дугуй ширээний ярилцлагын үеэр эрдэмтэд бүтээлийн дээжээсээ академид хандив өргөснөөр бид одоогоор 20 гаруй номтой болж, номын сангийн эх сууриа тавиад байна. Мөн академийн дотоод зохион байгуулалтыг оновчтой болгох үүднээс салбартай байхаар тогтож, салбарын эрхлэгч нарыг сонгон ажлыг нь эхлүүлээ.

Манай академийн Түүх, угсаатан судлалын салбарын эрхлэгч Б.Ширнэн, Хэл, зохиол судлалын салбарын эрхлэгч Г.Гантогтох, Соёл, урлаг судлалын салбарын эрхлэгч Г.Батцэрэн, Гадаад харилцаа хамтын ажиллагааны салбарын эрхлэгч Б.Дашням, Эх бичиг, сан хөмрөгийн салбарын эрхлэгчээр Б.Чинзориг нар ажиллаж байна.

2008 оны 4-р сарын 9-12-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Дархад, Буриад судлалын зарим асуудал” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд академийн гишүүдээс илтгэл хэлэлцүүлээ. Мөн 5-р сарын 14-нд Дорнод аймгийн төвд Дорнод Монголын дээд сургуулиас санаачлан ОХУ-ын Буриад Улсын Их Сургуультай хамтран зохион байгуулсан “Буриад ертөнц: үзэл баримтлал ба хэл соёлын бодлого” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хуралд манай академийн гишүүдээс таван хүн илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд ОХУ-ын Буриад улс, Эрхүү мужын Усть Ордын тойрог, Агын тойргоос ирсэн төлөөлөгч нартай хамтран ажиллах талаар гэрээ, хэлэлцээ байгуулж, Чита мужын Агын тойргын буриад хэлний сургалттай Зүтгүлийн дунд сургуультай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар хотын Хөлөнбуйр дээд сургуулийн Монгол судлалын сургуультай хамтран ажиллах талаар ярилцаж, урьдчилсан байдлаар тохирлоо.

ОХУ-ын Агын тойргийн Зүтгэлийн дунд сургуулиас манай академийн үйл ажиллагааг дэмжих үүднээс буриад хэлний сурах бичгийг хандивлахаар хэлэлцэж тохирсноос гадна Монголын буриад сумдын Ерөнхий боловсролын дунд сургуультай хамтран ажиллах, шифийн харилцаа тогтоохоор болоод байна. Ингэснээр буриад сумдын хүүхэд, сурагчид буриад хэл аялгуугаа мартаггүй байх, ёс заншлаа сэргээн хөгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарна гэдэгт бид итгэж, найдаж байна.

Цаашид “Буриад ертөнц” сэдэвт хурлыг хоёр жилд нэг удаа Олон улсын төвшинд хийж байхаар тогтож, зургаан хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулж, тэргүүнээр нь академийн Ерөнхийлөгч М.Одмандах сонгогдсон байна. Манай академиас буриад судлалыг хөгжүүлэх талаар нэлээд ажлыг санаачлан, зарим зүйлийг хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд буриадын түүх, угсаатны зүй болон хэл аялгуу, урлаг соёлыг шинжлэх ухааны үүднээс судлан цуглуулах, залуу хойч үедээ ёс заншил, түүх соёлоо өвлүүлэн, заан сургах талаар тодорхой төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

Хуасай М.Одмандах
Буриад Судлалын Академийн ерөнхийлөгч
МУБИС-ийн багш, доктор /Ph.D/

МОНГОЛ ДАХЬ БУРИАД СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Хураангуй

Энэхүү өгүүлэлдээ Монгол дахь буриад судлалын түүх, өнөөгийн байдлыг чиглэл бүрээр нь тодорхойлон гаргаж цааш нь ямар ажил, судалгаа хийх боломж, шаардлага байгааг тодруулахыг хичээсэн болно.

Монголд буриад судлал нь нэгдсэн системтэй болж хараахан амжаагүй байна. Хүмүүс өөр өөрсдийн сонирхол, хүслийн дагуу энэ тэнд, тархай бутархай, хэсэг бусаг байдлаар судлаж байгаа боловч хүмүүст тодорхой судалгаа алга байна. Ихэнх тохиолдолд аман зохиол, хэл аялгууны материал нь эх хэрэглэгдэхүүний төвшинд цуглуулсан зүйл олон боловч нарийвчилсан судалгааны ажил хийж, нэгдсэн дүгнэлт гаргасан нь харьцангуй цөөн байгаа юм. Тиймээс цаашдаа дээрх баялаг эх хэрэглэгдэхүүнийг нарийвчлан судлах нь өнөөгийн буриад судлаачдын өмнө тулгарсан чухал ажил болоод байна.

1. Буриад судлалын өнөөгийн байдал

Монгол судлалын нэгэн салбар болсон “буриад судлал” одоогоос 60 гаруй жилийн тэртээ эхэлсэн хэдий боловч монгол судлалын нэгэн хавсарга судалгааны хүрээнд явж ирснээс бус бие даасан судлагдахууны хувьд төдийлөн нарийвчлан судлагдаагүй явсаар өдий хүрсэн байна. Монголын түүх-угсаатан зүй, ардын аман зохиол, урлаг, утга, соёл судлал зэрэг судалгааны хүрээнд тодорхой эрдэмтэд судалгаа хийж, ШУА-ийн Хэл зохиолын болон Түүхийн хүрээлэнгээс эрдэм шинжилгээний экспедицээр 10 гаруй удаа монголын буриадуудын амьдран суудаг аймаг, сумаар явж, аман зохиол, түүх, угсаатны зүйн холбогдолтой, эд өлөг, эх хэрэглэгдэхүүнийг сурвалжлан цуглуулж, хүрээлэнгүүдийн сан хөмрөгт хадгалсан байна.

Гэвч тал бүрээс нарийвчлан судалсан зүйл нэн ховор байгаа нь Монголд “буриад судлал” төдийлөн бие даасан салбар болоогүйг харуулж байна. Энд түүхэн нөхцөл шалтгаан байсныг үгүйсгэх аргагүй. Харин энэ үед академич Б.Ринчин, түүхч, эрдэмтэн зохиолч Х.Пэрлээ, угсаатан судлаач эрдэмтэн Х.Нямбуу, доктор, профессор Б.Сумьяабаатар, Ж.Цолоо, Г.Гантогтох зэрэг манай нэртэй судлаачид тодорхой хүрээ, хязгаарын дотор эрдэм судлалын ажил эрхэлж, илтгэл, өгүүлэл, ном товхимол нийтлүүлж байсан нь сайшаалтай хэрэг юм. Тэд бол монгол дахь

буриад судлалын эх суурийг баттай тавьж өгсөн гавьяатай хүмүүс. Түүний буухиа өнөөдөр улам батжин, өргөжин тэлж байгааг бид харж байна.

Харин 1990 оны ардчиллаас хойш монголын ястан угсаатнууд түүх, аман зохиол, хэл, соёл, ёс заншлаа сэргээх, түүнийг судлан тодорхойлох талаар чөлөөтэй болж, төдий чинээгээр судлаачид бие даасан эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хийх болсон нь **монгол судлалд** чухал зүйл байсан юм. Үүний үр дүнд цөөнгүй эрдэмтэд ойрд, дархад, хотгойд, буриад судлалын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалж, нэг сэдэвт зохиол болон эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, нэг сэдэвт зохиол бичиж хэвлүүлэх болсон нь монгол судлалд, тэр дундаа ястан, угсаатан судлалд тодорхой ахиц дэвшил гарсныг харуулж байна.

Өнөөдөр Боржигон судлалын төв, ойрд судлалын “Тод номын гэрэл төв”, Хотгойд судлалын төв, Буриад судлалын академи, Дархад судлалын нийгэмлэг зэрэг ТББ-ууд бий болж ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд болон гадаадын судалгааны байгууллагуудтай хамтран түүх, утга соёл, ястан угсаатны соёл, ёс заншил, аман зохиолын талаар эрчимтэй судалгаа хийж байгаа нь “Монгол судлал”-д оруулж буй тэдний хувь нэмэр юм. Ингэж монголчууд өөрсдийн ястан, угсаатны талаарх иж бүрэн судалгааг бүрэн хийж чадах аваас **монгол судлал** жинхэнэ утгаараа хөгжиж, шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр болох боломжтой.

Буриад судлалын асуудлаар сүүлийн жилүүдэд манай улсад “Алтаргана-2000” наадмын хүрээнд “Буриад монголчуудын угсаа-түүхийн зарим асуудал”, 2008 оны 4-р сард Хөвсгөл аймгийн Мөрөн хотод “Дархад, Буриад судлалын зарим асуудал”, мөн 5-р сарын 14-нд Дорнод аймагт Дорнод дээд сургууль, ОХУ-ын Буриад Улсын Их Сургуультай хамтран “Буриад ертөнц: үзэл баримтлал ба хэл соёлын бодлого” зэрэг Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан нь буриад судлаач эрдэмтдийн хувьд бүтээсэн хийснээ олон нийтэд түгээхэд ихээхэн ач холбогдолтой болсон юм. Мөн зарим эрдэмтэд гадаад улс орнуудад болсон эрдэм шинжилгээний бага хурал, симпозиумд удаа дараа оролцож илтгэл хэлэлцүүлж, цөөнгүй өгүүлэл, судалгааны бүтээл хэвлэгдэх болсон нь монголын буриад судлал бие даасан нэгэн салбар болон хөгжих боломжтойг харуулж байна.

Буриад судлалыг хөгжүүлэхийн төлөө бие сэтгэлээ чилээн, оюун бодлоо хөвчилж байгаа Б.Сумьяабаатар, Г.Гантогтох, Г.Цэрэнханд, Р.Рэгэндорж, Л.Галбаабадраа, Д.Дамдинжав, Д.Ханджав, Т.Галсан, Б.Ширнэн, А.Оюунтунгалаг нарын судлаачдын буухиаг үргэлжлүүлэх залуу судлаачдыг бэлтгэх нь монголд буриад судлал тасралтгүй, залгамж холбоонд хөгжих бодит боломжийг нээх юм. Ахмад, залуу судлаачдын нягт холбоог хангах нь бидний цаашид анхаарах гол зүйлийн нэг гэж бодож байна.

Буриад судлал ийм төвшинд хөгжихөд 1994 оноос эхэлсэн буриадын “Алтаргана” наадам үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд буриад гэсэн ухамсар, сэтгэлгээ, буриад монголчуудаа гэсэн сэтгэлийг бадраасан, цаашид судалгаа шинжилгээний ажил эрхлэх зайлшгүй шаардлагатай төдийгүй цаг нь болсон гэдгийг ухааруулсан том үйл явдал байсан юм. Тийм учраас “Алтаргана” наадмын түүхэн ач холбогдол, ирээдүйн үүргийн талаар мартаж хэрхэвч болохгүй бөгөөд цаашид улам өргөн дэлгэр болгож, буухиаг таслалгүй авч явах нь монгол улсын хэмжээний асуудал болоод байна.

2. Буриад хэл, аялгуу судласан тойм

Монгол эрдэмтэд буриад-монгол хэл аялгууны талаар бие даасан дорвитой судалгаа шинжилгээний бүтээл сүүлийн жилүүдэд цөөн боловч хэвлэгдсэн байна.

Профессор Ж.Санжаа “ОЦМХ-ний авиазүй” бүтээлдээ буриад-монгол хэлний авиа зүйн зарим онцлогийг дурьдсан, профессор Ц.Өнөрбаян “ОЦМХ-ний үгзүй” бүтээлдээ үгзүйн талын зарим онцлогийг дурьдсан ба мөн академич Д.Төмөртоогоо “Монгол хэлний түүхэн хэлзүй” номын 1 боть “Түүхэн авиа зүй” бүтээлдээ буриад хэлний авианы зарим түүхэн хувьсал онцлог талаас нь судлаж дүгнэлт гаргасан байна.

“Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй” /1983 он/ хамтын бүтээлд авиа зүй, үг зүй талаас нь харьцуулан судласан байна. 1987 онд Г.Гантогтох “БНМАУ-ын нутгийн аялгууны толь бичиг” /Буриад аялгуу/-ийг бичсэн боловч 1988 онд цөөн тоогоор хэвлэгдэж, мөн 1992 онд Сөүл хотод цөөн тоогоор хэвлэгдсэн нь манай судлаач, хүмүүст төдийлөн хүрээгүй байна. Уг толь нь орчин цагийн монголд хэлний буриад хэл аялгууг судлах үгийн сангийн гол хэрэглэгдэхүүн болохуйц том бүтээл болсон юм.

Хэл шинжлэлч, доктор Б.Ширнэн “h”-авиаг судлахын оршилд” /УБ, 2005/ гэсэн h авианы тухай авиан зүйн талаас нь мөшгин хөөсөн нэг сэдэвт судалгааны бүтээл нь буриад хэл аялгууны нэгэн өвөрмөц онцлогийн нэг “h” авиаг дэлхийн хэл аялгууны ижил төстэй үсэг болон авиалбарын талаар иж бүрэн судалгаа хийсэн нь ихээхэн олзуурхууштай ажлын нэг болжээ.

Буриадын хэл аялгууг дагнан судлаж Т.Цэрмаа “Ага аялгуу” /2004/, Г.Батзаяа “Монгол хэлний нутгийн аялгуунуудын авианы харьцуулал” /2007/ зэрэг сэдвээр докторын зэрэг хамгаалсан бол МУИС-ийн багш Г.Гантогтох “Буриад аялгууны үгийн сангийн бүрэлдэхүүний онцлог”, “Монгол зан үйлийн аман зохиолын уламжлал” зэрэг сэдвээр дэд докторын болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан байна. Дээрх судалгаанд буриадын хэл аялгуу, тэр дундаа үгсийн сангийн талаас нь харьцуулан судалж дүгнэлт хийсэн нь буриад судлалд томоохон хувь нэмэр болсон гэж дүгнэж болох юм.

Буриад монгол хэлний аман аялгууг судлахад хэрэглэгдэх тулгуур эх материалын арвин их цуглуулга нь ШУА-ийн ХЗХ-ийн номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байна. ХЗХ-ийн нутгийн аялгуу судлалын эрдэм шинжилгээний ангийн судалгаа, мөн МУБИС-ийн эрдэм шинжилгээний ангийн судалгааны материалуудад түшиглэн буриад хэл аялгууг судлан, авиазүй, үгзүй, үгийн сангийн төвшинд иж бүрэн судалгаа хийх нь нэн шаардлагатай байна. Мөн саяхан Дорнод дээд сургуулийн багш, докторант С.Алтанцэцэг “Буриад хэл аялгууны зөрөөтэй үгийн толь” /2007/ бэсрэг толь бичсэн нь Дорнодын хорь, ага аман аялгууны халх аялгуунаас зөрөөтэй үгийг тайлбарлан хэвлүүлсэн нь судлаачдад нэн хэрэгтэй ном болсон байна.

3. Буриад аман зохиол судлалын тойм

Буриад судлалын нэгэн салаа мөчир болсон буриадын аман зохиол судлах ажил монгол улсад нэлээд хэдэн жилийн өмнөөс эхэлсэн боловч нэгдсэн системтэй уялдаа холбоотой судалсан судалгаа хараахан алга байна. Өнөөдөр буриадын аман зохиолыг цөөхөн эрдэмтэд

Монголын буриадын аман зохиолыг Б.Ринчен, Ц.Сумъяабаатар, Х.Сампилдэндэв нар анхлан, бөө мөргөл, угийн бичиг, хуримын зан үйл, яруу

найргийг нь судалсан. Ч.Содном “Буряад арадай дуунууд” (1964), Г.Цэрэнханд “Буриад зан үйлийн дуу” (1988) түүвэр, Тойсомын Галсан “Монголын Буриадын амрагийн дуу” (1994), “Буриад язгуур домгийн товчоон” (1998), Афганистаны Абдул Мажид “Монголын буриадын ардын дууны яруу найргийн онцлог” (1994), Д.Бямбасүрэн “Буриад түмний гарал, түүх, угсаатны онцлог” (2003), Д.Дамдинжав, “Бөртэ чоно, Барга баатар, Алун Гуа нарын судалгааны зарим асуудалд” (2004), Д.Ханджав, С.Батбилиг “Буриад-Монголчуудын тотем, уриа дуудлагын тухайд” (2002), Р.Чүлтэмсүрэн Дорнод аймгийн нэрт зайран агсан, буриадын галзууд омгийн Чойжилын Цэрэнгийн тухай “Хэцийн дуу тасраагүй” өгүүлэл, Г.Гантогтох буриадын бөө мөргөл, угсаатны зүй, зан үйлийн аман зохиолыг судалж, Дорнодын Багшийн сургуулийн багш С.Алтанцэцэг буриадын зан үйлийн дууг нарийвчлан судалж байна.

Судлаач Тойсомын Галсан буриадын язгуур домгийг судалж эрдмийн зэрэг хамгаалсан нь одоогоор хийгдээд байгаа иж бүрэн судалгааны нэг болсон байна. Аман зохиол судлаач, хэлшинжлэлийн шинжлэх ухааны доктор, профессор, МУИС-ийн багш Г.Гантогтох, доктор, профессор Ж.Цолоо нар хамтран олон жилийн турш сурвалжлан цуглуулсан эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан “Арван гурван ноёдын дуун” /2007/ эмхэтгэлийг хэвлүүлсэн нь буриадын аман зохиол судлалд үнэтэй хувь нэмэр болсон жинтэй бүтээл юм. Гэвч буриадын ардын аман зохиолын эх хэрэглэгдэхүүнийг бүрэн судалж, чиглэл чиглэлээр судалгааны ажил эрхлэх боломж их байна. Тууль, явган үлгэр, зүйр цэцэн үг, оньсого таавар, хууч яриа, домог, зан үйлийн аман зохиол, буриадын хуримын аман зохиол гэх мэт сэдвүүд бараг хөндөгдөөгүй атар хэвээр байна. Цаашид залуу судлаачид эдгээр сэдвээр ажиллах бүрэн боломжтой байна.

Монголын талаас аман зохиол судлаач Ч.Содном 1964 онд “Буряад арадай дуунууд” нэртэй 300 орчим дуу багтаасан нэгэн эмхэтгэлийг хэвлүүлэхдээ Дорнод, Хэнтий аймгийн буриад нарын дунд өргөн дэлгэрсэн, нийтлэг сэдэв бүхий ардын дууг багтааж, оршил тайлбар хийн хэвлүүлсэн нь нэлээд сонирхол татах эх хэрэглэгдэхүүн болсон байна. 1983 онд Н.Дулмаа “Хувьсгалын дуу” гэсэн бяцхан эмхэтгэлийг нот, оршил тайлбарын хамт 70 гаруй дууг багтааж хэвлүүлсэн нь хувьсгалын сэдэвт буриад ардын дууг судлахад чухал хэрэглэгдэхүүн болсон ном юм. 1988 онд “Буриад ардын зан үйлийн дуу” гэсэн эмхэтгэлийг доктор Г.Цэрэнханд эмхэтгэн хэвлүүлсэн бол 1994 онд Т.Галсан “Монголын буриадын амрагийн дуу” түүвэр, 2004 онд ардын армийн хурандаа асан Б.Цэрэн “Буриад дуунай түүбэри” /2005/, Л.Галбаабадраа “Хөвсгөл нутгийн буриад зоны суух хуурын сургалтын буриад дууны түүвэр” /Мөрөн, 2008/ зэрэг түүвэр хэвлүүлсэн нь буриад дууны судалгааны эх хэрэглэгдэхүүнийг баяжуулсан хэрэг юм.

Мөн Афганистаны монголч эрдэмтэн Абдул Мажид 1995 онд буриад дууны судалгаагаар эрдмийн зэрэг хамгаалсан бол СУИС-ийн багш Г.Батцэрэн мөн буриад дууг судлан урлаг судлалын ухааны докторын зэрэг хамгаалсан явдал нь уг сэдэв судалгааны эргэлтэнд баттай орж, судлаачдын анхаарлыг татсаныг гэрчилнэ. Энэ бүхнээс үзэхэд буриад дууны судлал нэлээд өргөжин хүрээгээ тэлсэн нь харагдаж байна. Гэвч эмхэтгэн хэвлүүлсэн нь нэлээд буй боловч нарийвчилсан судалгаа хараахан бүрэн хийгдээгүй байна.

Буриад туулийн талаар Дорнод Дээд Сургуулийн багш докторант Б.Шагдаржав нэлээд зүйлийг хийж, цөөнгүй туулийг буриад хэл аялгуунаас орчин цагийн монгол

хэлрүү хөрвүүлэн хэвлэлд бэлтгэснээс гадна, ажиглалт, шинжилгээ дүгнэлт хийж байгаа нь буриадын тууль судлалд оруулж байгаа томоохон хувь нэмэр юм.

4. Буриадын түүх судлалын өнөөгийн байдал

Монголын буриадуудын түүхийн судалгаа нэлээд ахицтай байгааг онцлон дурдах хэрэгтэй байна. Түүхийн талаар нэлээд эрдэмтэд бүтээл туурвиж байгаагаас гадна ахмад настууд өөрийн мэдэх хүрээнд буриадын гарал угсаа, түүхийн талаар судалгаа хийсээр байна. Тухайлбал, судлаач Р.Рэгзэндорж, Д.Дамдинжав, А.Оюунтунгалаг, Б.Санжаадамба, Г.Батжаргал, Т.Галсан, Д.Ханджав, Б.Ууганбаяр, Б.Ширнэн, С.Ишбалжир, Д.Бадамням нарын зэрэг олон судлаач, багш нар буриадын түүхийн тодорхой асуудлыг сонгон авч өөр өөрийн судалгааг хийсээр байна.

Буриадын угсаа гарвал, түүхийн талаар монголд сүүлийн хэдэн жилд хэд хэдэн хурлыг хийсэн нь түүх судалгаанд түлхэц үзүүлсэн ажил болсон байна. Уг хурлуудаар буриадын угсаатны зүйн болон түүхэн талаас нь нэлээд асуудлыг дэвшүүлэн тавьж, шийдвэрлэхийг зорьсон байна. Монголын буриадын түүхийн талаарх судалгаа нь гарал үүслийн талаар болон их нүүдэл, 1930-аад оны их хэлмэгдүүлэлтийн талаар голлон анхаарч ирсэнээс гадна ихэвчлэн монгол руу нүүсэн гурван удаагийн нүүдэл, 1930-аад оны их хэлмэгдүүлтийн талаар анхаарч ирсэн нь нэг талаас өрөөсгөл хандлага гэж үзэж болохоор байна. Мөн монголын буриад сумдын түүхэн товчоог бичиж гаргасан нь буриадын түүх судлалд үнэтэй хувь нэмэр болсон бүтээлүүд болсон байгааг тэмдэглэн хэлэх нь зүйд нийцнэ. Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо, Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Батширээт зэрэг сумын түүхэн товчоонд буриадын түүхийн чухал чухал мэдээ баримтууд байгаа нь түүх судлалд эргэж харах, судлан тодорхойлох шаардлагатай юм.

С.Баттогтохын “Нууц хуйвалдаанаас нугалаа завхралд”, А.Нямаа, Батцэцэг “Орос дахь монгол угсааны хүмүүс”, Д.Дамдинжав “Монголын буриад зон” /2002/, “Монголд дагаар орсон буриадын товч түүх” /Чойбалсан, 2000/, “Шинэ монголын төлөө тэмцэж явсан буриадууд тэдгээрийн хувь заяа” /2006/, Д.Бадамням “Буриадууд цагааны оргодол гэж үү” /2000/, Алтаргана наадамд зориулсан “Буриад монголчуудын угсаа-түүхийн зарим асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл /2000/ зэрэг бүтээл болон монгол улсын түүхийн ботиудад буриадын түүх, гарал угсааны талаар судлан шинжилсэн байдаг.

МУБИС-ийн БС-ийн багш доктор, дэд профессор А.Оюунтунгалаг монголын буриад нарын түүх, угсаатны талаас нь судлан “Монголын буриад” сэдвээр түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан нь буриадын түүх судлалаар хамгаалсан иж бүрэн судалгааны нэг болсон юм.

5. Буриадын угсаатан судлалын өнөөгийн байдал

Буриад монголчуудыг угсаатны зүйн талаас нь дагнан судалсан судалгааг цөөн бус хэвлэгджээ. Монголын угсаатны зүйн судалгааны нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж судлагдсаар өдийг хүрсэн байна.

Судлаач Х.Пэрлээ, Б.Ринчен, Х.Нямбуу, Г.Цэрэнханд, Б.Сумьябаатар, Б.Ширнэн, А.Оюунтунгалаг, Д.Ханджав нарын зэрэг эрдэмтэн судлаачид буриадын угсаатны зүйн талаар чамбгүй судалгаа хийжээ. Нэрт эрдэмтэн Х.Пэрлээ “Нэгэн гэрийн түүхийн тухай” /1958/, Б.Ринчен “Сэлэнгийн зургаан эцгийн тухай” /УБ., 1959/, “Хори-буриадын нэгэн угийн бичгийн тухай” /1965, Мажар/, С.Сумьябаатар

“Буриадын угийн бичгээс” /1966/, Г.Цэрэнханд “Буриадын гарал үүсэлд холбогдох тэмдэглэл”, Х.Нямбуу “Буриад”, “Ойрд” цуврал өгүүлэл, Д.Бямбасүрэн “Буриад зоны уг гарал угсаа” /2003/, Б.Ширнэн “Тэнгэр уншихуй” /2004/, А.Оюунтунгалаг “Монголын буриад” /2004/ зэрэг бүтээлд буриадын гарал угсаа, угсаатны зүйд холбогдох олон асуудлыг хөндөж, ялангуяа буриадын бөөгийн гарал үүсэл, домог, шүтлэг, аман билэг талаас нь судалгааны эргэлтэнд оруулсан явдал нь энэ чиглэлийн судалгаанд үнэтэй эх хэрэглэгдэхүүн, судлагдахуун болж байна.

Өнөөдөр буриадын бөө судлал харьцангуй сайн хөгжсөн бөгөөд үүнд судлаач, академич Б.Ринчен, доктор, профессор С.Дулам, доктор, профессор Д.Бум-Очир нарын оруулсан хувь нэмэр үлэмж их юм.

Эдгээр бүтээлээс харж байхад буриадын хувцас, эд өлөг болон идээн соёлын талаар судлан тодорхойлноос гадна ёс заншил уламжлалын талаар эх хэрэглэгдэхүүнийг хэвлүүлсэн учраас хойч үеийн судлаачид судлан тодорхойлох шаардлагатай болжээ.

6. Буриад судлалын цаашдын чиг хандлага, тулгамдсан асуудал

Өнөөдөр монголд буриад судлалыг тодорхой систем дэс дараатай, бодлого чиглэлтэйгээр эрдэмтэн судлаачдын хүч, боломж, бололцоог нэгтгэн чанарын шинэ шатанд гаргах нь цаг үеийн шаардлагаар бидний өмнө тавигдаж байна.

Буриад Судлалын Академи нь эхний ээлжинд “**монгол дахь буриад судлал**”-ыг хөгжүүлэхэд анхаарахаас гадна гурван гүрний буриадын аж амьдрал, ёс заншил, түүх, угсаатны зүйн судалгааг харьцуулан судалж, бүх талын судалгаа шинжилгээний ажлыг иж бүрэн хийхийн тулд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд өмнөх судлаачдын хийсэн бүтээснийг дахин давтахгүйгээр шинэчлэн хөгжүүлж, буриад судлалыг шинэ шатанд гаргахад анхааран ажиллана.

Бидний өмнө шийдвэрлэх нэг чухал зүйл бол буриад судлаачдын залуу халааг бэлтгэх, тэднийг сургаж дадлагажуулах, сэтгэл зүрхээрээ буриад судлалын ажлыг эрхлэн ажиллах залуучуудыг олж, тэднийг дэмжин туслах, эрдэм судлалын ажлын арга зүйд сургахаас гадна гадаад хэлний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хөрш орнуудын буриад судлаачдын туршлагаас суралцуулж, цаашдын эрдэм судлалын ажилд нь чиглүүлэх юм.

Монгол орны буриад сумдын нутгаар 10 гаруй удаа экспедициэр сурвалжлан цуглуулсан эх хэрэглэгдэхүүнийг шинжлэх ухааны эргэлтэнд оруулж, олны хүртээл болгохын тулд холбогдох хүрээлэн, байгууллагууд-тай хамтран ажиллах талаар төлөвлөж байна. Энэ бол сүүлийн 50 гаруй жилд олж цуглуулсан юугаар ч солишгүй чухал баялаг юм.

Мөн буриад судлалын чиглэлээр бичсэн ном, гарын авлага, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг хэвлэн нийтлүүлж судлаачдын хүртээл болгох нь буриад судлалд оруулах томоохон хувь нэмэр болохоос гадна судлаачдын хөдөлмөр зүтгэл, буриад судлалд оруулсан гавьяаг жинхэнэ утгаар нь олны сонорт хүргэх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Манай академиас буриад судлалыг дараах зүйлээр өргөжүүлэн судлах, үйл ажиллагааны дараах чиглэл гаргаад байна. Үүнд:

1. Буриадын түүх, угсаатны зүй, хэлзохиол, утга соёл, бөө, шашин соёлын талаарх судалгааг явуулж, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, гарсан үр дүнг нийтийн хүртээл болгох,

2. Буриад монголчуудын түүх-угсаатан, хэл соёлын талаарх мэдээллийг цуврал сэтгүүл, сонин, бусад мэдээллийн хэрэгслүүдээр хүргэх, мөн сургалт, соёлын өдөрлөг зохион байгуулах,
3. Гадаад орнуудад амьдарч байгаа буриад монголчуудтай утга соёлын харилцааг тогтоон хөгжүүлэх, тэдний аж амьдрал, ахуй соёл, түүх угсаатан, аман билгийн талаар эрдэм шинжилгээний экспедиц, аялал зохион байгуулах,
4. Буриадын түүх, угсаатны зүй, аман болон утга соёлын бүтээл, ховор ном, дурсгалуудыг хэвлэж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах,
5. Буриадын ардын язгуур урлаг, үндэсний спортыг судлах, сурталчилан дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах,

зэргээр тогтмол үйл ажиллагаа явуулах бөгөөд эрдэм шинжилгээний бага хурал, эрдэм шинжилгээний сэтгүүл, буриадын аман билэг болон угсаатны зүйн талаар экспедици зохион байгуулах, цуврал ном товхимол гаргах зэрэгт гол анхаарлаа хандуулан ажиллаж, тасралтгүй тогтмол үйл ажиллагаа явуулан, олон нийтэд буриадуудынхаа талаар зөв бодол, хандлага төлөвшүүлэх нь чухал байна.

Мөн гадаад харилцааг өргөжүүлэхэд анхаарч ОХУ-ын буриад болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйрын Шинэхээний буриад монголчууд-тайгаа эрдэм шинжилгээ болон соёлын харилцааг тогтмолжуулж, эрдэм шинжилгээний ажилтнуудыг сургах, харилцан солилцох, туршлагаа хуваалцах, хамтарсан эрдэм шинжилгээний экспедицийг зохион байгуулах зэрэг ажлыг хийх нь буриад судлал олон улсын төвшинд хөгжих боломж, бололцоог нээх болно.

Ингэснээр буриад судлалыг иж бүрэн хандлагатай, гурван гүрэнд буй буриад судлалыг уялдаа холбоотой, харилцан бие биенээ нөхсөн, залгамж холбоотой болгоход манай академийн үйл ажиллагаа чиглэнэ. Бид бүгдээрээ буриад судлалыг дэлхийн төвшинд гаргахын төлөө гар, сэтгэл нийлэн ажиллана гэдэгт итгэж байгаагаа энэ ялдард хэлэх гэсэн юм.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

Моотгон Д.Бадамням

Буриад Улсын соёлын гавъяат зүтгэлтэн

ШИЛДЭЙ ЗАНГИЙН БААТАРЛАГ, ЭМГЭНЭЛТ ДУУНЫ УЧИР

1727-1728 он ганц Шилдэй зангид гай түйтгэр учруулсан төдийгүй нийт нүүдэлчин монголчуудад, хүчирхэг хөрш нартаа хуваагдан бусдын эрхшээлд түмэн зовлон эдлэхийн эхлэл болсон жил байлаа. Энэ бол хаант Орос, Манж Чин улс хоёрын хооронд хил тавьсан жил байлаа.

XVII зууны эхнээс ойн мод шиг олон орос хүмүүс Уралын нурууг даван Сибирь нутаг руу нөмрөн орж, улмаар Байгаль далай хүртэл тархан, Буриадын нутагт хүч түрэн ороод, тэр нутгийн нүүдэлчин “мунгал”¹-уудын газар нутгийг булаан эзэмшиж суурьшсан нь тодорхой. Энэ үеэс эхлэн буриад зон “Ойн модон олон гү. Ород мангад олон гү” гэж ярилцах болжээ. Энэ нь буриад зон Орос гүрэнд “сайн дураар нэгдсэн” хэрэг байлаа гэж түүхийг гуйвуулан, “Буриадууд Орост сайн дураар нэгдсэний 300 жилийн ой!?” хэмээн сүржигнэж байсан нь саяхан. Тэгвэл энэ бол худлаа гэдгийг батлах баримт “Буриадын түүхэнд холбогдох баримт бичгүүд”-эд (“Сборник документов по истории Бурятии. XVII век”. Улан-Үдэ, 1960) өдий төдийгөөрөө байна. Жишээ болгон ганц хоёр баримт дурдъя: Тавьтын ноён П.Зарубины Ангар мөрний цаадах Брацкийн² нутагт 1651-1653 онд дайтсан тухай илтгэл бичигт “Өчүүхэн барлаг намайг цэрэг аваад Лена мөрний эхэн хавийн галт зэвсэг бүхий албаны хүмүүстэй хамт Брацкийн дуулгаваргүй нутгуудыг эрхэндээ оруулаад, тэндэх мунгалын тэрсүүд тайж нарыг миний хүчирхэг мугарт захируул... гэснийг ёсоор болгов” гэсэн бол атаман Иван Похабов илтгэлдээ “Брацкийн тайж нар эндэх острогоос³ урваад албат нартайгаа хамт Мунгалууд руу нүүн одлоо” гэжээ.

Мөн Енисейн воевод⁴ В.Е.Голохвастов Цагаан хаан Алексей Михайловичид 1666 оны 8 дугаар сарын 14-нд илгээсэн өргөх бичигтээ “Эрхэм дээдэс Таны өчүүхэн барлаг миний бие Баргузинд острог байгуулаад тэндээсээ тавьтын ноён Гаврилка Ловцовт 16 цэрэг, хөлсний 3 цэрэг захирсан аравтын ноён Оська Васильевыг өгөөд, бас хааны сан хөмрөгөөс хорооны зэс их буу 1, төмөр мөхлөг сум 40 ширхэг, их хэмжээтэй дарь олгоод, Сэлэнгэд цутгадаг Чика голын адагт ... шинээр шивээ бэхлэлт байгуул, Братск, Түнгүс, Мугальск хүмүүсийг их эзэн хаан Таны үүрдийн барлаг болго... гэж явуулсан... Тэд Чика гол дээр ...4 талдаа өндөр цамхагтай” 60 шажин⁵ тойрог бүхий острог байгуулаад, бүслэлтийн үед хамгаалалт болох шуудуу ухав, шуудууны дотроо үзүүртэй шор олныг зоов” гэсэн байв. Энэ тухай буриадуудын үйлдсэн заргын бичигт: “Атаман Иван Похабов биднийг зүйл бүрээр хүчирхийлэн зовоож, элдвээр хавчин боогдуулж, эмс охидыг хүчээр эдлэн,

самууран завхайрч, мал сүргийг дээрэмдэн, зүйрлэшгүй ихээр айлган сүрдүүлж байна...” гэжээ.

Зөвхөн энэ хэдэн баримтаас үзэхэд буриад зон Орост сайн дураар нэгдэн ороогүй нь тодорхойгоос гадна энэ нутгийн хүмүүс уг гарвал, хэл, соёл нэгтэй монголчуудтайгаа нэгдэх их дүрвэлт энэ үеэс эхэлсэн гэж үзэх үндэс байна.

Уугуул нутаг усандаа эзэн байж чадахаа больсон Хори буриад зоноос Галзууд омгийн зайсан Бадан Турахин, 23 настай Абжа буюу Эрээшхэн удаган нар тэргүүтэй 52 хүн мориор түмэн бэрхшээл туулан алс холын Москва хүрч, I Петр хаанд айлтгал бичиг гардуулжээ. Хаан айлтгал бичгийг үзээд энэ “инородчууд”⁶ зүгээр нэг энэ хүртэл зүтгэж ирээгүй, зовлондоо туугдсан нь лавтай тул тэднийг тайвшруулан өөртөө татаж чадвал Алс Дорнодод бэхжихэд тустай гэж алсын хараатай сэтгээд “Дагаар орсон нутгийн хүмүүсийг хавчин дээрэлхэж үл болно Тийм хэрэг өдүүлсэн хүмүүсийг хатуу цээрлүүлэх болно” гэсэн утга бүхий зарлиг гаргаж нийтэд тунхагласнаас хойш буриад зоны байдал нэг хэсэгтээ зөөлөрч иржээ.

Энэ үеэр Их Монгол гүрний дорнод хязгаарт байсан Манж нар хүчирхэгжээд Хятадын Бээжин хотыг эзлэв. Дараа нь өвөрлөгч монголчуудыг, бас Халх монгол, ойрад монголчуудыг дараалан эзэллээ. Ийнхүү Манж Чин улс Орос гүрэнтэй маш урт газраар халз тулан учрах боллоо. Энэ хоёр гүрэнд эзэмшил газраа тодорхойлон хил тогтоох шаардлага гарсан тул хоёр талаас төлөөлөгчид томилон хэлэлцээ хийж эхлэв. Үүнд Оросын талаас элчин сайд Ф.А.Головин, Чин улсын талаас бүрэн эрхт төлөөлөгч Сонгот нар 1689 оны 8 дугаар сарын 27-нд хэлэлцээ хийж “Нэрчүүгийн гэрээ”⁷ гэгчийг байгуулав. Дараа нь Оросын элчин сайд С.Л:Владиславович-Рагузинский Манжийн бүрэн эрхт төлөөлөгч Чабина, Тэгүт, Тулишен нар 1727 оны 10 сард Хиагтад хэлэлцээ хийж Соёны нурууны Шавийн даваанаас Эргүнэ голын Абагайтын толгой хүртэл хил тавих гэрээ байгуулжээ.

**“Хилэ татаһан учир манай монгол арадта ехэхэн хохирол асарааһан. Юүб гэхэдэ, энэ үе болотор элдэб газарай монголиууд, халхашье, буряадшье, ойрадшье зон бэе бээдээ сүлөөтэй ябалсадаг байгаа. Харин хилын бий болоходо зарима буриадууд хилын саана үлэшэһэн юм. Тэдэнэй нэгэн Шилдэй занги байгаа”¹³ гэж бичсэн. Тийм ээ Орос, Манж хоёр их гүрний тавьсан хилээс болж хуваагдсан Азийн цээжинд орших Их Монгол үндэстний хүмүүс олноороо хэлмэгдэн хохирсны зөвхөн нэг нь Шилдэй занги даруй мөн.*

Эдгээр гэрээний дагуу хил тавих ажил шуурхай эхлээд 1728 он гэхэд шувтарчээ. Буриадын нэрт монголч эрдэмтэн, доктор Ш.Б.Чимитдоржиев энэ тухай: “Хил тогтоох үеэр Шилдэй занги 800 албат нарынхаа хамт Улз, Хэрлэн гол, Далай нуур хавиар нутаглаж байсан бололтой. Ширабнимбуу Хубитуевын “Оросын гүрний зүүн Сибирийн дотор агч Буриад хэмээх ястан зоны гүрэн гарсан ба түүний дотроос Хори”¹¹ эцгийн буриад зоны түүх”-д бичсэнээр бол Шилдэй занги хил тавих ажилд идэвхтэй оролцож явсан Шодо Болтирог гэдэг тайж хүний ойрын хамаатан галзууд омгийн хүн байжээ. Ойрын төрөл нь хилийн цаана үлдэх болсонд санаа зовсон Шодо уугуул нутагтаа даруй нүүж ир гэж хэлүүлсний хариуд Шилдэй занги өөрийн засуулыг⁹ илгээн “Хэрвээ морь хэрэгтэй бол ардаг хүрэн тэргүүтэй 6 морь, эмээл хэрэгтэй бол алтан эмээл авагун” гэж хэлүүлжээ. Шодо Болтирог энэ үгийн “Хилийг Ардаг хүрэн болон тэр хавийн 6 гол, Алтан эмээл гэдэг уулыг

оролцуулаад тавих хэрэгтэй” гэсэн далд утгыг үл ойлгон, баярхаж байна гэж бодоод хил тавих газрыг сонгох талаар ямар нэг санаачлага гаргалгүй өнгөрчээ.

“Хори буриадын хураангуй түүх” гэдэг нэр нь үл мэдэгдэх зохиогчийн сурвалж бичигт Ширабнимбугийн бичсэнийг бараг хэвээр нь давтаад, “Засуул тэргүүтэй Шилдэй зангийн элч нар хилийн дээс тавих газрыг сонгон бичигтэй цагаан чулуугаар тэмдэг тавьсан¹⁰” тухай дурджээ.

Эдгээр түүх бичгээс гадна “Балжин хатны тухай дурдалга (тууж)” гэх мэт Буриадын түүхийн сурвалж бичгүүдэд гардаг “Алтан эмээл” хэмээх уул, Ардаг хүрэн гэдэг гол” манай улсын дорнод хилийн цаахна Шинэ барга хошууны нутагт байдаг.

Мөн “Хори буриадын тухай Ацгатын товчоон” хэмээх гар бичмэлд Шилдэй занги хилийн цаана үлдсэн шалтгааныг дээрх байдлаар өгүүлээд, хил тогтоогдсоноос хойш хэдэн жилийн дараа “1730 оны үес Шилдэй занги 800 өрх албат нараа аваад хил давахыг оролдоод Оросын хасаг цэрэгт баригдан Манжийн ноёдод цаазлагдсан...” гэж дурдсанаас гадна Шилдэй зангийн дууны нэг хувилбарыг сийрүүлжээ:

Найман ханатай гэрээ

ачаалан ябажа гарлаа би

Найман зуун албатаяа

дагуулан ябажа гарлай би

Тэмээнэйнгээ олондо

тэнюүн газар бэдэрлэй би

Тэнэгэйнгээ ехэдэ тэбхэр

хили алхалай би

Адуунайнгаа олондо арын

шивээ бэдэрлэй би

Айдарайнгаа ехэдэ алтан

хили алхалай би

Хонинойгоо олондо хоту

шивээ бэдэрлэй би

Холшоройгоо ехэдэ хүндэлэн

хили алхалай би

Хара хүхэ мориёо харайжа

хүсэгдэхгүй гэжэ наналай би

Хан баабай эзэнээ харадажа

барихагүй гэжэ наналай би

Энэ зууны өөр нэг хувилбарыг Ж.Бадамдаш “Алтаргана” хэмээх буриад ардын дууны эмхтгэлдээ оруулжээ.

Шэлдэй занги

Гунан гунан хараханайнь зай да зай

Гүйдэл шэнжэнь адли

Гүлмэр багахан зангийнъ зай да зай

Нуудал шэнжэнь адли

Өдуунайнгаа олондо, зай да зай

*Аранга шэбээ бодхолойб
Айдарайнгаа ехэдэ, зай да зай
Алтан хилэ алхалайб
Хонинойнгоо олондо, зай да зай
Хобто шэбээ бодхолойб
Холшоройнгоо ехэдэ, зай да зай
Хуули хилэ алхалайб
Тэмээнэйнгээ олондо, зай да зай
Тэбхэ шэбээ бодхолойб
Тэршээгэйнгээ ехэдэ, зай да зай
Тэгшэ хилэ алхалайб
Гунан гунан хараханинь, зай да зай
Гурбан хүлдөө шүдэртэй
Гүлмэр багахан зангинь, зай да зай
Гурбан дабхар сэрэг соо
Дүнэн дүнэн хараханинь, зай да зай
Дүрбэн хүлдөө шүдэртэй
Дүүхэн багахан зангинь, зай да зай
Дүрбэн зүгтөө сэрэгтэй
Хажа л мүнгэн хаадагни
Хажуу газар жэбэрбэл
Хайран бага наһамни
Харийн газар нүгшэбэл*

Энэ бол голдуу Онон голын Дадал, Биндэр, Батширээт сумын буриадуудын дуулдаг хувилбар бололтой. Ага нутгаас гаралтай Улз голын буриадуудын дуулж заншсан хувилбар ийм:

*Гунан гунан харахамни
Гүйдэл дундаа зогсобо
Гүлмэр багахан Шилдэй занги
Идэр дундаа зогсобо
Хайбан хайбан харахамни
Хатар дундаа зогсобо
Харахан баахан Шилдэй занги
Идэр дундаа зогсобо
Хүхэ түмэр хаадагни
Хүбиийн оёрто жэбэрэбэ
Хүйхэр хүхюүн Шилдэй занги
Хүнэй гарта оробо
Хара түмэр хаадагни
Хадын оёрто жэбэрэбэ
Харахан залуухан Шилдэй занги
Харийнхинай гарта оробо
Арбан сагаан шүдээ
Зууһан зандаа хэбтэхэб
Ара ла буриад нютагаа
Бусаһан шэнди ханахаб*

*Хорин сагаан шүдэээ
Зуухан зандаа хэбтэхэб
Хори Буриад нютагаа
Бусаһан шэнди ханахаб*

Ж.Цолоо, Г.Гантогтох нарын цуглуулсан хэвлэлд бэлтгэснийг Антоон Мостаэргын ивээн тэтгэж хэвлүүлсэн “Арван гурван ноёдын дуун” (буриад ардын аман зохиолын цоморлог) номд ийм нэг хувилбар байна:

*Гунан гунан харахамни
Гурван хүлдөө шүдэртэй
Гүрмэлзэгшэ Шэлдэй
Гурбан давхар сэрэг соо
Дүнэн дүнэн харахамни
Дүрбэн хүлдөө шүдэртэй
Дүрмэлзэгшэ Шэлдэй
Дүрбэн давхар сэрэг соо
Үхэрэйнгээ олондо
Үндэр шэбээ бодхолойб
Үлиэрэйнгээ ехэдэ
Үргэн хили алхалайб
Хонинойгоо олондо
Хото шэбээ бодхолойб
Холшоройгоо ехэдэ
Хуулийн хили алхалайб
Тэмээнэйгээ олондо
Тэнюү шэбээ бодхолойб
Тэнэгэйнгээ ехэдэ
Танюүһтата хили алхалайб
Алаг эрээн нюдэмни
Аяга соогоо шэрьехэнэ
Алда хара гээзэгэмни
Гүрлээтээ хагдархана
Дурагар хар нюдэмни
Долон соогоо шэрьехэнэ
Дэлим хара гээзэгэмни
Томолёотоёо хосорхоно
Мүндэгэрхэн толгоймни
Мухарин ошон хэбтэхэ лэ
Манжу муухай дайсан
Манхагнан ошин үдъхэлхэл
Хара дурагар нюдэмни
Хараһан зандаа хэбтэхэ лэ
Хайратай баатар бээмни
Хара шоройдо дарагдаха ла
Эрээн хара нюдэмни
Энеэбхилэһэн зандаа хэбтэхэ лэ
Эдир баатар бээмни*

Энэ газарта хосорохо ло

Ийм олон хувилбараар бүх буриад зоны 300-аад жил дуулсаар ирсэн энэ баатарлаг бөгөөд эмгэнэлт дууны утга агуулгыг молхи миний бие тайлбарлахыг оролдох хэрэгцээ шаардлага байхгүй. Харин Орос гүрэнд хүчээр эзлэгдсэн Монгол гүрний умард хэсгийн (одоо Буриад хэмээн нэрлэгдэх болсон) нүүдэлчин эсгий туургатанд ямар хувь тавилан тохиосныг цухас дурдахыг оролдоё.

Монгол хэмээх ертөнцөөс таслагдан оросын төр захиргаа, цэргийн тогтолцооны эрхшээлд орсон олон монгол овог аймгуудын аж байдал, соёл, зан заншилд оросын нөлөөгөөр тодорхой өөрчлөлтүүд гарснаар барахгүй тэр олон монгол аймгууд нэгдэн нягтарч буриад хэмээх нэг угсаатан бүрэлдэн тогтох үйл явц эхэлсэн сайн талтай ч түүнд өнөөх оросын нөлөө буюу миний бодлоор орос хэмээх их үндэстний дээрэнгүй үзэл, хүчин мөхөс бага үндэстэн ястнуудыг хүчээр уусгах бодлого ямагт саад бэрхшээл учруулсаар иржээ.

Хаант засгийн үед засаг захиргааныхаа овгийн тогтолцоог устгуулж, оросын газрын эздийн эрхшээлд орон, малын бэлчээр, хадлангийн газаргүй болсон малчид “бичигт цагаан чулууны цаана гарч, хүнээ хүн болгох, малаа мал болгохоор”¹¹ өмнө зүг рүү хил даван нүүж эхэлжээ. Тийнхүү дүрвэж нүүгчдийн үр сад нарын нэгээхэн хэсэг нь та бид нар байна.

Хаант засгийг түлхэн унагасан Ленин тэргүүтэй большевикуудын засаглалын үед Буриадуудыг Автономит муж¹² болгоод дараа нь бүр Автономит Буриад Улс¹³ болгосныг баярлан тэмдэглүүштэй. Ийнхүү улс хэмээх статустай болж урам зориг сэргэсэн буриадын ард түмэн уламжлалт соёл, аж байдал, заншлаа сэргээн хөгжүүлэх их ажилд шаламгайлан оржээ. Үүний ганц жишээ хэлэхэд Буриад улсын дотор буриад-монгол хэл, орос хэл хоёр тэгш эрхтэй байсан тул буриад аймаг сумдад бүх албан хэргийг буриад хэлээр, монгол бичгээр хөтөлж байв.

1926 онд хэл соёлоо хөгжүүлэх асуудлаар тус улсын хэмжээний анхдугаар зөвлөлгөөн болж, Монгол улсын Судар бичгийн хүрээлэнтэй хамтран монгол бичгийн хэлний нэгдмэл зөв бичих дүрэм, нэр томъёо боловсруулах төлөвлөгөө баталсан байна. Энэ үеэр буриадын сэхээтэн мэргэд олноор төрөн гарч, хэл соёлоо хөгжүүлэх хэрэгт ихээхэн амжилт олж байсныг тоочоод баршгүй. Гэтэл Сталины үеийн хууль бус, хүний ёсноос гадуур үйл ажиллагаа эхэлснээр тэр сайхан эхлэл буюу сэргэн мандалт тасарсан нь туйлын харамсалтай.

Юуны өмнө буриад-монголчуудын мянгаад жилийн түүхтэй бичгийг устгаснаар их хэлмэгдүүлэлт эхэлсэн гэж болно. 1931 онд буриад овог аймгуудыг нэгтгэж байсан сонгодог монгол бичгийг халж, оронд нь эхлээд латин, дараа нь кирилл бичиг хэрэглэх болсон явдал ард түмний нэгдмэл байдал, хэл соёлын хөгжилд ихээхэн хор хохирол учруулав.

1937 онд нэгдмэл Буриад улсыг гурав хувааж, засаг захиргаа, нутаг дэвсгэр, соёл, аж байдлын нэгдмэл байдлыг алдагдуулав. Энэ тухай доктор Ш.Б.Чимитдоржиев бичихдээ: “Манай ороной түүхэдэ 1937 он шимэрүүн хатуу, хуули буса юүмэнүүдээр дүүрэн гажа буруу он байгаа. Агуу ехэ ударидагша (Сталиныг хэлжээ-Д.Б.), тэрэниие тойроһон холо харасагүй удамаршад манай дундаһаа хэдэн зуун мянган ухаатай бэрхэ хүбүүдыемнай хоролон абажа, ГУЛАГ-ай хүйтэн бараагуудга абаашажа хаяһан, зобооһон, хюдаһан гээжэ. Ямар бэрхэ, һайн хүбүүд, басагаднай халааб!”

1937 онд хара ханаата хүнүүдэй ханаашалгаар манай Буриад-Монголой республика гурбан хэсэг боложо таһалагдаһан, буриад-монгол арад нэгэдэлээ алдаһан гэжэ... Тэрэ үеһөө эхилэн манай буриад-монгол арад алишье талаараа һуларжа эхилээ. Нэн түрүүн соёл болбосоролнай, хэлэ бэшэгнай хохиролд ороо. Литературна хэлэн хүгжэхээс болёо...”¹³ гэжээ.

Нэг хүнийг тахин шүтэх үе дуусч, Хрущевийн дулаарлын үе эхэлсэн гэх боловч Буриадын ард түмэнд халгаатай үйл явдлууд үргэлжилсээр байв. “1958 оны зун Н.Хрущев нэг өдөр учиргүй уурлаад (энэ нь НҮБ-д БНМАУ элсэх гэхэд гурав хуваагдсан гээд халгаахгүй байсантай холбоотой гэдэг.-Д.Б.) Буриад-монгол гэдэг нэрийн сүүлийн хэсгийг авч хая гэдэг ээлжит “мэргэн зарлиг” айлдсаны дагуу юм мэдэхгүй манай дуулгавартай дарга нар 1958 оны 7 сарын 7-нд “Монгол” гэдэг үгийг хассан тогтоол гаргасан юм даг”¹⁵ гэж Балдоржийн Пунцаг бичсэн байна.

Яг энэ үеэр, тэмээ бол нүүдэлчин монголчуудын бэлгэ тэмдэг мөн гэж ихэд мэдэмхийрэн дүгнээд буриад зоны эдэлж хэрэглэж байсан тэмээг хоморголон устгасан гажиг явдал бий. Үүний дараа 1973 онд Буриад улсад цэцэрлэгээс эхлээд бүх сургуульд буриад хэлээр хичээл заахыг хориглосон. Үүний улмаас олон зуун буриад хэлний багш ажилгүй болж, буриад хэлээ мэдэхгүй бүхэл бүтэн үе өсөж бий болжээ. Энэ бол Брежнев хэмээх бас нэг “мэргэн удирдагчийн” учруулсан гай.

Ардчилал, даяарчлалын өнөө үеийн гол зарчим бол бусдын эрхийг хүндэтгэх явдал гэж үздэг. Гэтэл Оросын удирдагчид яагаад энэ зарчмыг хүндэтгэхгүй бусдыг эрхийг хөсөрдүүлсээр байна вэ?! Өмнөх удирдагч нарынхаа алдаа завхралыг засах гэж Горбачев өөрчлөлт шинэчлэлтийг эхлүүлсэн, бололцооныхоо хирээр зассан. Гэтэл түүнийг зайлуулаад гарч ирсэн Сталинч товарищууд, жишээ нь Чеченийн өөртөө засах эрхийг хөсөрдүүлж, чеченчүүдийг хүйс тэмтрэх бодлого явуулсан., явуулсаар байна. Бас буриад зоны өөртөө засан тохинох эрхийг үл хүндэтгэн Буриадын хоёрын хоёр автономит тойргийг КГБ-ын тагнуул товарищ Путин устгачихлаа. Халам халаг!! Үлдээд байгаа ганц Буриад улсад маань гар бүү хүрэг гэж хөх мөнх тэнгэртээ залбирья!

Олон зуун жилийн турш ийм хүнд бэрх сорилт, басамжлал, доромжлолыг нэр төртэй даван туулж, буриад-монгол гэдэг үндэс язгуураа, хэл соёлоо, зан заншлаа хадгалан өдий хүрсэн Буриадын эрэлхэг зоригтой, тэсвэр хатуужилтай, өндөр их соёлтой ард түмэн өв соёлоо, хэрвээ өнөөх товарищууд элдвээр гоочлоод байхгүй бол, сэргээн мандуулах нь лавтай.

“Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ногоорох” цаг ирнэ ээ. Бурхан үз ээ.

Зүүлт

1. Мунгал-Монголыг тэр үеийн бичиг баримтад мугал, мунгал гэх мэтээр бичдэг байсан нь тэр бичиг үйлдэгчид бичиг номд маруухан байсантай холбоотой байж мэднэ.
2. Брацкий-Ангарын эхин хавийн эхирис, булгад мэтийн монгол овог аймгуудыг “брацк, брат, братские люди” гэж нэрлэж байв.
3. Острог-шивээ, бэхлэлт, Оросууд Ангар мөрний эхнээс аваад Эрхүү гол, Баргажин, Сэлэнгэ, Үдэ гол гэх мэт газарт хэдэн арван острог байгуулан дорно зүг ахисаар бүр зүүн хязгаарын Нэрчүү гол дээр острог байгуулжээ.
4. Воевод-мужийн ноён, мужийн цэргийн захирагч

5. Сажен-алд, дэлэмтэй дүйх уртын хэмжээ
6. Инородец-орос бус харь төрлийн гэсэн утгатай гадуурхсан өнгө аястай үг
7. Нерчинский договор-Большая Советская энциклопедия. XVII боть.
8. Кяхтинский договор-мөн тэнд XIV боть.
9. Засуул-Оросын хасаг цэргийн есаул гэдэг цолын уугуул дуудлага нь
10. Тэмдэг тавьсан “бичигт цагаан чулуу” хаана байгаа нь тодорхойгүй. Хилийн шугам болгохоор сонгосон газарт тэмдэг тавьсан бол ганц газар тавиагүй байх ёстой. Хэрвээ тийм аваас “бичигт цагаан чулуу”-ны нэг нь Улзын голын хойт биед орших Доргон толгойн оройд байгаа байх.
11. 1921 оны хавар Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын бүрэлдэхүүнд Автономит Буриад-монгол муж байгуулагджээ. Түүнд нийт 110000 хүн амтай Ага, Баргажин, Хори, Чикой (Сүх гол) аймгууд багтаж байв. Мөн тэр жилийн 10-р сард ЗСБНХОУ-ын бүрэлдэхүүнд хоёр дахь 1921 оны хавар Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын бүрэлдэхүүнд Автономит Буриад-монгол муж байгуулагдав. Түүнд багтсан Түнхэн, Бохан, Алайр, Эхирид-Булгад, Сэлэнгэ аймгуудын нийт 185 гаруй мянган хүн амын 70 % нь буриад байв.
12. 1922 онд иргэний дайн дуусч, АДБНУ-ыг татан буулгаад ЗСБНХОУ-д нэгтгэсний дараа Буриадын ард түмний хүсэлтээр 2 автономит мужийг нэгтгэн Зөвлөлт Социалист Автономит Буриад Монгол Улс байгуулах зарлигийг ЗСБНХОУ-ын Төвийн Гүйцэтгэх Хороо 1923 оны 5-р сарын 30-ны өдөр гаргажээ. Түүнд Түнхэн, Бохан, Алайр, Эхирид-Булгад, Хори, Троицкосавск, Баргажин, Ага аймгууд, Дээд Үдэ үезд багтаж байв. Аймгууд хошуудад, үезд волостид хуваагдаж байв. Буриад улсын Засгийн газар, гэгээрэл, эрүүл мэнд, хууль зүй, дотоод явдал, газар тариалан-хөдөө аж ахуй сангийн яамд байгуулагдав.
13. “Как исчезла единая Бурят-Монголия” (1937 и 1958), Улан-Үдэ, 2004-“Нэгдмэл Буриад-монгол улсыг хуваасан нь”, нүүр 112.
14. Мөн тэнд, нүүр 33.
15. “Бурятия” сонин 1997-03-17.
16. КГБ-Улсыг аюулаас хамгаалах хороо, манайхаар Дотоод явдлын яам.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

*Хагшууд Шарайд Г.Батцэрэн
ОХУ-ын Буриад Улсын
Урлагийн гавьяат зүтгэлтэн
СВИС-ийн багш, доктор /Ph. D /,
дэд профессор*

НЭРЬЕЛЭГ

/Буриад ардын дуут бүжгийн уламжлал/

Буриад зон дуут бүжгээр маш баялаг уламжлалтай билээ. Ардын дуу тухайн ард түмний зан заншил, ахуй, хэл, газар зүйн байрлал зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөгөөр бүтдэг. Буриад зоны дунд зохиогддог “Галын наадам” нь түүдэг гал тойрон “Ёохор”, “Ээрэмшэлгэ”, “Хатар”, “Нэрьелгэ” зэрэг дуут бүжиг бүжин дуулдаг уламжлалтай билээ.

Эрт цагт Галын наадам хийхдээ хоёр хэсэг түүдэг асаан галын хурц гэрэлд тойрон зогссон залуусаас хэн нэг нь эхэлж дуулахыг шийдэж ядан байтал хэн нэгэн эмэгтэй:

Галые манайхи носоохо
Гайхамшигтай гэлсэгшэ
Ганса нэгээр дуулаха
Эшэртэй гэлсэгшэ

гэж гоцлон дуулахад хүрээлэн зогсогсод залган авч буриад бүжгийн дууны түгээмэл дахилт болох

“Айхор, яахор, яахоръя

“Яахоржэ байжэ наадъяа”

гэсэн үгээр дуулан бүжиглэдэг. Тэгэхдээ эхлээд хоёр басгад, нэг хүбүүнийг дундаа хийн гал тойрон бүжиглэж дуулж наадах ба сүүлдээ нийт залуус хоёр хэсэг болон хүрээлж, гар гараасаа барилцаад нар зөв тойрон найган ганхан, дуулан бүжиглэцгээдэг.

Энэ үед дуулах дууг “Хатарай” буюу “Нааданай дуу”, “Нэръяелгын дуун” гэж нэрлэдэг. Эдгээр дууг бүжгийн хөдөлгөөний айзам хэмнэлийг зохицуулах зориулалттайн зэрэгцээ Галын наадамд оролцогсдын сэтгэл санааг илэрхийлэх үүрэгтэй. Тэгэхдээ бүр эртний үед аялгууны зориулалттай саланги тусгай үгсийн давтамж байснаа үгийн урлагийн шинж нь ихсэн хөгжсөн бизээ.

Хуримлах ёсонд бэрийг үдэх, Галын наадамын үед “Ээрэмшэлгэ”, “Нэръяелэг” зэрэг бүжгүүдэд тус тусад нь зориулсан дуу дуулдаг. Өөрөөр хэлбэл эл хоёр бүжгийн хослол байдаг боловч “Нэръяелэг” голлодог. Нэръяелэг бүжиг нь “Ёохор”, “Ээрэмшэлгэ” бүжгийн хэмнэлээс нилээд удаавтар, намуун хөдөлгөөнтэй, найган бүжих бүжиг бөгөөд үг дан нь тохирсон “Баруун өндөр ууланд хүү-өөг” гэсэн намуун дөлгөөн айзамтай шүлэг байдаг.

Нэръяелгийн бүжгийн үед дуулах дуу нь Ёохор, Ээрэмшэлгэ зэрэг бүжгийн дуунаасаа эрт цагт цөөвтөр байснаа орчин цагт бүжгийн хэмнэлд тохирсон олон дууг дуулах болжээ.

Буриадын аман зохиол судлаач, эрдэмтэн Д.С.Дугаров “Бурятские народные песни” бүтээлдээ 1961 онд Буриад нутгаас “Нэръяен” гэдэг нэрийн дор нилээд хэдэн дуу бичиж авсан тухайгаа дурьдаад эл үгийг “Нэръяехэ” – “Поднимать шум, гремет” үгчилэн орчуулаад “Веселится” гэж утгачилан тайлбарласан байдаг. Д.С.Дугаровын тайлбарласнаар Ниргэх буюу Нэръяехэ гэдэг нь ниргэн нижигнэн хөл нийлүүлж, хөгжилдөн бүжиглэх гэсэн утгатай үг болно. Галын наадамд хөгжилдөн бүжиглэхдээ залуус эрэгтэй эмэгтэйгээрээ ялгаран талцан дуулах дуу, нийтээрээ хамтран найган бүжих үеийн дуу гэж байдаг. Тухайлбал:

Набтагар дээр гарч

Наран гартал бүжиглэе

Намжир бардам хүбүүдые

Номхортол бүжиглэе.... гэж басгадуудай дуулахад хүбүүд:

Тэбхэр сагаан одоной

Тэгшэртэлни наадъяа

Тэнэг бардам басгадаа

Тэмтэртэл нь наадъяа... гэж талцан бүжиглэж байхдаа харилцан мэтгэлцэн дуулж байсны ул мөр байгаа бол:

Баруун өндөр ууланд хүү-өөг

Өарын тухай шилүүс хүү-өөг

Бас л цаана нь харахад хүү-өөг

Баглагар зандан шиниус хүү-өөг гэх мэтээр дуулдаг эл дууг нийтээр нэгдэн найган бүжиглэхдээ дуулдаг байжээ. Эдгээр бадгийг ажиглахад тухайн үед хийх бүжгийн байдалтай дууны аяны айзам, хэмнэл зохицож байсан байдал харагдаж байна

Тухайлбал:

Эрэгтэй, эмэгтэйгээрээ талцан харилцан мэтгэлцэж дуулах дээрхи дууг хурдан хөдөлгөөнт бүжгийн үед дуулж болох бол сүүлийн дуу удаан хөдөлгөөнтэй найган бүжих бүжгийн хөдөлгөөнд зохицсон нь илт байна.

Мөн /ээ-хөөг, хүү-өөг/ хэмээн бөөгийн яруу найргийн сүүл холбох аргыг ашиглан зохиосон энэ дуу Нэръялгын дууны нилээд эрт үед хамаарах нь лавтай байна. Эрдэмтэн Д.С.Дугаров Нэръялгыг буриад хөгжим дууны нэн эртний төрөл зүйл ба агуулгаараа эртний эцгийн эрхт овогт нийгмийн анчин аймгийн ертөнцийг үзэх үзлийг тусган илэрхийлжээ тэмдэглэсэн байдаг.

Харганын найгалтаар найгая
Хандагайн хатаралтаар хатаряа
Бургааһанай найгалтаар найгая

Бугын хатараар хатаряа... гэх зэргээр өгүүлэн буй эл дуут бүжиг анчин овог аймгийн дунд үүссэн байж болох юм.

Буриадын аман зохиол судлаач, эрдэмтэн М.Н.Хангалов “Хатар” бүжгийн хөдөлгөөнийг Монголчуудын ан агнах үеийн ёс журамтай харьцуулхаад “Энэ бүжиг бол эртний үеийн нийтийн, ан зээгт авын ёс журмыг үйл хөдлөлөөр хуулбарлан тусгасан”... болохыг тэмдэглэсэн байдаг.

Тэгвэл бүжигт ан агнуурыг үйл хөдлөлөөр дүрслэх явдал нь эрт үед их ав хоморгын өмнөх дасгал сургууль байсан төдийгүй ангийн олз омог нэмэгдүүлэх зориулалттай зан үйлийн чанартай үйл хөдлөл байснаа хөдөлгөөний урлагийн шинж нь дэвжин хөгжсөн бизээ.

“Монголын Нууц Товчоо”-ны 117-р зүйлд Онон мөрний Хархонаг-ийн хөндийд Хотола хаан өргөмжлөөд Хархонаг-ийн саглагар модны дор “Хабиргата хаулаха, эбүдүг-тэ үлхэг болитала дэвсэн бүжиглэж хуримлав. Монгол-ун жиргаланг дэбсэн хуримлан жиргаха бүлээ” хэмээн тэмдэглэгдэн үлджээ. МНТ-ны зарим галиг эхэд /Хабиргата хаулаха, эбүдүг-тэ үлхэг болитала дэбсэбэ/ гэдгийг зориут хашилтанд бичсэн байдаг нь зүй ёсоор анхаарал татаж байна.

Эртний Монголчууд саглагар модыг зан үйлийн зориулалттайгаар шүтэн түүнийг тойрон янз бүрийн тайлга, ёслол үйлдэн бүжиглэж нааддаг байжээ.

МНТ-ны 117-р зүйлд “...одоо бид амраглан явъя гэж Тэмүжин Мэргэдэйн Тогтоогаас олзолж авсан алтан бүсээ Жамуха андад бүслүүлж, Тогтоогийн эрмэг халиуныг Жамуха андад унуулав. Жамуха хариуд нь Увас Мэргидийн Дайр-Үсүн-ээс олзолж авсан алтан бүсээ Тэмүжинд бүслүүлж, Дайр-Үсүний эвэрт ишгэн цагаан морийг Тэмүжинд унуулав. Ийнхүү анд боллоцоод:

Хорхунаг Жубурын хөндийд
Хулдгар хуны өвөрт
Саглагар модны дор
Сайхан хурим үйлдэж
Сайтар бүжиглэн жаргаж
Санаа сэтгэл нэгдэж
Сайн нөхөд болоод
Шөнө нэгэн хөнжилд орж хонох бүлээ

Дээр өгүүлж буй бүжиг бол Буриад ардын “Хатар”, “Ээрэмшээлгэ” бүжигтэй агаар нэг байна. Мөн эртний гарлаараа үүнтэй шууд холбогдох “Нэръялгэ”:

Хажуу ла зүлэг ногооёе
Халцартал нь наадъя

Хажуугийнхаа ханжуургыг
Хангир янгир наадъя
Хартай бардам хүбүүдыг
Харштал нь наадъя
 Үзүүр зүлэг ногооеы
 Үлтиртэл нь наадъя
 Үхэнэйнгээ даруулгыс
 Хангинатал нь наадъя
Үндэр дээрэ гаражэ
Үүрэй сайтал наадъя
Үе хултай хүбүүдые
Үгы болтол наадъя
Набтар дээрэ гаражэ
Наран гартал наадъя
 Намжир бардам хүбүүдые
 Номхортоло наадъя
 Солмон соохор одоной
 Сохо дээрэ гартал наадъя
 Собоо бардам басгадые
 Сомсортоло нь наадъя... гэхчилэн дуулдаг билээ.

Эртний Нэръялгын дууны үгийг үзвэл МНТ-ны 57-р, 117-р зүйлд “Монголын жаргалан” болсон “бүжиг хурим”-ын тухай, “Саглагар модны дор, сайхан хурим үйлдэж” сайтар бүжиглэн жарган буй тухай дурьдсантай төстэй байна. Нэръялгын дуу эрт үед зохиогдсон нь эргэлзээгүй байна.

Хажуу зүлэг ногоог халцартал

Үзүүр зүлэг ногоог үлтиртэл...нь наадаж байх тухай эл дуунд өгүүлсэн нь “Хабиргата хаулаха, Эбүдүг-гэ үлхэг болитала дэбсэбэ”-гэй холбоотой байна уу гэдгийг авч үзье.

Тойрон бүжгийн хэлбэр, хөдөлгөөн ижил байна. МНТ-нд үүнийг “Монголын жаргалан нь дэвсэн хуримлан жаргах” гэсэн байхад Буриад ардын дуунд “Үүр цайтал, цолмон цоохор одны цох дээр гартал нааддаг” гэснээрээ бүжгийн зорилго, цаг хугацаа адил байна. Буриадын уг дууны мөр МНТ-нд тэмдэглэгдэн үлдсэн үг хоёрын мөрийн утга, шүлгийн бүтэц, зохиомж адил төдийгүй зарим үг /халцартал/, /үлтиртэл/ наадах гэсэн үгнүүд таарч байгаа нь энэ дуу МНТ-ны Хотоло хаан өргөмжилсэн үеэс эдүгээ хүртэл аман хэлбэрээр хадгалагдаж ирсэн гэх бүрэн үндэстэй байна.

Тухайн үеэс эдүгээ хүртэл дуут бүжгүүд хэрхэн өөрчлөгдөн, эртний Монголчуудын баярын энэхүү хөдөлгөөнт бүжгүүд Буриад ардын урын санд хэрхэн уламжлагдан хадгалагдаж ирсэн бэ гэдгийг судлах зайлшгүй шаардлагатай байна гэдгийг судлаачдад сонордуулахаар энэ сэдвийг сонгон авлаа.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

Балданов А.Л., Орхокова Л.А.
*Усть-Ордын багшанарай мэргэжэл
дээшлүүлгын институт*

ЭРХҮҮГЭЙ ОБЛАСТИЙН УСТЬ-ОРДЫН ОКРУГАЙ НАЦИОНАЛЬНА ПОЛИТИКЫН ХҮГЖЭЛГЭ

Буриад Усть-Ордын округ - олон яхатан хүнүүдтэй нютаг. Округ соомнай 100 гаран ондо ондоо яхатан ажаһуудаг. Тон үндэһэн буриад зон 30%-нь болоно. 2008 онһоо манай буриад округ тус ондоо өөрынгөө ёһо заншал саашаа үргэлжэлүүлхэ эрхэтэй Эрхүүгэй областиин хуби болобо. Мүнөө боложо байһан арад зоной политическэ, экономическэ ажабайдал гүрэнэй национальна политикаһаа дулдыдажа, национальна соел культураяа хүгжөөжэ ба эрдэм һуралсалаа урагшань ябуулжа байна. Олон яхатанай зон бэе бээдээ нягта холбоотойгоор хандана. Шажанһаа гү, али национальна асуудалнуудһаа болон элдэб ушарнууд болоногүй.

Харин мүнөө үедэ буриад зон өөрынгөө хэлэ бэшэгээ дүүрэн хэрэглэнэгүй. Тиимэһээ шиидхэгдээгүй асуудалнууд гаражал байдаг. Иимэ юумэн юундэ болоноб гэхэдэ, гүрэнэймнай хэлэн ород хэлэн байна, үндэһэн хэлэнэй хүгжэхэ үйлэнүүд үсөөн байна. һургуулинуудаар хэлэн үзэгдөөшье һаа, бүхы ажа байдалдаа буриад зон хэлэеэ һайса хэрэглэнэгүй. Гүрэн хадаа ехээр анхаралаа табижа, һанаһан хэрэгээ дууһан бүтээнэгүй. Бүхы юумэн ород хэлэн дээрэ болошоно. Тиигээшье һаа, манай округ соо буриад соел культура хүгжэжэл байдаг. һургуулинууд элдэб янзын ажал ябуулжал байдаг. «Сагаалган» гэжэ һайндэрһээ эхилээд, жэл соо олон

һайндэрнүүд болодог. Бишыхан үхибүүдһээ эхилээд, томо хүнүүд хабаадалсажа, ажалаа хэдэг. Тиибэшье, округ соомнай ехэл хүдэлмэри ябуулагдаха еһотой гэжэ һанагдана. Энэ хадаа юум бэ гэхэдэ ехэхэн округ доторхи программа зохогдохо еһотой.

Нэгэдэхинь хадаа, буряад зон өөһэд хоорондоо өөрынгөө хэлэн дээрэ үргэнөөр хөөрэлдэхэ еһотой. Хүдөө нютагаар зон хөөрэлдөөшье хадаа, округой центртэ ерэхэдэ ородоор дуугаралдашадаг, городто ошоходоо, ородоор хөөрэлдэхөө оролдошодог юм. Юундэб гэхэдэ ганса буряад зон ажаһууна бэшэ, харин бэшэ бэшэ яһатан олон. Тиибэшье, манай һанахада, үшөө үргэнөөр суглаа хуралнуудые хэжэл байхада үлүү болохогүй. Багшанарай элдэб янзын форумууд, хүүгэдэй олимпиаданууд, шэнжэлэлгын ябуулганууд, соел культурын ба муниципальна бүридэлнүүдэй хүдэлмэри хэлэ хүгжөөлгын аргууд болоно. Тиимэһээ округһоо гадна Буряад республикатай, Монгол оронтой, Хитадтай холбоотой байгаа һаа, ехэ һонин байха гэжэ тоолонобди. Дүй дүршлээрөө хубаалдаха, бэе бээдэе ошолсохо, ерэлсэхэ, хүүгэдэй делегацинуудые ябуулжа, танилсуулжа, хэлсээ холбоо бүридхэжэ байгаа һаа, ямар гое байха гээшэб. Иимэ конференцинуудые үнгэргэжэ байхада, хэлэн уран болохо, эб найрамдал хүсэ шадалтай болохо.

Хоёрдохоор, өөрынгөө буряад хэлэндэ һайнаар һургаха еһотойбди. Бүхы һуралсалай ажал ябуулга, библиотекэнүүдэй фонднуудые ехэ бололго, буряад хэлэн дээрэ уран зохоолнуудые хэблэлгэ, бишыхан үхибүүдэй ба литературна зохоолнуудые хэблэлгэ гэхэ мэтэ хүдэлмэри үргэнөөр хэгдэхэ еһотой юм.

Тиибэл, багшанарай ба бэшэшье ажалшадай хүдэлмэри һайжаруулжа, өөрынгөө үндэһэн хэлэн дээрэ ажалаа ябуулаа һаа, хэлэн хүгжэжэл байха байна.

Гурбадахяар, буряад зон өөрынгөө еһо заншал, шажанаа алдангүй, саашань хүгжөөхые харана. Энэ талаар округ соо ехэхэн хүдэлмэри ябуулагдана. Усть-Ордаманнай Гүрэнэй ансамбль «Талын аялганууд», Уран гарай центр, Арадай уран гүйсэдхэлгын центр, «Уран зурагай һургуули», «Хүгжэмэй һургуули», Хүүгэдэй уран гарай центр гэгшэд бии. Эдэмнай өөрын еһо заншал сахилга, хэлэн ба бэшэгээ үзэлгэ, хубсаһа хунараа шэнжэлэлгэ, эрдэмээ шудалалга, искусство үзэлгэ, шажанай ябуулга, спорт ба соел культурын ажал гэжэ хубаарна. Эдэ бүгэдээ саашань хүгжөөхын түлөө, хүдөө нютагай һургуулинууд ба соелой байшангуудай хүдэлмэришэд ехэ үүргэ дүүргэдэг юм. өөрынгөө хүдөө нютагһаа ехэ хүдэлмэри ябуулхаһаа гадна, аймагай ба округой конкурсуудта хабаадалсадаг. Тиигэжэ өөрынгөө заншал алдангүй ябахаа эрмэлзэдэг. Тиибэшье, баһа шэнжэлэлгэнүүд хэрэгтэй. һайндэрнүүдые бэлэдхэхэ, үхибүүдэ бишыханһаа уран хүгжэлгэдэ һургаха, һургуулинуудтаа үшөө үргэнөөр үзэхэ ябуулганууд баһал сэнтэй юм. Спортивна ба национальна нааданууд уран һайханай – театральна, хореографическа, фольклорно ажал ябуулга баһал ехэ түсэб эринэ.

Дүрбэдэхээр, эдэ бүгэдэ ажалнуудые округ соо хүнүүдэй өөһэд дундаа зохидоор хандаха асуудалнуудые шийдэхэ еһотой. Тиигэхын тула, нэгэ хэды саг болоод лэ, олон яһатанай хандалгые үзэжэ, зарим ажалаа хамта сугтаа ябуулхые хараха гэжэ һанагдана, үгы хадаа ондоо яһатанай дуратай ажал ябуулгада туһалжа, саашаа хамта хүгжэжэ ябаха еһотой.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

*Бодонгууд Д.Буджав
Өндөр настан,
судлаач*

ХОРЬ БУРИАДЫН УГ ГАРЛЫН ТУХАЙ

Эртний дундад зууны үе, тухайлбал, VI зууны дунд үеэс манай эриний II мянган жилийн эхэн хүртэл Байгал далайн эрэг хавийн нутаг хоёр талаараа курыхан, байырк /байегт/ турк угсаатанд эзлэгдсэн байжээ. Эднүүс бичиг үсэгтэй, янз бүрийн гар урлал хөгжүүлэн амьдарч байсан хэдий ч аж ахуйн үндэс нь хагас нүүдлийн мал аж ахуй байв.

Чингэс хааны үед Баргажин Түхэм гэдэг нэрээр Байгалын эргэн тойрны нутаг дэвсгэрийг тэмдэглэсэн төдийгүй турк хэлтэй курыханууд дайжин явсны дараа ойн монголчуудын угсаатан нүүдэллэн ирж суурьшсан байдаг. 1201 оны үед Баргажин Түхэм гэдэг омог угсаатан үүсч бий болсон тэгээд нэгдсэн улсад захирагдах болсон гэж бий. Харин буриадын ард түмний түүхийг зөвхөн XVI зуунаас эхэлсэн гэж түүхийн ухааны доктор Б.Р.Зоригтуев үзсэн байдаг. (1)

XVII зууны эхэнд Байгал хавийн үндсэн угсаатан дараах байдлаар суурьшин нутаглаж байжээ. Ангар, түүний булан тохойгоор Булагадууд, Эрхүү, Хито, Цагаан голын бараан, зүүн, өмнө хөндийгөөр нь хонгодорууд суурьшсан байна. Лена мөрний дээд хэсгээр эхирит угсаатан, Байгалын өмнөх Үд голоор хорьчууд, Хилго голоос зүүн тийш Халхын нутаг дэвсгэр эхэлж байжээ.

Хорьчууд нь бүх буриад угсаатны нэгэн адил нүүдлийн мал аж ахуй, ан гөрөөг эрхлэн, амьдралын хэв маяг тогтворгүй, нутаг байнга сэлгэн нааш, цаашаа нүүдэллэн амьдарч байжээ. Энэ нь их төлөв бэлчээр, ан гөрөө хийх нөхцлөөс болж хоорондоо маргах, албатууд ам зөрөлдөх асуудал гардаг байсантай холбодог байв.

Хэрэв хорьчууд эрт цагт, дундад зууны эхээр Бйаагл орчмоор идээшин нутаглаж байсан бол дундад зууны сүүлээр Байгалын чанадад гарч нутаглах болжээ. Гэхдээ XVI зууны хоёрдугаар хагаст хорь-буриадууд уугуул эх нутагтаа амьдрахаар буцаж ирсэн гэж тэмдэглэгдсэн байдаг ажээ. (2)

Хорь угсаатны идээшиж суурьшсан газар нутагтай холбогдуулан ард түмний дунд өргөн тархсан Заян Наваа-гийн тухай нэгэн домог дээр тогтон өгүүлье. Зарим судлаачдын үзэж байгаагаар Заян Наваа нутаг Төвдийн өмнөд хэсгийн Сүмбэр уулын районд Их Гималайн салбар ууланд байдаг, тэнд хорийн эртний нутаг бий гэдэг. Зарим нь алс холын Ирак дахь /Мосул хотын районд/ Нава-гийн нутаг дэвсгэр газрыг хорийнхны өлгий нутаг гэж үзэж буйгаа таамаглан гаргасан байгаа. Гэхдээ энэ бүхэн шинжлэх ухааны баттай нотолгоо аваагүй байгаа билээ. Эл бүхнээс үзэхэд хорьчууд нэг газраас нөгөө рүү, тэгэх тусмаа алс хол газарт хүртэл байнга нүүдэл суудал хийж байсан гэдэг нь харагддаг. XVI-XVII зуунд хорийнхны нүүдэл, нутагшлын байдлыг Буриадын он тооллын бичигт үндсэндээ үнэн зөв тусгаж чадсан, тухайлбал, XVII зууны эхэн үеэс аваад тэд Үд, Хилго, Ана, Худан, Курба, Байгал хавийн Хударийн тал, мөн Ингэда, Үлирэнгэ, Тур, Ага голын дагуу, Аргун, Дорнод Байгалын чанад хүртэл тарж тогтвор суурьшилтай нутаглах болсон гэж тэмдэглэсэн байна. (3)

Хорийнхны эрхэлдэг үндсэн ажил бусад буриад овогтны нэгэн адил мал аж ахуй байсан. Адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ маллана. Буриадууд эрт цагт дундад зууны үед гахай маллаж байсныг аман зохиолын зарим материал, археологийн олдвор зүйлүүд гэрчилдэг гэдэг. (4) Мал аж ахуй нь малыг бэлчээрээр маллах аргад голлон суурилсан байдаг. Энэ нь олон зууны туршлагаар боловсруулагдаж үүссэн арга технологи гэж болно. Нүүдэл суудлыг жилд хэд хэдэн удаа хийдэг байсан ба эргэлтийн тоо хэмжээ нь малын тоо толгой, уг газар орны байгаль цаг уурын нөхцлөөр тодорхойлогдоно. Өвөлжөөндөө ойрхон, усны эх үүсвэртэй, хадлан цавчлан авах боломжтой газраа малын хөлөөс хамгаалан өвс тэжээл авахад зориулж ашигладаг байв. Тэд эрт цагийн усжуулалтын систем өнөөдрийг хүртэл хадгалагдаж ирсэн байдаг.

XVII зуунд хорьчууд бусад буриад угсаатны нэгэн адил Орос улсад харьяалалтай болсон ба харин буриадын Орост нэгдсэн баримт материал нь төгс төгөлдөр буй байгаа юм. Энэ үйл явц нарийн төвөгтэй, зөрчилтэй асуудлын нэг гэж бичигдэх болж байна. Зарим газар нутагт буриад, оросын холбоо харилцаа нь намдуу тайван шинжтэй байсан бол бусад газруудад хэрүүл сөргөлдөөн, зэвсэгт мөргөлдөөнд хүрч байсныг баримт материал гэрчилдэг юм. Буриадууд эд хөрөнгийн албан татвар, оросын эрх мэдэлд орохоос татгалзаж, зарим газарт оросын нутгийн цэргийн ахлагч, мөнгө хүүлэгчид хааны засаг захиргааны нэрээр зүй бус ааш авир гаргаж байсныг эсэргүүцэн тэмцэлдэж байсан мэдээ сэлтүүд эх сурвалж бичгүүдэд тусгагдсан байдаг.

Нутгийн ба мужийн цэргийн ноёд, эрхтэн, дархтаны нэгэн хэргээр буриадууд өөрийн төлөөлөгчдийг муж, нийслэл хот руу илгээж дээд шатны газарт гомдол мэдүүлж байсан байдаг. 1702-1703 онуудад хорь буриадын төлөөлөгчид Москва, Оросын хаан I Пётр хаанд очиж уулзаж байсан нь үүнийг гэрчилнэ. I Пётр хаан хорь буриадуудад үржил шимтэй газар эзэмших эрх олгох зарлиг буулгасан байдаг. Энэ зарлигийн 300 жилийн ойг 2003 онд тэмдэглэсэн билээ.

Хорийн буриадын угийн бичгийг Хоридой мэргэнээс эхэлж бичдэг. Түүний дотор Бабжа баатар, Балжин хатан, Шилдэй - занги нарын нэрийг онцгой хүндэтгэлтэйгээр оруулдаг юм. Хоридой нь Барга баатарын гурав дахь хөвүүн байсан. Хоридой мэргэний гурван эхнэрийн нэг болох Баргажин - гоо бол Бэд улсын сурвалжтаны нэгнийд өсөж өндийсөн эмэгтэй гэдэг. Тэр нь Алан-гоо гэж ганц охиныг төрүүлсэн бүлгээ. Хоридой мэргэний Шаралдай гэдэг эхнэрээс таван хүү төрсөн байдаг. Галзууд, Хуасай, Хүбдүүд, Гушид, Шарайд гэж нэртэй байсан. Хоридой мэргэний нөгөө нэгэн эхнэр болох Нагадайгаас Харгана, Бодонгууд, Худай, Батанай, Цагаан, Халбин гэж зургаан хүү төрсөн байдаг. Эд нар бүгд өөр өөрийн нэрээр отог омог шинээр үүсгэн өсөж өнөржсөн түүхтэй. Тэд өвөг эцэг Барга баатар болон өөрийн эцэг Хоридойн захиа гэрээсийг дагаж 424 онд Байгалын урд эргээс өмнө зүг рүү нүүж Түвд, одоогийн Хятадын Бээжин хотын ойролцоо газар, өмнөдийн дөчин есөн хошуу, хойт халх - Монголын нутгаар амьдарсан гэж түүхлэгддэг. (5)

Хорь... Хоридой ... Хоридой мэргэн, түүний эцэг хөх тэнгэрийн хун шувуун охинтой гэрлэн 11 хүүтэй болсон гэж домоглогддог түүх ч бий.

Хорь буриадын түүх иймэрхүү гайхалтай сонин зүйл олонтой билээ. Хорьчуудыг Азийн хамгийн их нүүдэл хийж амьдарсан нэгэн ястан гэж үзэхэд болно. Хорийнхонтой холбоотой гэхээр домог, өвөг аймаг, газар нутаг янз бүрийн нутаг оронд олноор тааралддаг гэдэг. Хорийн 11 эцгийн төлөөлөл Өвөр Монгол, Халх, Монгол, Халимаг, Төвдөд амьдарч байдаг ажээ. Якутын Саха-д Улуу, Хоролорын гэх олон тооны отог омгийн залгамж зон бий ажээ. Шинэ, Хуучин баргын ихэнх нь өөрсдийгөө Хоридой мэргэнээс эхлэлтэй гэдэг. Усть-Ордын тойрогт Галзууд, Батанай, Халбин, Хангин омгийн ойрхны ахан дүүсийн зон олонтой уулзаж болох ба тэнд Хорёод, Шарайд, Худайн голын хөндий гэж нэртэй суурин газрууд бий ажээ. Агын тойргийн эзэд нь хорьчууд буюу хорийн 8 эцгийн төлөөлөл юм. Манай Монол улсын Дорнод, Хэнтий аймгийн буриад зон Хоридой мэргэний үр сад, тэр хүний удам залгамж болон өнөржиж яваа ард түмэн билээ.

Ашигласан материал

1. Чимитдоржиев Ш. Буриадын түүх бичгүүд ба уг бичгийн тухай. 2000.
2. Краткий путеводитель по памятным местам и достопримечательностям Хижингинскоо района. 2005.
3. Дамдинжав Д. Монголын буриад зон. 2002.
4. Бямбасүрэн Д. Буриад түмний гарал, түүх угсаатны онцлог. УБ.2002.
5. Буриад монголчуудын гарал үүсэл, түүхийн зарим асуудал. Э/ш-ний бага хурлын материалын эмхэтгэл. 2000.
6. Монголын нууц товчоо. Хоёрдах хэвлэл. Уб., 1957.
7. Галсан Т. Буриад язгуур домгийн товчоон. УБ, 1998.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

Шарайд Г.Гантогтох
Буриад Судлалын Академийн
Хэл, зохиолын салбарын эрхлэгч,
МУИС-ийн багш, доктор /Sc.D./,
профессор

БУРИАД ТУУЛЬС ДАХЬ ЗАН ҮЙЛИЙН УЛАМЖЛАЛ

Буриад зон эрт урьд цагаас эхлэн үлгэр туульсыг зохион хайлж, үеэс үед уламжлан иржээ. Буриад ардын туульс цаглашгүй арвин бөгөөд судалгааны хэрэглэгдэхүүн болон судлагдсаар эдүгээ зуу гаруй жил болжээ. Гэсэн хэдий боловч судалж амжаагүй зүйл асар арвин байна. Үүний нэг нь буриад туульс дахь зан үйлийн уламжлал юм. Гэтэл буриад туульс буриад зоны аж төрж ирсэн ёс заншил, зан датгал, хэв суртал, зан үйлийг үе үеэр нь үргэлжлүүлэн өвлөн хадгалж дархалсаар иржээ.

Буриад туульс дахь зан үйлийн уламжлалыг авч үзэхэд төрт ёсны зан үйлийн уламжлал, аж төрөх ёсны зан үйлийн уламжлал, мөргөл залбирлын зан үйлийн уламжлал бүрэн цогцолжээ.

Төрт ёсны зан үйлийн уламжлал. Төрт ёс гэдэг тухайн үндэстэн ястны түүхэнд оршин тогтнож эмхлэн байгуулсан төр засаг, омог овгийн байгуулал, барьж хэрэгжүүлсэн хууль цааз, хэв журам, заншиж тогтсон зан заншил, хүндэтгэж бишрэн дагадаг захирч захирагдах ёс зэргийг агуулсан хүн зоны харилцааны уламжлал шинэчлэл юм.

Төрт ёсны зан үйл нь ёсыг ёслон төрийг төрлөн, уулзаж учран харилцахдаа хэрхэх хийгээд хүндэтгэн найрсах ба нэр хүнд ёс журмаа сахих, ачлал тус, өршөөл нигүүлсэл халамж хайр, гэхсээл цээрлэл тэргүүтнийг агуулсан хүмүүсийн харилцааны соёл юм. Буриад туульсад төрт ёсны уламжлал маш арвин байгаа бөгөөд буриад Жангарын туульд: *Түрэ гэжэ түбхыжэ ёһо гэжэ ёдойжо нууба ха*

(*төр хэмээн төмбийж ёс хэмээн ёмбойж суув гэнэ*) гэж өгүүлжээ. Ёоро Ёгшоолой туульд туулийн баатар Ёоро Ёгшоолой Харалтуу мэргэн хааны охиныг гуйхдаа борвин дээрээ бохилзон, тахим дээрээ тахилзан хүндэтгэн найрсаж байна. Ёоро Ёгшоолой баатар хүнийхээ нэр хүнд, шударга ёс, журмыг сахиж хүнд хүчир нум сумаа тосож угтсан хүнд өгөлгүй, хүргэн хүүгийн ёсыг дагаж морио бариулалгүй, төв шударгын ёсыг дагаж босгон доор хөндлөн хэвтсэн хүнээс жийрхэлгүй дээгүүр нь алхаад, хааны харцнаас далдиралгүй орж ирж байна. Осодор мэргэн туульд хүч бяд муутай амьтдыг хүчтэний савраас аварч хожим ач тусыг нь хүртдэг. Айдуурай мэргэн туульд Агуу ногоон дүүхэй албат зондоо Заха ёһоо харыг, Түрэ ёһоо хахийт гэж чандлан захиж хэлдэг. Алтан шагай хүбүүн туульд: өөрийг нь харваж алсан Ёргоодой мэргэнийг Алтан шагай мэргэн мориныхоо ачаар ахин амилаад байхдаа өршөөн нигүүлсэж мөнхийн усаар амилуулаад анд нөхөд болдог. Ёоро Ёгшоолой туульд: Адуу малдаа эзэн болсон эрэмгий шаламгай мангасын охиныг хайрлан халамжилж их хатнаа болгож авдаг. Аламж мэргэн туульд: Харын ихээр хардаж борын ихээр бордсон Хар, Шар зутан хоёр авгаа гэсгээн цээрлүүлдэг. найдар Буйдар туульд: Хоёр дүүгээ хорлосон харьял гоохон эгчээ морины сүүлнээс чиргүүлж цээрлүүлдэг гэх мэт төрт ёсны зан үйлийн үйлдлийг өгүүлсэн өгүүлэмж гэвэл далай баян.

Буриад ардын баатарлаг туульс дахь зан үйлийн төрт ёсны уламжлалыг мэнд хүндийн, нялхсыг угтах зоог шүүс хүндэтгэлийн, найр наадмын, хурим тойн зан үйл, үг хэллэг хэмээн авч үзэв.

1. Мэнд хүндийн зан үйл, үг хэллэг.

Буриад Гэсэрийн туульд: *“Боржон хангай боһогынь боггүй арюунаар алхаж хаан амараар амаршалба, хатан мэндээр мэндэшэлбэ. Толгой гурбан тэнгэришүүл баруун гараар золгожо бардам хүүрээ хэлсэбэ, ута гараар золгожо уран хүүрээр ушарба”* гэж байдаг нь мэнд хүндийн зан үйл тодорхой, үг хэллэг яруугийн жишээ мөн. Хаан амраар амарчилж, хатан мэндээр мэндчилэх гэдэг төрт ёсны мэндчилгээ. Буриад монгол зоны заншлаар эр хүний амар амгаланг Амар мэндэ хэмээн амарчилж, эмэгтэй хүнийг мэнд ээ гэж мэндчилдэг. Осодор мэргэн туульд: *Хаан мэндээр мэндэшэлбэ хатан дорообоор дорооболбо* гэсэн хэллэг байдаг. Хатны бие лагшин эрүүл мэндийг нь асууж байгаа хэвшмэл хэллэг. Буриад аялгуунд *мэндэ дорообо* гэсэн хоршоо үг байдаг. Дорообо гэдэг нь орос хэлнээс орсон *здоров* гэсэн үгийн буриад дуудлага юм. Ёоро Ёгшоолой туульд: *Үбэр мэргэн эсэгэмни Амар хайн ябана гүт* гэж элбэрэлт мэндчилгээгээр мэндэлдэг. Аламж мэргэн туульд: *Мэтэр гэсэн биеэрээ хадам баабай мэндэ! гэжэ мэндэшэлжэ оробол даа Хадам эхэ мэндэ! гэжэ хадам эхээ мэндэшэлжи байбал даа.* Хэмээн ёст мэндчилгээгээр мэндэлдэг. Буриад зон айлд орохдоо эхэлж бурханд мөргөөд гэрт байгаа хүн бүхнийг нэг бүрчлэн хандаж мэндчилээд, адуу мал сүрэг мэндэ гэж сурдаг заншилтай билээ.

2. Нялхсыг угтах зан үйл, үг хэллэг

Нялхсыг угтах зан үйл нь буриад туульсад төрсөн гарсан тоонотыг нь хэдий цагт, хаана, аль зүгт, ямар газар гэдгийг нарийн дурдаж өгүүлсэн байдаг. Аламж мэргэн туульд: *“Урайни уриндоло урин сагай түрүүндэ лө газаада ехэ далайяа гарим дээрээ түрэбэ, газар ехэ дайдаяа гүрүм дээрээ түрэбэ. Зүүни хаани зүгтэ лэ зүгэй хани дайдада гушин хаани гурьбида гурбан сэеын булууда түрэн гаран яргабала”* (Урьдын урд цагт урин цагийн эхэнд гадаад их далайн эрэгт, газар их

дэлхийн өнцөгт зүүний хааны зүгт, зүгийнхэний тэнд гучинхан толгодын дунд гурван цэгийн бэлчирт төрөн гаран жаргав гэнэ) гэх мэтээр тодорхой заасан. Буриад зон унасан газар, угаасан ус,хүй дарсан хөх чулуугаа тоонот хэмээн нэрлэж насан туршдаа сүслэн санаж явдаг заншилтай. Туульд энэ сэтгэлгээ тусч хаа явсан газраа алдар нэрээ хэлэхдээ төрсөн гарсан тоонотоо дурдан хэлж байдаг.

Хүүхэд олж жирэмсэн боллоо гэхийг туулийн хэллэгээр “*Алтан Шиэбшүүр хатани урда найхан хормойнь үргэлдэжэ байба ла, хойто найхан хормойнь ханжалдажа ороболо. Нууха сагаа ерэхэдэ ороо үргөөр заһажэ дэрэээ үндэрээр табижа Ёолон ёогшон хэбэтэбэ лэ*” гэж Осоодор мэргэн туульд гардаг. Хүүхэд тосож авч байгаа зан үйл “*Үе сагаан үбһэ үтэр түргэн абша үхинэй хүйһэ хүндэбэ. Улаан утаһаар уяба*” гэж Хаан Сагта абхай туульд гардаг.

Буриад туулийн хэллэгээр мэндлэх, төрөх, гарах гэсэн үгийг “*Мүн бэээ бээлбэ мүхэрээн шарай шарайлаба*” гэж хэлнэ. Бас энэ хэллэгийн нөгөө нэгэн утга нь туулийн баатар ямар нэгэн юманд хувилсан байгаад эргэж биедээ тохорвол мөн ингэж хэлдэг.

3. Зоог шүүс хүндэтгэлийн зан үйл, үг хэллэг

Буриад ардын туульс зоог шүүс хүндэтгэлийн үйл явдал үг хэллэгээр асар баялаг. Тууль болгонд бараг өгүллсэн бий. Туульд гардаг зоог шүүс идээг нэрлэвэл айраг, сэгээ, миша, шарууһа шүүһэ, төөлэй, бозо, тараг, саахар, улаан боодхо, архи, арза, хорзо, шүхэр шавай гэх мэт.

Гэсэрийн туульд: “*Алтан шэрээгээ татаба амтата эдеэгээ табиба, мүнгэн шэрээгээ татажа найхан эдеэгээ табиба, нуураар хэмнэмэ архияа аягалжа бариба, болдогоор хэмнэмэ михаяа асаралдажа табиба. Хан Хюрмас тэнгэри Сэгээн сэбдэг тэнгэрийн амтата эдээнэй найханда арбан хурганайгаа үзүүрыг таһа хазан алдаба эшэхын ехээр эшэбэ, сошихын ехээр сошобо. Сэгээн сэбдэг тэнгэри, Сэсэн ууган хатан хоёр Ай нохойл!... гэлдэжэ үгэ алдан байбад лэ*” гэж гардаг. Аламж мэргэн туульд: *Татахада һунаха табихада агшаха тажаа мүнгэн остоолоо табилдажа байба ла даа Агуу гоохон дүүхэйн. Далан зүһэнэй эдее дээжэ барин асаржа табилдажа байбал даа. Юһэн зүһэнэй боодхойе зүһэ бэрин асаржа табилдажа үгүбэл даа. Алта мүнгүн самбаараа бусалгажа асарба арбан толгой саахараа буталжа табилал. Уухайн найхан ундаараа ундулуулжа талгаба, идехүйн найхан эдеэгээр идеэлүүлжэ талгаба.* гэж гардаг нь туулийн тогтмол хэллэг болон хэвшжээ.

4. Найр наадмын зан үйл, үг хэллэг

Буриад Жангарын туульд: “*Хүри дүү, хуряахай хоёр уулзажа амгалан мэндэээ хэлэлсэжэ аяар тэрэ холо оронһоо орожо ерэхэ гээшэ ехэ һонин байна гэжэ Мийр мэргэн хуряахай ехэ баясжа, нашаганаса энежэ, ташаганаса хөөрэжэ, дэмбэ улаан тамхияа залалсажа шара саарһан дээрэ шатар табижа, хара саарһан дээрээ хаарта лүн хэжэ*” ханашигүй найхан наадангаар сэнгүүлжэ, гурбан хоногто гуда найрлажа, дүрбэн хоногто дүлэ сэнгэжэ эрдимтэ сагаан бумбаяа бэлэг үгэжэ мордуулба алтай.” гэж байдаг нь баяр наадмын тод томруун дүрслэл юм. Буриад түмний дунд хөзөр, шатар цэнгэл наадмын олон зууны уламжлалтай цэнгээний төрөл билээ. Хар толгойгоороо мөрий тавьж хааны охинтой хаарталддаг буриад Жангарын туулийн өвөрмөц сонин дүр дүрслэл.

Эрийн гурван наадмын дүр дүрслэл буриад монгол туулийн түгээмэл нэгэн төрөл нь байдаг тул жишээ авч дурдах нь илүүц.

Хатир наадмын дүрслэл “Шонхоодой мэргэн” туульд: *“Хара халюу малгайтай харамаалжин хара сэмбэн дэгэлтэй басгад гэшиэ хатаражса байха. Хүригэн хүригэн хүбүүн ерэ наашаа хатараяс гэжэ хэлэхэдэн буруу тээшиэ хараад гаралсажи орхёорой. Түүнэй удаада нааданда ошолдожи ябахато нэгэ хэхэг басгад хатаражси байхато хартуусхани малгайтай хүбэнтэй дэгэлтэй басгад сабахи плинс годоһотон хүригэн хүригэн хүбүүн ерэ хаашаа, хатараяе гэхүдэн буруу тээшиэ хараад гаралсажи ошиходои хамниган хүний басгад хушийн үнэр гарша хатаражси байха бидэ годон хани малгайтай хатаражси хэбтэжэ хүригэн, хүригэн хүбүүн ерэ наашаа, хатараяа гэхү бииз. Оролсожи хатаралдажи үхөөсэй л даа.”* гэж гардаг.

Найрлаж байгаа дүр дүрлэл буриад туульд түгээмэл. Хэлц хэллэг нь *“Арын хэсэ дэлдэжэ араяа зони дэлгэжэ, үбэрэй хэсэ дэлдэжэ, эбэрэй зони суглуулба. Нуураар хэмнэжэ архи гаргабала нугаар хэмнэжэ мяха гаргаба ла, юһэн үдэрөөр хэмнэжэ ехэ найр зугаа хэбэ лэ. Найман үдэрээр хэмнэжэ найр зугаа хэбэ лэ. Тагшаар хэмнэн уужал байба ла, таршагаар хэмнэн зугаалажа байба ла, сараар хэмнэжэ уужал байба ла, сагаар хэмнэн зугаалажа байба ла. Арбадахи үдэртөө тэлэрэбэ”* гэхчилэн хайлдаг.

5. Хурим тойн зан, үйл үг хэллэг

Хурим тойн зохиомж буриад монгол туульсын гол үйл явдлыг өгүүлдэг тул энэ зан үйл хийгээд үг хэллэг туульд туссан нь үлэмж буй. Туульсын гол баатар хүйт сүйт хүүхнээ алс хол нутгаас түмэн бэрхшээл туулж авч байгааг үлгэр туульсын зохиомжоор уран илтгэхийн зэрэгцээ буриад зоны хурим тойн ёс горимын дагуу өгүүлсэн өгүүлэмж туульд элбэг тохиолддог. Буриад монгол заншлаар босгож эхнэр авдаг эртний уламжлалт ёс хурим тойн зан үйлд өнөө боловч ёсолдог заншил бий. Осоодор мэргэн туульд тэнгэрийн охиныг хоёр эгчтэйгээ усанд шумбан наадаж байхад хувцсыг нь нууж аваад хэрэг зоригоо хэлж босгож авч байгаагаар гардаг. Хоёр эгч нь дүүгээ хүйт сүйт залуутайгаа жаргалтай сайхан суухын ерөөл тавьж нисэн оддог.

Нүгэлт нүцгэн гургууль туульд Төгс төлдөр хааны Цэдэндамба хөвгүүнд Гинари тэнгэрийн охиныг созол эрдэнээр бариад, хатан болгон суйвдаж өгч байгаа үйл явдал гардаг.

“Ёоро Ёгшоолой” туульд мангасын их хөрөнгийг эрэмгий шаламгай эрч их хүч хөдөлмөрөөрөө өсгөн хариулж арвижуулан дэлгэрүүлж өссөн мангасын үзэсгэлэнт сайхан охины эргүй эм, эзэнгүй зөөри би байна гэхэд нь сэтгэл нь уярч, их хатнаа болгон авсан үйл явдал гардаг.

Буриад туульсын баатрууд ихэвчлэн эрийн гурван наадамд эрэмгий шандсаа сорьж, гурван бооцоог авч, хүргэн хүүгийн сорилтыг давж байж заяаны шар сударт заасан хүйт сүйт хүүхнээ авдаг үйл явдал дэлгэрэнгүй. Буриад Жангарын туульд хүргэн сорих зан үйлийг басганай худалдаа гэж нэрлэсэн байдаг. Басганы худалдаагаар сүйлж эхнэр авч байгаа нь тэр ажээ.

“Ёоро Ёгшоолой” туульд Харалтуу мэргэн хааны өмнө борвин дээрээ бохилзож, тахим дээрээ тахилзаж байгаад гуйх гуулин толгой, мөргөх мөнгөн толгой тавинам гэж хэлэн охиныг нь гуйж авдаг.

“Осоодор мэргэн” туульд: хурим тойн найрт хутга тавилгүй мах идэж, хундага тавилгүй арван өдөр найрласныг өгүүлээд “Түрэ бүтэбэ төөлэй мухариба хурим бүтэбэ хубхай толгой мухариба” гэж хурим тойн явдлыг билигшээн хэлэлцэж

тардаг. Буриад заншлаар хурим тойн зан үйлд төөлэй залах ёс эрхэм байдгийг ийн өгүүлжээ.

BURIAD STUDIES

I Боть

'1 (001)

2008

Тойсомын Галсан

*Дорнод аймаг, Баян-Уул сум,
доктор /Ph.D./*

ТО ВАН ДИДОНО ХОЁР БУЮУ ҮХРИЙН ШИРЭЭР ГАЗАР НУТАГ АВАХ АРГА УХААНЫ ТУХАЙ

Өөр хоорондоо олон мянган модны зайтай орон газарт, хоорондоо 2600 жилийн зайтай цаг хугацааны зүйрлэшгүй алсад амьдарч байсан хэл хэлээ мэдэхгүй, харилцан хэрхэвч нэвтрэлцэж чадахгүй нэг нь Төв Азийн талын монгол, нөгөө нь Италийн хойгийн хоёр түүхт хүмүний амьдрал, хувь заяанд холбогдож гарсан үхрийн ширээр газар нутаг авсан арга ухааны тухай нэгэн сэдэвт домгийн тухай өгүүлье.

То ван буюу олноо сэцэн Тогтохтөр (1793-1868) хэмээн алдаршсан алтан ургийн нэгэн XIX зууны үед Дорнод монголд амьдарч байсан бөгөөд барга нар түүний нутгийн Дархан уулыг авах санаархал өвөрлөж, Манжийн хаанд зарга мэдүүлсэн юмсанжээ. Манжийн хаан сүрээр далайлган, уг уулыг Баргад өгөх шахсанд То ван энэ уулнаас нэг үхрийн ширний дайтай газар аваад, илүү гарваас их эзэнтэн танд өргөө гэсэн гэдэг. Чингээд То ван нас гүйцсэн шар гаргуулж, ширийг нь тэлэн талхиулж, сайн сурчнаар аргамж маягтайгаар маш нарийн зүсүүлж, түүгээрээ уг уулыг бүтэн тойруулж ороогоод халх нутагтаа буюу өөрийн хошууны мэдэлд авч үлдсэн гэдэг. Үүнээс хойш тэр уулыг дархалж Дархан уул гэх болсон домогтой.(1)

Хулд уул Тогтох төр вангийн үед манжид алдагдахад тэрбээр Манжийн хаанд хандаж: -Үхэхдээ шарилаа тавих үхрийн ширний чинээ газар авья гэсэн байна. Манжийн хаан То вангийн хүсэлтийг ёсоор болгон зөвшөөрөхөд тэрбээр, үхрийн ширийг нарийхан зүсч, Хулд уулыг тойруулан шилжүүлж тавьсаар газар хэмжсэн гэдэг домог шиг яриа бий. Гэхдээ үхрийн ширийг хичнээн ч нарийхан зүссэн Хулд уулыг бүтэн тойруулж болохгүй нь 1996 онд “Хэцүү Тогтохтөр ван” гэдэг түүхэн сэдэвт уран сайхны киноны зураг авалтын үеэр ажиглагдсан юм гэж То ван судлаач

Д.Дуламсүрэн бичсэн байна. Өмнөх домогт гараагүй бас нэг шинэ мэдээлэл бол домог дахь уулын нэр Хулд болох нь бидэнд тодорхой боллоо. Тэрбээр, Халх гол нутгийнхны настан буурлуудын үг яриаг нэлээд сонсож, сонин хэвлэлд гарсан домог тэргүүтнийг харьцуулан үзээд, То вангийн үхрийн ширний хэмжээтэй газар гэж хүссэн газар нь Хулд уул болох нь бодит үнэнд нийцэж байна. Холбогдох домог эл явдлаас үүджээ гэж үзсэн байна. Судлаач цааш нь “үхрийн шир” гэдэг хэмжихүйн нэгжийн талаарх хүмүүсийн ойлголтыг хүртэл сонирхон мөшгиж үзээд, Илдэн вангийн хошууны 40 000 ам км газрыг үхрийн шир дэвсэж авсан гэвэл хэн үнэмших билээ (2) гэсэн байна.

То вангийн эх нутгийнхаа уулыг үхрийн ширээр буцааж авсан домгийн талаар эрдэмтэн Д.Халтар, Р.Гончигдорж нар “То ван ба математикийн асуудлууд” сэдвээр илтгэл тавьж, бодлого зохиосон байна. Тэд бичихдээ “МЭӨ 800 жилийн тэртээ Финикийн гүнж ахайтан Дидоно хорон санаат ахаасаа зугтааж, өөрт нь өгсөн бухын арьсыг нарийн зүсэж хийсэн аргамжаар Газрын дундад тэнгисийн эрэг орчим газраас хамгийн их талбайтай хэсгийг таслан авсан тухай домог Римийн яруу найрагч Вергилий (НТӨ 70-19)-н “Энейда” туульст бичигдсэн байдаг. Гэтэл халхын хатуу журамт То ван яг ийм аргаар манж нараас газар таслан авч байсан тухай домог яриа байдаг төдийгүй өөрийнхөө ордыг тойруулан, дайснуудаас хамгаалсан хамгийн их бэлчээрийн талбайг агуулсан суваг ухуулж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлджээ... дэлхий дахинаа Дидоны гэж алдаршсан, бидний хувьд То вангийн гэж нэрлэж болохоор багц бодлого танилцуулья (3) гэсэн байна. Ийнхүү тэд математик сэтгэлгээний нь талаас “үхрийн шир”-ийг анхлан хөнджээ. “Энейн дуулал”-ыг орчуулагчийн анхаарал ч бас л математикч нарын нэгэн адил “үхрийн шир” -нд хэсэг зуур тогтож торсон нь аргагүй юм даа гэлтэй.

Хүн төрөлхтөний түүх, соёлд мөнхөрсөн алдарт туульс “Илиада”-гийн үйл явдал-герег хийгээд илион хүмүүсийн хоорондын арван жил үргэлжилсэн дайн Приам хааны тавин хөвгүүдийн сор болсон Гектор алагдаж, тэдний баатарлан хамгаалсан Трой хот овжин зальжин Одиссейн домогт модон морины арга ухаанд автсаны эрхээр эзлэгдэж, их түймэрт шатах үеэр Эней баатар өтөл буурал эцгээ үүрэн гал нурам болж буй төрөлх хотоо орхин гарч, нөхдийн хамт долоон онгоц хөлөглөн, долоон жил далайгаар явсаар байгаад, зургаа нь далайн шуурганд сүйдэж, дөнгөж ганц хөлөг онгоцтой эх газрын эрэгт хүрч ирсэн ажгуу. Маргааш өглөө нь янаг амраглалын тэнгэр Афродита гоо үзэсгэлэн төгөлдөр бүсгүйн дүрээр түүнтэй учран, угтан хүлээж буй учрал тохиол, ахуй насны нь хувь төөргийг зааварлан хэлнэ. Хэн хэн нь гашуун зовлон амссан Эней Дидоно хоёр хувь заяаны эрхээр ийнхүү учирч голомт бадраана.

Дидона бүсгүй уул нь Финийн толгой баян Сикейтэй гэрлэсэн юмсанжээ. Тэнгэр болоод хүмүний дундаас төрсөн титан Пигмалион Дидоногийн төрсөн ах бөгөөд Тирийн хаан байсан хэдий ч хүргэн Сикейтэйгээ алтны улмаас маргалдаж, улмаар, ариун шүтээнийхээ өмнө хүргэнээ хор шингээсэн сумаар харван хороосон ажгуу. Сикейн сүнс шөнө дөлөөр хайрт гэргийнхээ дэргэд сүүтэгнэн хүрч ирээд, цоо харвуулсан шархаа яран харуулж байгаад, яргалал болсон орон гэр орд харш, бузартсан бурхан шүтээнээс алсалж, эндээс үтэр холдон зайлагтун” гэж гэргийдээ зөвлөөд, алс холын аянд нь хэрэг болох алт, эрдэнэсээ нуусан газраа зааж, хэрхэн авах арга хэлж өгсөн юм байжээ.

Дидона бүсгүй эр нөхөр Сикейн сүнсний өчил үгэнд итгэж, хань нөхрийнхөө өс авч, төрсөн ахаа хороогоод, харь нутгийг зорин явсаар Италид ирж, газар худалдан авчээ. Зохиолд бичсэнээр

“Хөндий дүүрэн алттай ирээд авсан газар нь
Өнөө чиний зогсож буй энэ л хөрс шороо юм
Карфагены шинэ цайз, хана хэрэм босч байна
Эндээс худалдаж авсан газар нь алгын чинээхэн
Алдалбал ер хэмжээ нь бухын ганц арьс төдий”, (нэр нь хүртэл Бирс) байж л дээ.

Ш.Одонтөр бухын арьсны нэрийг хүртэл “бирс” гэж байгааг машид сонирхон, герегт бас **bursa** (хуулсан арьс) гэдэг болохыг тэмдэглэжээ. Эртний герег хэлний толь бичигт “бирсан”... (4) гэж бичсэн байдаг нь эртний монгол хэлний “фарисун” - “фарисун”-эдүгээ хэлний “арьс-” гэдэгтэй нэг гаралтай үг болох нь илэрхий байна. Буриадын “арахан” лугаа үгийн утга дүйж байна.

Газар худалдан авахдаа ашигласан хэмжүүр нь хоёр домогт адилхан сайтар элдэж нарийхан зүссэн үхрийн шир төдийгүй уул үхрийн ширний нэр нь монгол, герег хэлнээ бас л адилхан, нэг гаралтай үг болох нь энд ойлгомжтой боллоо.

Орчуулагч домогт өгүүлснээр финикчүүд нэг том бухын арьсыг зүсэж, газраа хэмжин хуваадаг заншилтай гэнэ гээд ийм маягийн домог монголын То вангийн домогт бий (5) гэснийг ч тэмдэглэх хэрэгтэй юм.

Афродита тэнгэр Эней баатартай ярилцах үедээ

“Харин энэ газар өмнө нь Ливийн эзэмшил байсан чиг

Хатуу байрын эцэст, өдгөө, Тирийн Дидонагийнх” гэснээс үзвэл Дидона ёс бусаар өөд болсон фини удмын нөхрийнхөө хөрөнгөөр Ливичүүдээс уул газрыг худалдан авсан нь мэдэгдэж байна.

Дээр өгүүлж буй монгол, герег домог “үхрийн ширээр газар авсан тухай” нэгэн сэдэвтэй учраас нарийвчлан судлахад сонирхолтой ажээ. Товчлон өгүүлбээс, газрын үнэ цэнийн асуудал юм. Газрын төлөө ур ухаан дайчилж байсан эртний бөгөөд хүмүн төрөлхтний мөнхийн сэдэв хөндсөн байна.

То ван монгол орон манжийн эрхшээлд байсан XIX зууны дунд үед газар нутгийнхаа ганц уулыг ч болов бусдад алдахгүй гэж чармайж байсан бол 2000 жилийн тэртээ Хүннүгийн зүүн талаар нутагладаг Дунху улсаас элч илгээж, хоёр улсын хил орчим байдаг хүн нутагладаггүй хэсэг газраа өгөхийг шаарджээ. Модун хаан түшмэдүүдээ цуглуулж хэрхэхийг зөвлөлдөхөд нэлээд хэсэг нь хайртай морь, хайртай хатнаа өгч болсон юм. Тэр муу жаахан газрыг өгөхөд яахав хэмээн зөвшөөрөх санал гаргажээ. Үүнд, Модун шаньюй маш ихээр хилэгнэн, мунхаг түшмэдийг цаазлах зарлиг буулгаж: - Адуун сүрэг байгаа цагт агт морь олдоно, Улс орон байгаа цагт хатан олдоно. Харин өвгөдийнхөө газар нутгаас өчүүхэн төдийг ч харьд өгч үл болно. Газар бол улсын үндэс хэмээн сургажээ (6) гэж гардаг.

Монголчууд Модун шаньюйн үеэс газрын үнэ цэнийг айхтар мэддэг, газраа эрхэмлэн шүтдэг, хуульчлан хамгаалдаг байсан нь их л анхаарууштай асуудал бөлгөө. То ван Хүннү гүрний хаан Модуны үеэс алтан ургийнхны цусанд шингэсэн их өвөг Чингис хааны үед ч дахин давтан зарлиглан бичигдээгүй хуулийг ягштал мөрдсөн нь эндээс харагдаж байна. Бидний өвөг дээдэс газаргүйдэхийн гачлан

зовлонг хэдийд ч хаана ч үзээгүй улс явсан даа. Үлэмжхэн цөөрч амь тэмцэн Эргүнэ хунд нутаглан өнөржин олширч байхдаа л уужим дэлгэр нутгийг хүсэмжлэн байсан явдал монголын эртний домогт бий. Ийн бодоход, монголын гол сурвалжит эртний овог аймаг - хияд боржигины нэрийн “киян” хэмээх үгийн утга ихээхэн нягтлуштай. Эрдэмтэн Г.Сүхбаатар нанхиадын түүх сурвалжаас уул үгийн утга нь “уулын догшин үер”-ийн нэр болохыг олж тогтоосон (7). Миний хувьд буриадын хэл ярианаас их усан үерийг “Цагаан морь” хэмээдэг болохыг мэдээлсэн билээ. (8). Үгийн гарбаль судлаачид аль хэдийнээс “хияд” хэмээх нь “цагаан” гэсэн үг болохыг “гялалзах, гялтайх, гял цал, гилбэлгээн” г.м. язгуур нэгт олон үгсийг харьцуулан нотлоод эдүгээ нэгэнт санал нэгдмэл болжээ. Японы умарт нутагт **каяато-казато** овгийнхон буй бөгөөд тэдний нэрийн утга нь “догшин салхи, шуурга” гэсэн үг юм билээ. “З, Ж” фонем “j” лугаа сэлгэцэх авианы хуулийг бодолцвоос, энэ нь бас л “кияд” “овог болоод орхино.

Өрнөдийн олон хэлнээ далайг “океан” хэмээн нэрлэдэг, эртний герегийн домогт “далайгаас ирсэн хүмүүс”-ийг ийн нэрлэдэг ажээ. Франц хэлний нэвтэрхий тайлбар толь”-д уул үгийг “хүн” хэмээн тайлбарласан байх юм. “Океан” хэмээх нь угтаа хаяа хярхаггүй их далай” гэсэн утгатай герег үг ажээ. Эртний герег хэлэнд ...**океан или океанос** нь Египетийн Нил мөрний эртний нэр (9) юмсанжээ. Нэн эрт үед Мисир нутгийн дундуур урсах Нил мөрнийг ингэж нэрлэж байсан нь хиян-киян нарын нэгэн хэсэг нь тэр цагт уул мөрний сав газарт он удаан аж төрж байсан гэдгийн баталгаа биш үү? Эзэмшин аж төрж байсан аймаг, угсаатны нь нэрээр уул,усыг нэрлэх явдал түгээмэл үзэгдэл билээ. Океанос гэхлээр далайн лусын хааны гүнж нарыг хэлдэг байна.Монголоор “усан дагина” гэдэгтэй л дүйх билээ. Тухайн харь нутгийнханд монгол удмын бүсгүйчүүл усан дагина шиг харагдаад байдаг нь дорнын яруу найрагч Б.Явуухулангийн

“Хүлгийн сайныг би адуунаасаа барилаа

Хүүхний сайхныг би Монголдоо харлаа” гэсэн мөрийг өөрийн эрхгүй санагдуулна.

Эртний герегийн домогт Уран, Геи хоёр тэнгэрийн дундаас төрсөн Океан тэнгэр /*бог водной стихии*/ байдаг билээ. Тэнгэр газрын дундаас монгол хүмүн эх сурвалжаа авсан гэдэг монгол домог зүйн ойлголттой энэ нь нийцэж байгаа юм. Усан эрхшээлт тэнгэр хэмээвээс зохимжтой агаад монголын сурвалжит “**киян**” аймгийнхны нэр нь эртний герегийн домогт далайн буюу усны тэнгэр болж ороод зогсоогүй улирах түүхийн урт хугацаанд олон улсын шинжтэй дэлхий нийтийн нэр томьёо болохдоо анхдагч дуудлага болоод “их ус” хэмээсэн үндсэн ухагдхуунаа тэр чигээр нь хадгалсаар ирсэн байна гэж үзэж байна. Киян-Океан нар евроази дахинаа түгэн тархсан соёлжуулагч баатар төдийгүй тэрхүү баатрын нэр болжээ.

То вангийн “Үхрийн ширээр уулаа авсан” домог-ийн түүхэн үндсийг мөшгин улбаалаад үзэхэд эртний Рим, Герегийн домгийн сэтгэлгээ рүү өөрийн эрхгүй хөтлөгдөн ороод зогсохгүй, мянганы их хүн эзэн богд Чингис хааны удмын То вангийн язгуур овог нь хүртэл хияд, -герегийн усан эрхшээлт Океан тэнгэртэй шууд хамааралтай болж байна. Усан эрхшээлт буюу далайн тэнгэр Посейдоны нэрийг эртний монголын “фусун –усан-ус” гэсэн үгээс гаралтай гэж үздэг эрдэмтэн ч бий.(10) Энэхүү дүгнэлт нь зөв зүйтэй юм гэдгийг олон баримтуудтай харьцуулан нягталсны эцэст миний бие олж мэдсэн билээ.

Хияд нарын дунд өнө эртнээс тархсан газрын үнэ цэнийн тухай домгийн цөм болсон “үхрийн ширээр газар авсан домгийн тархалт нь их л эртний бөгөөд уул монгол италид нэгэн голомтоос тархсан гэж үзвэл зохих байна. Монгол, герегийн нэгэн цөм бүхий олон арван домог, тухайлбал:

1. Финийн хааны охин Европа нь бухын дүрээр ирсэн Зевстэй нөхцөж, өрнө тивийг үүсгэн байгуулагч гурван хөвгүүд төрүүлсэн нь Асуйхан /Ази?1/ удган бухтай нөхцөж, бас гурван хүү төрүүлсэн лүгээ нэн адил,

2. Финийн хаан Агенорын хүү Европын ах Фив хотыг үүсгэн байгуулагч, 16 үсэг бүхий эртний герегийн цагаан толгойг зохиогч Кадмын нэр /Геродотын бичсэнээр/ монголын худам бичгийн нэртэй ижил,

3. То вангийн ордоо тойруулан барьсан суваг Балкан, Италийн хойгийн хот улсынхны хамгаалалттай агаар нэгэн,

4. Эней баатрын эцгээ үүрэн дайн дажны хөлөөс үтэр холдон одож буй нь их нүүдлийн цуваа элсэн цөлийн дунд усаар гачигдан сүйрэхийн даваанд араг дотор нуусан эцгийнхээ сургаалаар гунан үхрээ даган явсны хүчинд баян бүрдтэй залгаж, цуваагаа аварсан төдийгүй өтгөсийн амийг “цагаанаа цацаах, хард хахаах”-ыг зогсоосон хөвгүүн лүгээ ижил,

5. Трой буюу Илион хотын хаан Приам нь буриадын бөөгийн шашны тэнгэрийн нэртэй адилхан байдаг,

6. Ази, Европа хоёр тивийн хүн ардын үүслийн тухайд Асуйхан удганы гурван хөвгүүдийн нэр монголын болоод герегийн томоохон гурван аймаг, улс, угсаатны нэртэй ижилхэн байдаг зэрэг олон баримтууд То ван, Дидоно хоёрын нэгэн загварын арга ухаанаар газар худалдан авч байсныг тайлж өгөх гол түлхүүр болж байна.

Илион буюу Трой хотоос эцгээ үүрч долоон жил далайгаар тэнэсэн Эней баатар нөхдийн хамт Италийн хойгт хүрэлцэн очоод төрөлх Трой буюу Илион хотынхоо нэрээр овоглон өнөржиж, Итали даяар Юлий омог болж, эдний алтан ургаас алдарт Юлий Цезарь төрж гарсан бөгөөд Хүннү гүрний мандал бадралаас өмнөх үеийн манайхны өвөг дээдэстэй соёлын төдийгүй уг язгуур, угсаа гарлын хэлхээ холбоотон байсан байна. Ингэхлээр Эней болоод түүний удмын Цезарь нар Италид

“Хүннүгийн хаан Атилла

Хүндтэй маягаар заларна” гэдэг итали ардын дуу гарахаас өмнө очсон, тэнд төрсөн соёлжуулагч баатрууд юм. Ийм сэтгэл оюун болоод ахуй ёс зан заншлын тааламжтай хөрсөн дээр Атилла хаан морилсон нь зүй ёсны юм шүү.

Өрнөдийн Гэсэр судлаач зарим эрдэмтэд Цезарь хааныг Гэсэр хаан гэж тайлбарласныг буруутгах аргагүй юм. Гэсэр нэрийн талаар Ц.Дамдинсүрэн багш “Амдо улсын хаан” гэж, Б.Сумьябаатар багш солонгос хэл, түүхээс “көсыр хан” гэдэг үгийг олж, “бүхний ван” гэсэн цол болохыг тогтоосон. Эрдэмтэн Чандмань Персын хаан Ксеркс юм гэж цаг хугацааны хувьд урагшлуулсан шаталсан амжилтууд нь шинжлэх ухаан улам хөгжин байгаагийн тодорхой жишээ юм. Судлаачийн хувьд энэ талаар бас өөрийн байр суурь бий.

Эртний хоёр угсаатны үг, домог, овог аймгийн нэр тэргүүтнийг өөрийн боломжийн хирээр харьцуулсан судалгаанаас дуслын төдийг өгүүлэхэд ийм болой.

Номзүй

1. То ван судлал. Г.Аким. “То ван” - 93-р тал
2. То ван судлал. 7-р боть. 52-53-р тал
3. То ван судлал. 7-р боть. 24-р тал. Б.Халтар, Р.Гончигдорж.”То ван ба математикийн асуудлууд”
4. Х.Дворецкий. Древнегреческо-русский словарь М.1958
5. Ш.Одонтөрийн орчуулга Вергилий “Энейн дуулал” 2003. УБ.427-р тал
6. Х.Сампилэндэв. “Эзэн богд Чингис хааны домог оршивай” УБ.1996, ШУАХЗХ Монгол домгийн чуулган УБ.1999.35-р тал
7. Г.Сүхбаатар. “Өвөг монголчууд” УБ.
8. Т.Галсан. Буриадын язгуур домгийн товчоон УБ.1998.
9. Х. Дворецкий.Древнегреческо-русский словарь
10. Чандмань нар “Монгол хэлтдийн 8000 жилийн түүхийг мөшгих нь”. Хөх хот, ӨМӨЗОХХ 1997.

BURIAD STUDIES

I Боть

1 (001)

2008

Д.Дамдинжав
*Дорнод аймаг, Хэрлэн сум,
9 дүгээр баг, түүх судлаач*

БАЙГАЛ НУУР ОРЧНЫ ГАЗАР НУТАГ ЭРТ ҮЕЭС ЯМАР УЛСЫН МЭДЭЛД БАЙВ, ЯАГААД ОРОСЫНХ БОЛОВ

Буриад түмний тоонто нутаг Байгал нуурын орчин газар хэдий үеэс ямар улсын мэдэлд байв? гэдгийг эрт үеэс авч үзэх шаардлагатай байдаг.

Шинэ чулуун зэвсгийн үеэс Төв Азийн өргөн уудам тал нутагт суурьшин нутаглаж байсан нүүдэлчин олон аймгуудын нийгмийн дунд төр улс байгуулах уур амьсгал бий болж МЭӨ 111 зууны сүүлч үеэр Модун Шаньюй гэрч хүн гарч олон аймгуудыг байлдан дагуулж Азийн түүхэнд анхны нүүдэлчин Хүннү улсыг байгуулсан билээ.

Хүннү гүрэн Модун Шаньюйн үед өргөн уудам нутгийг эзэмшиж хүчирхэгийн туйлд хүрч, түүний газар нутаг тэр үед баруунаас Дорнод Түркестаны хот улсууд, өмнө зүгт Дорнод Ху аймгийн нутаглаж байсан Ляо голын эхний газар, өмнө зүгт Хятадын урт Цагаан хэрэм, умар зүгт Байгал нуурын хойт тал хүрч байв.

Сяньби улсын үед буюу МЭ-ний 11 зууны үед Байгал нуур бүхэлдээ Лена /Зүлэг/, Ангар мөрний цутгалын нэлээд хэсэг энэ улст харьяалагдаж байв.

МЭ-ний V зууны үед Их Нирун /Жужан/ улсын газар нутаг өмнөд зүгт Говь, умард зүгт Байгал нуур бүхэлдээ, өрнө зүгт Хар Шар, дорно зүгт Солонгос хүрч байжээ.

Түрэгийн үед Байгал нуур орчны өмнөд талын газар нутаг тэдний мэдэлд байв. МЭ-ний IV зууны үед байлдан дагууллын үр дүнд Түрэгийн газар нутаг ихэд өргөжин тэлж зүүн зүгт Солонгосын булангаас баруун зүгт Долоон усны газар хүртэл, өмнө зүг Цагаан хэрмийн хавь газраас умард зүг Байгал нуурын хойт тал хүрч байжээ.

Уйгарын хаант улсын үед /VIII/ эзлэн суусан нутаг нь баруун зүгт Алтайн уулнаас, зүүн зүгт Хянган /Хаан уул-Hiangang/-ы нуур хүртэл, өмнө зүгт Говь хүртэл, хойт зүгт Байгал нуур бүхэлдээ энэ улсын хойт хил хязгаар нутаг болж байв.

Киргизийн хаант улсын үед /IX зуун/ Байгал нуурын өмнө, зүүн өмнөх эрэг дагуух нутаг, Сэлэнгэ, Онон мөрөн бүхэлдээ энэ улст харьяалагдаж байв.

Хятад буюу Ляо улсын үед /1040 он/ Байгал нуурын өмнө, зүүн өмнөх нутаг, Сэлэнгэ, Хёлго, Ингода, Шилка мөрөн, Саяаны нуруу энэ улст харьяалагдаж монгол хэлт овог, аймгууд энд нутаглаж байжээ.

Ой хөвч, нуур цөөрмийн энэ нутагт тэртээх их нуудлийн балар эртнээс монгол овгууд амьдран суусаар иржээ. Эрт цагт Хүннүгийн эзэнт гүрний нэг хэсэг болж байсан эл нутаг 1207 онд Чингис хааны эзэмшилд хамрагдан орж, харин хоёр зуу гаруй жилийн дараа түүний хөвгүүдийн сул дорой захиргаанаас ангижран тасарч салсан ажээ.

Бүтэцийн хувьд түргэн эвдэрсэн монгол овог, аймгуулыг Чингисийн удмын Батмөнх Даян хаан /1466-1543/ дахин нэгтгэж өвөг дээдсийнхээ бараг бүх нутаг буюу өөрөөр хэлбэл өмнө зүг цөл Говиос, умар зүг Байгал нуур хүртлэх газрыг өөрийн захиргаанд хураан авчээ.

Монголын хүчирхэгжилт оргилдоо хүрч Карпатын уулсаас Номхон дөлгөөн далай хүртэл нэгэн бүхэл бүтэн эзэнт гүрэн бүрэлдэн тогтов. Түүнийг үндэслэгчид Ази, Европын хагсыг эзэлсэн энэхүү хэмжээгүй эрхт хаант улстаа “Ouiréar (Kunéar)” Кипчак гэдэг нэр өгчээ. Сибирь, Байгал нуур орчны газар нутаг бүхэл бүтнээрээ энэ улсын харьяанд оров.

Тогоонтөмөр хаан хятадаас хөөгдөж 1370 онд нас барснаас монголын Их Юан улс мөхсөн боловч Монгол улс мөхөөгүй өмнөд Сибирь, Байгал нуураас Их Цагаан хэрэм хүртэл, Хангайн нуураас Тэнгэр уул, Ляодун, Сычунь, Шэньси хүртэл уужим нутагт Монгол улс оршин тогтносоор байсан ба түүнийг түүх сурвалжид Хойт /Ар/ Юан улс гэж тэмдэглэсэн байдаг.

XVI зууны үед Ойрадын Гэрсэнз жалайр хунтайжийн ууган хөвгүүн Ашихай, түүний ач хөвгүүн Шолой Убаш хунтайжийн /орос сударт Алтан хаан гэж алдаршсан/ нутгийн хил нь зүүн тийш Сэлэнгэ, Тамирын голын эх, баруун тийш Алтайн урианхай, баруун буриад, Красноярск хүрч байжээ.

XVI зууны сүүлч үе /1580 он/-д Ермак Тимофеевич /?-1585/ гэгч Сибирийн газар нутгийн баруун сэжүүрийг байлдан эзлээд дорно зүг тийш давшиж зүүн арын Хүүлинг гэдэг хүрч, тэр нутагт Хүүлингийн острог /засаг захиргааны нэгж/ тогтоосноор Байгал нуур орчны газар нутгийг байлдан дагуулах аян дайны эхлэл тавигдаж Байгал нуурын хойт тал, Верхоленскд сууж байсан буриадууд 1583 онд оросын мэдэлд оров.

Ингэж оросууд Байгал нуур орчныг хасаг цэргийн хүчээр эрхшээлдээ оруулж эхэлснээр газар нутаг, байгалийн өгөөж хишгээр амьдарч байсан чөлөөт амьдралтай буриад зоньг байлдан дагуулах эхлэл XVI зууны сүүлч үеэс тавигдав.

XVII зууны эхээр хасаг цэргийн отрядууд баруун буриадын нутагт довтлон орж цус асгаруулсан тулааныг олон удаа хийж Байгал нуурын баруун буриадуудыг энэ зууны дунд үе хүртлэх хугацаанд оросын хааны мэдэлд оруулжээ.

Оросууд ингэж өрнөөс дорно руу эзлэн түрэмгийлэх аян хийж удаа дараа цэрэгжсэн отрядыг явуулж буриад зон олны тоонто нутаг болох Байгал нуур

орчныг булаан авч, зон олныг нь алж талах болсон эхлэлийг XVIII зууны эхэн үетэй холбон үзэж болох байна.

Энэ зуунд Халх Монголд гурван том аймаг, тухайлбал: Түшээт хан, Засагт хан, Сэцэн хан аймаг гэж байсан бөгөөд эхний хоёр нь хүчирхэг газар нутгаараа байгалын чанадын буриадуудын газар нутагтай шууд хиллэдэг байв.

Оросуудыг Байгал нуур орчны газар нутагт ирэхээс өмнө тэр хавийн буриадууд монгол ноёдод тогтмол бус алба барьж байсан бол Өвөр Байгалын буриадууд монголын Түшээт хан, Засагт ханы албат /харьяат иргэд/-ууд байв. Өөрөөр хэлбэл оросуудыг Өвөр Байгалд ирэхээс өмнө энэ газар нутаг Түшээт ханы бүрэн мэдэлд байжээ.

Энэ тухай Сибирийн түүх судлаачдын анхных болох П.А.Словцев бичихдээ: Энэ газар нутаг /Байгал нуур орчин Д.Д/ тухайн үедээ эзэн Чингисийн болон түүний үе залгамжлагчдын их гүрний бүрэлдэхүүнд багтаж байсан бол сүүлдээ XVII зууны дунд үе хүртэл халын хоёр ханы үгийг дагаж байсан ажээ гэж тэмдэгдсэн байдаг.

1646 онд 60 хүнтэй хасаг цэргийн отряд, том газар эзэмшигч боярын хүү Иван Галкины удирдлагаар Енисейгээс шинэ албатуудад татвар ноогдуулан хураах, Байгал орчмын газрыг тодорхойлон бичих, алт мөнгөний судлыг эрж хайх үүрэгтэйгээр гарчээ. Энэ отряд Баргажин голын адагт ирээд баргажинд шивээ барив. Бас Енисейгээс Шилк мөрний чиглэлд хасаг цэргийн отрядуудыг явуулж байв.

Иргэж олон тооны хасаг цэргийн отряд, алт мөнгөний эрэлчид олон удаа зүүн буриадад илгээгдэж, нэг их эсэргүүцэлтэй тулгаралгүйгээр Байгал нуурын зүүн талын газар нутгийг, зон олонтой нь эзлэн авчээ.

Оросууд Сибирийг эзэгнэж байх үед, монголын эзэмшилд байсан байгал нуур орчны газар нутаг, цаашлаад Хөвсгөл нуурыг эрх мэдэлдээ авахыг оросууд зүйл бүрийн аргаар сонирхож байв. Байгал нуурыг оросууд өөрсдийн эрхшээлд оруулах санаархал ямар байсныг доорх материалаас харж болох байна.

Үүнд: Оросын улс төрийн зүтгэлтэн, генерал - фельдмаршал Ф.А.Головин гэгч өөрийн тэмдэглэлдээ монгол ноёдтой байгуулсан дипломат хэлэлцээрээр хоёр улсын хилийн шугамыг тогтоох тухай гэрээний төсөл, худалдааны харилцааны талаар тодорхой бичсэн байна. Тэрбээр тухайн үед монголын Түшээт ханд явуулсан бичигтээ: Далбаа хөлөглөж загас барьж үзээгүй монголчууд Байгал нуур төдийлөн ашиг багатай тул түүнийгээ манай орост шилжүүлж, оронд нь бидний зүгээс мөнхийн найрамдал, найдвартай түшиг олж болох юм гэсэн санал дэвшүүлээд танайд шаардлагатай байгаа галт зэвсэг /цахиур буу/ 500 ширхэг, мөн дэлбэрэх бөмбөгөөр харвадаг гунан буу 10 ширхэгийг тус тус бэлэг болгон барихад бэлэн байгаагаа илэрхийлж байжээ. Оросууд ингэж монголын газар нутагт шунахайран зүтгэж байв.

Хаант Оросын зүгээс ийнхүү буриад монголчуудын газар нутгийг түрэмгийлэн эзэлж, зон олныг нь тарчилгаж, зовоож байсныг халх монголын ноёд ажиглагчийн байр суурьнаас зүгээр харж суусангүй.

1667 онд Зүүн гарын Сэнгэ тайж Красноярскийн бэхлэлтийг эзлэн байлдан дагуулагчдад заналхийлж, 1669-1670 онд Дай хунтайжийн монголчууд 15000 цэргийн хүчээр Нэршүүг эзлэн буриадуудыг хураан буцааж байснаас гадна 1674 онд тавнангийн Гэгээн тайж цэрэглэн хөдөлж байв.

1688 онд Баатар хунтайжийнхан 4000 цэргийн хүчээр Үдэ, Сэлэнгийн шивээг дайрч байх үед Галдан /1644-1697/ бошигт Түшээт ханыг довтолсноор монгол цэрэг буцаж буриадчуудыг өмгөөлөн газар нутгийг нь хамгаалж тэмцэх боломжийг бүр мөсөн алдахад хүргэсэн байна. Монголын дотоод байдал ийн хямарснаас халх монголын ноёд гадагшаа цэрэглэн дайтах чадваргүй болов.

Буриадчуудын ужигарсан хатуу эсэргүүцэлтэй тулгарсан учраас Байгал нуур орчны газар нутгийг байлдан эзлэх нь оросуудаас даруй жар гаруй жилийн хугацаа шаардсан юм. Ингэж оросуудаас Байгал орчны газар нутгийг зон олонтой нь эрхшээлдээ оруулах үйл явц буриад нутагт урт удаан хугацааны цус асгаруулсан тэмцлийн эцэст Орост ашигтайгаар сая биелэлээ олсон байна.

Хаант Орос улс 1680-аад оны үеийн байдлаар буриадчуудын дийлэнхийг өөрийн харьяат болгосон нь улс төрийн алсын хараатай бодлого байв. Энэ нь эхний ээлжинд Байгал нуур орчинд оршин суугч буриад, монгол хэлт овог аймгуудыг бариаг бүгдийг өөрийн албат болгох, дараагийн ээлжинд газар нутгийн асуудлыг олон улсын хэмжээнд шийдвэрлүүлэх бодлого байв.

Ингэснээр ч Монгол улс, манжид дагаар орж өөрийн гэх улс төрийн бодлогогүй байсан эгзэгтэй үед буюу 1989 оны Нэршүүгийн орос манжийн гэрээгээр Байгал орчны газар нутгийг орос улс өөрийн мэдэлд бүрэн авч, 1727-1728 оны Буурын хэлэлцээрээр монгол, оросын хилийн шугамыг татаж баталгаажуулав. Энэ нь монголыг тасчиж хуваасан үйл явдал байв.

Эх сурвалж

1. “БНМУ-ын түүх” /нэмж засварласан гуравдугаар хэвлэл/. Улаанбаатар хот 1984 он
2. “Историка культурный атлас Бурятый” Москва 2001
3. А.Столыпин “Москва, Бээжингийн завсар дахь Монгол орон” Улаанбаатар хот 2000 он
4. “Буриад-монголчуудын угсаа-түүхийн зарим асуудал” /Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал/ илтгэлүүд. Улаанбаатар хот, 2000 он
5. “Өдрийн сонин” Улаанбаатар хот 2001 он 171 /634/
6. “Ил товчоон” сонин. Улаанбаатар хот 1992 он 136 /69/

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

Морман Д.Дашдаваа
Улс төрийн хэлмэгдэсдийн холбооны
Нийслэлийн салбар зөвлөлийн дарга

МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТЭД БУРИАД ЗОН ӨРТСӨН НЬ¹

1930-40-өөд онд Монголд болсон их хэлмэгдүүлэлт гэдэг их хядлага бол Монголын шинэхэн түүхийн хамгийн эмгэнэлт явдал.

Монголд улс төрийн коммунист хэлмэгдүүлэлт 1921 оноос эхэлсэн байдаг. Гэтэл 1922 оноос коммунист хэлмэгдүүлэлт эхэлсэн гэж худал бичээд байх юм. 1921 оны намар түвд лам нар Богдын дэмжлэг, Японы туслалцаатайгаар ардын хувьсгалт засгийг түлхэн унагах гэж байна гэсэн зохиомол хэргийг сэдэж, саж лам Жамъянданзан тэргүүтэй олон түвд лам хуваргуудыг “Саж ламын хэрэг” гэгчээр хэлмэгдүүлэн баривчилсан байна. Харин түүнээс хойш буюу 1922 онд Бодоо, Чагдаржав нарын бүлэг, буриад Очиров, Туванов нарын бүлэг, 1924 онд Данзан, Баваасан нарын бүлэг гэх мэтээр зохиомол хэргийн хэлмэгдүүлэлтүүд жил бүр явагдсаар 1937-40-өөд онд бүр гаарч, хэдэн арван мянган гэмгүй хүнийг баривчлан шийтгэж, тэдний 4-ний 3-ыг нь буудан алсан байдаг.

Монгол дахь их хэлмэгдүүлэлт буюу их хядлага гэж ЗХУ-ын Дотоод Хэргийн Ардын Комиссарын газрын /НКВД/ орлогч дарга генерал М.Фриновский, Батлан Хамгаалахын Ардын Комиссарын газрын орлогч дарга генерал Д.Смирнов, Монголд суух бүрэн эрхт шинэ элчин төлөөлөгч С.Миронов нар манай НТХ, Засгийн газарт ч хэлж мэдэгдэлгүйгээр 1937 оны 8-р сарын 26-нд Улаанбаатарт гэнэт хүрэлцэн ирж, Фриновский нь дайчлан баривчилж устгах шаардлагатай гэх манай 115 хариуцлагатай ажилтан-сайд, дарга нар, цэргийн удирдлагуудын “Заговор” /Хуйвалдаан/ нэртэй нэрсийн жагсаалтыг 1937 оны 8-р сарын 28-нд Х.Чойбалсанд гардуулж, Х.Чойбалсан нь уг нэрсийн жагсаалтад орогсодоос 65 хүнийг нь 9-р сарын 10-ны шөнө дайчлан баривчлснаар эхэлсэн, гүтгэн гүжирдэж

¹ 2008 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод болсон “Дархад, Буриад судлалын зарим асуудал” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл.

хоморголон баривчилдаг, эрүүдэн тамалж худал хэрэг тулган хүлээлгэдэг, үй олноор нь хоморголон алж устгадаг фашист үйл ажиллагааг хэлдэг. Гэвч гэмгүй хүмүүсийг гүтгэн гүжирдэж зохиомол хэрэгт үй олноор нь хэлмэгдүүлдэг энэ ажиллагаа Монголд бүр 1937 оны 9-р сарын 10-наас өмнө эхэлсэн байсан гэж хэлж болохоор байна. 1933 онд “Японы тагнуулын хэрэг” буюу “Лхүмбийн хэрэг” гэдэг зохиомол хэргээр ганц жилд буриад голдуу 537 хүнийг баривчилж, фашист арга хэрэглэн хэрэг хүлээлгэж 317-г нь шийтгэхдээ 60-ыг нь буудан алах, 257-г нь янз бүрийн хугацаагаар хорихоор шийтгээд, бас 126 хүнийг Оросын Тундр руу зөвхөн ялтангуудаар хийлгэдэг хортой, хүнд ажил хийлгэхээр цөлж байснаас гадна лам нарыг барьж устгах зорилгоор зохиомолоор бий болгосон Ёнзон хамбын хувсгалын эсэргүү “Төв” гэдэг бүлгийн хэрэг гэгчид холбогдуулан 1937 оны хавар уг бүлгийн удирдагчид гэх Ёнзон хамба Лувсанхаймчиг, дэд хамба Дамдин, Монгол дахь тамгатай 13 хутагтаас үлдээд байсан сүүлчийн нь хутагт болох өндөр настай Манзушири хутагт Цэрэндорж нарын 23 том ламыг баривчилж, тэдний “хэргийг” 1937 оны 10-р сарын 4-7-нд Төв театрт “олны” өмнө шүүн таслахдаа 19-д нь буудан алах ял ноогдуулсан байна. Тэгэхээр зөвхөн сайд, дарга, цэргийнхнийг хоморголон баривчилсан 1937 оны 9-р сарын 10-ны баривчилгаанаар л их хэлмэгдүүлэлт эхэлсэн гэх нь зарим талаар учир дутагдалтай мэт.

Энэхүү их хядлагаар Монголын насанд хүрсэн эрэгтэй хүний 5 хүн тутмаас 1 нь баривчлагдаж, баривчлагдсан 4 хүн тутмын 3 нь буудуулсан байдаг. Энэ бол аймшигтай тоо. Тийнхүү ердөө 200-аад мянган насанд хүрсэн эрэгтэй хүнтэй байсан Монгол улсын 40-өөд мянган эрэгтэй нь баривчлагдаж, тэдний 30-аад мянга нь буудуулсан юм.

Их хядлагаар ийнхүү насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь буюу 10 хүнээс 2 нь баривчлагдаж байсан бол Монгол буриадуудын хувьд 1937-1938 онд насанд хүрсэн эрэгтэй буриадуудын 10 хүн тутмын 9 нь баривчлагдаж, баривчлагдсан 10 буриад тутмын мөн 9 нь буудуулсан байна. Тийнхүү монголын буриадууд бол Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтэд хамгийн ихээр өртсөн зоны нэг юм. Ганц баримт дурдья. ОБЭК-ын 1938.05.27-ны 20-р хурлаар орсон Хөвсгөл аймгийн 294 хүн, 1938.06.03-ны 21-р хурлаар орсон мөн аймгийн 319 хүнийг шийтгэхдээ энэ 613 хүний 507-г нь /83 %-ийг нь/ буудан алж, 106 нь /17%-ийг нь/ амь хэлтрүүлж 10 жилээр шийтгэсэн байгаа бол мөн тэр хоёр хурлаар шийтгэгдсэн 73 настай Цэмбэлийн Бизьяа нарын 30 малчин буриадыг болохоор ганцхныг нь амь хэлтрүүлж 10 жилээр шийтгээд бусад 29-ийг нь буудан алсан байх юм. /ОБЭК-ын энэ 20, 21-р хурлаар шийтгүүлсэн бүх хүний овог нэр, нас, хаяг, шийтгэлийн хэмжээг нь Ц.Оюунгэрэл, Ж.Л.Фолт нарын 2008 онд хэвлүүлсэн “Ногоон нүдэн лам” романы хавсралтаас тодорхой үзэж болно./

Монголын буриад нарын ихэнх нь оршин суудаг Дорнод, Хэнтий хоёр аймаг 1934 оны тоогоор 17,4 мянган буриадтай байснаас насанд хүрсэн эрэгтэй нь 6000 хүрэхгүй байсан боловч 5368 нь баривчлагдан хэлмэгджээ. Наашлаад Сэлэнгийн буриадын хувьд гэвэл Сэлэнгэ аймагт буриадууд 1920-30-аад онд ихэнхдээ Ерөө голын буриад хошуу нэртэйгээр одоогийн Ерөө сумаар оршин суудаг байсан ба 1937-38 онд насанд хүрсэн бараг бүх эрэгтэйчүүд нь баривчлагджээ. 1962 оны 1-р сард МАХН-ын ТХ-ны УТТ ба 2-р бүгд хуралд тавьж хэлэлцүүлсэн “Улсыг аюулаас хамгаалах байгууллагын ажилд гарч байсан алдаа завхралын тухай” НТХ-ны шалгалтын комиссын илтгэлд өгүүлснээр “Сэлэнгийн Ерөө сумын 2 багийн 100

орчим буриад өрхийн дотор эрэгтэй хүн ердөө 5” үлдсэн байсан байна. Мөн илтгэлд өгүүлснээр “үйлдлийн хэргийн холбогдолгүй Сэлэнгэ дэх /ДЯЯ/ хэлтсийн төлөөлөгч Лувсангийн Дамбыг буриад хүмүүсийг барихаас татгалзлаа гэж 1938 онд буудан алж байжээ”. Түүнийг “барих буриадгүй болсон” гэж ярьсныг нь буриадуудыг олж барихаас татгалзав гэж ийнхүү буудан алсан аж.

Эг-Сэлэнгийн буриад хошуу гэгдэж байсан Хөвсгөл, Булганы буриадууд ч дээр өгүүлснээр дээрхийн нэгэн адил хэлмэгджээ. Дархан аварга, хөдөлмөрийн баатар Дарийн Дамдин буриад тэргүүтэй аваргуудын өлгий нутаг Хөвсгөлийн Цагаан-Үүр сум харьцангуй цөөн буриадуудтай. Тус сумын 3-р багийн Халхан, Нарийн, Тохойгоор өвөлждөг Шар толгойн гэх буриадуудын эрэгтэйчүүд нь олноор баривчлагдснаас “1938 онд өвлийн идэш гаргах хүнгүй болж, Хажидмаагийн аав Санж гуай гэгч урианхай хүн тэдний өвлийн идшийг нь гаргаж өгч байдагсан” гэж 3-р багийн С.Норжид гуай гэрчлэн амьд сэрүүндээ ярьж байв.

Тийнхүү насанд хүрсэн 10 хүн тутмын 9 нь баривчлагдснаас 1944 оны хүн амын дэлгэрэнгүй бүртгэлээр Монголын буриад өрхийн 95 % нь өрхийн тэргүүлэгчгүй байсан байна.

Баривчлагдсан буриад нарын хэргийг үзэхэд, түүнчлэн баривчлагдсан 10 буриадын 9-ийг нь буудан алж, буриад нарт тийнхүү илүү чангаар хандаж байснаас үзэхэд буриадуудыг баривчлахдаа хувьсгалын эсэргүү хэрэгт үнэхээр оролцсон эсэхийг нь шалган цагаатгах уу, шийтгэх үү гэдгийг нь шийдвэрлэхийн тулд юм уу, тийм эсэргүү хэрэг байсан эсэхийг нь буюу бэлтгэгдэж байсан эсэхийг тогтоох зорилгоор тэднийг баривчилж байсан бус, тэднийг зөвхөн буудан алахын тулд л баривчилдаг байж гэсэн сэтгэгдэл төрнө. Их хэлмэгдүүлэлтээр халхчуудаас насанд хүрсэн 5 эрэгтэй тутмын 1 нь буюу 10 эрэгтэй тутмын 2 нь баривчлагдсан байхад цөөн тоотой буриад ястныг болохоор насанд хүрсэн 10 эрэгтэй тутмын 9-ийг нь баривчилж, баривчлагдсан 10 хүн тутмын 9-ийг нь буудаж байснаас үзэхэд насанд хүрсэн эрэгтэй буриадуудыг устган арилгах зорилготой, үлдсэн эмэгтэйчүүд, хүүхдүүдийг нь уусган арилгах тооцоотой байв уу гэж бодогдоно. Баривчлагдагсдын байцаалт гэдэг нь баривчлагдсан хүнийг заавал хэрэгт холбогдуулж устгуулах ганц зорилготой байлаа.

Энд нэг асуулт гарч байна. Феодал гэгдэх ноёд, язгууртнууд, тайж нар, чинээлэг амьдралтай хүмүүсийг болон лам нарыг бол ард олныг дарлагчид, тэднийг мөлжиж амьдрагчид, ангийн дайснууд, хувьсгалын эсэргүүнүүд гэсэн коммунист үзэл суртлаар устган үгүй хийх бодлого барьж байсан бол улаантан, цагаантан оросуудад хавчигдаж, ядрахдаа монгол ах дүүгээ бараадан орж ирсэн буриад ах, дүү нараа манай нам, төр 1930-аад оноос яагаад тийнхүү гэнэт үзэн ядаж, алж устгах гэх болов, уг нь тэдгээр буриадууд бол хэдийгээр харьцангуй цөөхөн тоотой ч нутгийн монголчуудыг ажил хөдөлмөрт ч, ахуй соёлд ч, эрдэм номд ч үлгэрлэж, бас ардын хувьсгалыг хийлцэж, бичиг баримтуудыг нь боловсруулалцсан хүмүүс биш билүү. Монголын анхны эмч, багш, эрдэмтэн, сэхээтнүүд нь голдуу тэрхүү цөөхөн буриадууд чинь байсан бус уу, буриадууд бол тусгаар тогтносон, хүчирхэг, нэгдсэн монгол улсаа дахин үүсгэн байгуулахыг санаархаж санаачлагчид байсан бус билүү гэсэн асуулт гарч ирнэ.

Жирийн монголчууд өөртэйгөө нэг үндэс угсаа, нэг хэл яриатай, нэг бичиг соёл, нэг зан заншил, шашин шүтлэгтэй, өөрийн үсэрсэн цус, тасарсан мах болох буриадуудыг хавчиж үзэн ядаж байсангүй ээ. Тэдний хооронд ямар нэгэн маргаан,

зөрчил гарч байгаагүй ээ. Тэгэхээр Монголын эрэгтэй буриадуудыг устгах бодлого бол Оросын бодлого байлаа. Харин Оросын энэ бодлогыг Монголын нам төр монголд уухайлан хэрэгжүүлсэн нь харамсалтай.

Оросууд яагаад манай буриадуудыг үзэн ядах болов? Орос дахь 1920-иод оны иргэний дайн, эмх замбараагүй байдал, дээрэм тонуул, өлсгөлөнгөөс зугтаан, түүнчлэн Монголыг тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж эрх чөлөөтэй орон болов гэж баярлан Монголд орж ирсэн буриадуудыг оросууд Орос орноос дайжигчид, Оросоос салж бусад монголчуудтайгаа нэгдэх гэдэг панмонголистууд, ийм панмонголист үзлийг монголчуудын дотор дэлгэрүүлж, уг үзлийг газар авахуулж, буриадчуудын дотор салан тусгаарлах үзлийг өрнүүлж мэдэх аюултай хүмүүс, тэдний энэ үзлийг дэмждэг япончуудтай нийлж болох октябрийн хувьсгалаас зугтагчид гэж үзэж, Монголын буриадчуудыг залхаан цээрлүүлэх, устгах бодлогыг явуулсан юм. Нөгөөтэйгүүр Монгол улс 1921 оны ардын гэх хувьсгалаар большевик Оросын барьцаанд орж, улмаар Оросын хараат “улаан” орон болж, Монголын нам, төр нь Оросын гар хөл болсон нам, төр болж хувирсан явдал оросуудыг Монголд дураараа дургих, Монголын дотоод хэрэгт эрээ цээргүй оролцох, өөрийн большевик бодлого, үйл ажиллагааг Монголд тулгах, нэвтрүүлэх, дураараа явуулах өргөн боломж бололцоог нээж өгсөн байна. Ямар сайндаа Фриновский нар Монголын нам, төрд урьдчилан мэдэгдэхгүйгээр Монголд гэнэт орж ирж байхав? Ингээд Монгол дахь феодал, лам нар, буриадчуудын асуудлыг оросууд шийддэг болов.

Гэхдээ Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн ганц эзэн, ганц хариуцагч нь зөвхөн Оросууд биш юм. Монголын хэлмэгдүүлэлт, түүний дотор их хэлмэгдүүлэлт гэгддэг их хядлага бол Монголын нам, төр Монгол улсыг Оросын хараат болгосны гай, Монголын нам, төр Орост хэт бялдуучилж байсны үр дагавар, Монголын нам, төр Оросын атганд орж, түүний дуулгавартай зарц, гар хөл болж байсны үр дүн даруй мөн. Хараат байх, барьцаанд орох, бусдын гар хөл болох нь ийм хортой, ийм аюултай ажээ.

Манай нам, төр Хятадын хараат байсан улсаа Оросын хараат болгоод өөрөө Коминтерн ба большевикчдын гарт орсон юм. Ингээд ард түмнээ авран хамгаалах хүлээж төр барьсан МАХН Коминтерний төлөөлөгчийг Монголд урин суулгаж, дараа нь бас НКВД-гийн олон тооны сургагчдыг Монголоор дүүрэн залан ирүүлж Монголын ДЯЯ-ыг тэпнээр пиг дүүргэж, намынхаа удаа дараагийн их хурлаас “Коминтерний удирдлага, зөвлөмжийг намынхаа үйл ажиллагааны удирдамж болгож байхаар” намдаа дахин дахин даалгаж, “хар, шар харгисуудын үлдэгдлийг бүрмөсөн устган арилгахаар” намынхаа Программд оруулж, намынхаа 8-р их хурлаар “Хувьсгалын эсэргүү дайсан шар, хар ялгаагүй нийт феодал нар, Монгол ба Хятадын худалдаачид ба цагааны хулгай дээрэмчин Барон Унгерний үлдэгдлүүд /буриадчуудыг тийнхүү нэрлэжээ/ бүгдээрээ гадаадын хөрөнгөтөн ба Хятадын цэргийн эрхтний тагнуулчин этгээд даруй мөн” гэж дүгнэж, НТХ-ны 3-р бүгд хурлынхаа илтгэлд “Монгол дахь Японы тагнуулын хэргийг хэн удирдаж байсан бэ хэмээвээс мөн л буриадчууд” гэж заан ийнхүү феодал, лам нар, буриадчуудыг устгахыг уриалж, 1931.12.29-нд НТХ “Энэхүү феодалыг устгах явдлыг хурдан түргэнээр явуулж тус намын 9-р их хурал хүртэл үндсэн дор дуусгахыг” даалгасан нууц “онц тогтоол” гаргаж байв. Ингээд хууль ёсыг завхруулж, зохиомол хилс хэргээр феодал, лам нар, буриадчуудыг хоморголон

устгахад хүрээ. Хөвсгөлд томилолтоор явж байсан Хэнтийн Бат-Өлзийн Батдоржийг буриад болохоор нь баривчлан шийтгэж байсан баримтыг доктор С.Бадарч өгүүлсэн байдаг. Зарим хэт хувьсгалчид энэ хэлмэгдүүлэлтээр хэрхэн хийрхэж байсан тухай Хөвсгөлийн буриадуудын хэлмэгдүүлэлтийн талаар бичсэн өгүүлэлдээ судлаач Л.Галбаабадраа тодорхой бичсэн байдаг. Хэлмэгдүүлэлтэд идэвх зүтгэл гарган хийрхэж байсан хүмүүст нам, төр одон тэмдэг, алдар цол, албан тушаалаа хайрлахгүй хүртээн, МАХН-ын коммунист үзэл сурталд хийрхсэн тэднийг улам хөөргөн дэвэргэж байв. Энд нэг тодорхой баримт өгүүлье. Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хялганатын хүрээнээс эхэлсэн 32 оны бослогоор босогчдын өөдөөс тэмцээгүй, харин ч тэднийг дэмжсэн буюу тэдэнтэй нийлсэн гэх Хялгантын хүрээний эд хэрэглэгчдийн хоршооны нягтлан бодогч, эвлэлийн гишүүн, Их-Уул сумын уугуул, 23 настай Ш.Дондогдоржийг намын гишүүн Лувсанжамбаа цаазлахдаа түүнийг Далхын дуганын хавьд хээр аваачин Их-Уул сумын сарлаг хочит Санжаагаар туслуулан хүлж аваад, хоёр завжийг нь хутгаар ярж, амьдаар нь эрүүг нь зааж алсан байна. Ийм харгис аллага үйлдсэн Лувсанжамбааг эсэргүүнүүдтэй сайн тэмцсэн гэж цусан гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж, ардын хувьсгалын партизан болгож, Хөвсгөл аймгийн намын хорооны 1-р нарийн бичгийн даргаар өргөмжилж байжээ.

Эцэст нь дүгнэхэд Монгол дахь улс төрийн коммунист хэлмэгдүүлэлт, түүний оргил болох 1930-40-өөд оны Их хядлага бол монголын шинэхэн түүхийн хэзээ ч мартаж болохгүй хамгийн эмгэнэлт явдал. Гэмгүй, хэрэг хийгээгүй олон арван мянган хүнийг улс төрийн зохиомол хилс хэрэгт гүжирдэн гүтгэж, дайчлан баривчилж, тамлан зовоож, нотлогдоогүй, байгаагүй, хэргээр хоморголон хядаж устгасан энэ явдал бол эрүүгийн гэмт хэрэг бөгөөд тэгэхдээ Монголд урьд хожид гарч байгаагүй, Монголын бүх түүхийн хамгийн том гэмт хэрэг. Феодал, лам нар, буриад, барга, цахарыг сонгон хядсан тэр аллага бол хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогддог аймаглан устгах ноцтой гэмт хэрэг /геноцид/ мөн. Монголд ийм коммунист фашизм гарч, аймшигт хэлмэгдүүлэлт, аюултай хядлага явагдсан явдал бол юуны өмнө Монгол улс тусгаар тогтнож чадаагүй, хойт их хөршийнхөө хараат улс байсантай нь холбоотой. Гэвч Монгол улсад 1990 онд ардчилсан хувьсгал ялж /дашрамд өгүүлэхэд энэ ардчилсан хувьсгалын ялалтад Хөвсгөлчүүд ихээхэн үүрэг гүйцэтгэв/, коммунист намын ганцаарчилсан дарангуйллыг эцэслэж, коммунист дэглэмийг устгаж, олон намын тогтолцоог бий болгож, шинэ ардчилсан үндсэн хуультай болж монгол улс сая нэг жинхэнэ ёсоор тусгаар тогтнож, гадаад орны хараат улс байхаа больсон хэдий ч энэ бүхэн нь хэлмэгдүүлэлтийг гаргуулахгүй байхын баталгаа болсонгүй. Үүний нотолгоо нь 2000-2004 онд 15000 хүн үзэл бодлоороо ялгаварлагдан ажлаасаа халагдаж, ажилгүй болж, амьдрал ахуйгаараа залхаан цээрлүүлэгдсэн явдал.

Үүнээс үндэслэн улс төрийн хэлмэгдүүлэлтийг судалж үзэхэд тухайн үеийн нөхцөл байдлаас үүдэн хэлмэгдүүлэлтийн хэлбэр байдал, арга ажиллагаа өөрчлөгдөн хувирч байдаг нь харагдав. Монгол улс гадаад ертөнцөөс тасарч, “хөмөрсөн тогоон дотор” байсан 1921-1950 оны үед манай нам, төр хууль ёсыг уландаа гишгэж, дураараа загнаж, улс төрийн худал, зохиомол хэргүүдийг үүсгэн, гэмгүй хүмүүсийг баривчлан устгаж байсан бол дэлхийн 2-р дайны дараа дэлхий 2 системд хуваагдаж, шинэ нөхцөл байдал бий болж, Монголын “хөмөрсөн тогоо” хагарч, дураараа алж устгаж болохгүй болоод ирэхийн хэрээр өөрөөр сэтгэгчид,

өөр үзэл бодолтнуудыг шорон гяндан, цөллөг, хавчлага, хяналт мөшгөлтөөр болон амьдал ахуйгаар нь залхаан цээрлүүлж хэлмэгдүүлдэг болов. Харин 1990 онд ардчилсан хувьсгал ялж, Монгол улс тусгаар тогтнон, Оросын хараат байхаа больж, олон намын тогтолцоо бий болж, ардчилагдахаар хэлмэгдүүлэлт нь нуугдмал аргаар явагддаг болж, өөр нам, өөр үзэл бодолтныг далдуур хяхан хавчих, ажилгүй болгон амьдрал ахуйгаар нь хохироох, тэдний амжилт бүтээлүүдийг дарах, шагнал урамшлаас хоцроох, зөвхөн өөрийн талынхныг магтан урамшуулах, эрэлт хүсэлт, тавьсан шаардлагад нь зориуд хариу өгөхгүй дарагдуулах зэрэг хэлбэрт шилжив.

Иймд улс төрийн хэлмэгдүүлэлтийг ямар нэг хэлбэрээр гаргуулахгүй байхад нөхцөл байдлаас гадна судалгаа хийж байх, сонор сэрэмжтэй байх явдал бас чухал ажээ.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)


2008

Оргодой бодонгууд **С.Ишбалжир**
ШУТИС-ийн МИС-ийн
Зөвлөх профессор,
МУ-ын гавьяат багш,
доктор, профессор

БУРИАД ГЭЖ ХЭН БЭ?

I. Угсаатан судлалд системчлэн хандах нь: Ямарваа угсаатныг төлөвшүүлдэг хүчин зүйлсийг: гадаад (уур амьсгал, хөрш зэргэлдээ улс орон), дотоод (угсаатны оршин суудаг газар нутгийн байдал, угсаатны аж уламжлал ба зан төрх) гэж хоёр хуваадаг.

Азийн Их талын “Их монгол” гүрэн хэмээх системийн зураг



Энэхүү системийн 6 дэд системийг авч үзэхэд Монгол, Хятад хоёрын зорилго тэс өөр, харин Хятад, Тангад, Зүрчид нар хоорондоо эерэг холбоотой байхад бүх дэд систем Монголтой сөрөг холбоотой. Энэ агуу их зөрчил Монголыг агуу их гүрэн болгосон ба тэр хэмжээгээр уналтанд оруулсан. Энэ бол эсрэг тэсрэг зөрчилтэй, нэгдэлтэй байсны дагалдал мөн.

Тэгвэл Монгол угсаатныг төлөвшүүлэхэд эдгээр таван хүчин зүйл хэрхэн нөлөөлснийг авч үзье.

Эн тэргүүнд Лев Николаевич Гумилевын тухай товч өгүүлье. Л. Н. Гумилевын эцэг Николай Степанович (1886-1921) Оросын томоохон яруу найрагч, 1910 оноос яруу найраг дахь Акмеизмын (дээд зэрэглэлийн гэсэн утгатай *акме-цэцэглэх* хүч гэсэн үгнээс гаралтай) урсгалын тэргүүн байсан. Хувьсгалын эсэргүү хэрэгт оролцож байсан гэж большевикууд 1921 онд буудан хороосон. Л.Н.Гумилевын эх Анна Андреевна Ахматова (1889-1966) нь Орос, Зөвлөлтийн яруу найрагч, (Горенко овогтой орос эцэгтэй, Ахматова овогтой татар эхтэй) сэтгэл зүйд хүчтэй нөлөөлдөг шүлэг бичдэг байжээ. Мөн уран бүтээлдээ Зөвлөлтийн эсрэг үзэл тусгасан хэмээн олонтоо хэлмэгдэн шийтгүүлж байсан аж. Эсэргүү эцэг, эхтэй гэж Л. Н. Гумилевыг эхлээд Колымагийн Гулагт хорьсон. Дараа нь дахин баривчилж Цагаан далайн суваг байгуулах барилга дээр албадан ажиллуулсан түүхтэй.

Лев Гумилев Ленинградын Их сургуулийн Түүхийн анги төгссөн түүхч мэргэжилтэй, мөн угсаатны зүй, уур амьсгал судлах ухааныг нарийн судлаж угсаатан судлаач мэргэжлийг давхар эзэмшсэн. Тэрбээр “В поисках вымышленного царства”, “Этногенез и биосфера земли”, “Древняя Русь и Великая степь”, “Гунны”, “Черная легенда” зэрэг угсаатны түүхийн тухай өгүүлсэн ер бусын бүтээлүүдийг туурвисан.

2. Төв Азийн өндөрлөг: Хойд талдаа Саяны нуруу, Байгаль нуурын баруун зүүн бие, Шилка, Амар мөрний хөндий. Урд талдаа Их цагаан хэрэм, Зүүнгарын хотгорын хойд хэсэг, баруун талдаа Алтай, Тарвагатайн нуруу, зүүн талаараа Солонгосын хойг хүртлэх Хангай, их тал, өргөн говь хосолсон 5 орчим сая ам дөрвөлжин км талбайтай, далайн түвшнээс дунджаар 1000-1500 м өндөр энэ газар нутгийг Төв Азийн өндөрлөг хэмээдэг. Төв Азийн өндөрлөгийн хойт тал нь Хойт Герман, өмнөд Англитай нэг өргөрөгт, урд тал нь Грек, Итали, Хойд Испанитай нэг өргөрөгт оршдог хэдий ч эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай.

Дээр дурьдсан Герман, Англи, Грек, Итали, Испани зэрэг орнуудын уур амьсгал нь ихээхэн чийглэг, урин дулаан, хөрс нь үржил шимтэй байхад Төв Азийн өндөрлөгт хуурай, хүйтэн урт өвөлтэй (заримдаа их хүйтэн өвөл – 40 хэмд хүрдэг), богино, халуун зуны улиралтай (заримдаа +40 хэм хүртэл халдаг), салхи шуургатай, хавсарган хүйтэн урт хавартай, дулаан дэлгэр богино намар зэрэг жилийн дөрвөн улиралтай. Хавар хур тунадас багатай, салхи ихтэй, шороон шуургатай, зун богино халуун +10 хэмээс +20 хэмд хэлбэлзэх боловч заримдаа +40 хэмд хүрэх нь бий. Хамгийн халуун, хамгийн хүйтэн өдрийн температурын жилийн зөрөө 20 хэмд хүрдэг. Нэг хоногийн өдөр шөнийн температурын зөрөө -20t хэмээс +25t хүрдэг. Хур тунадас багатай учир агаар хуурай. Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн учир агаар сийрэг, нарны илч хурц. /”Монголын нэвтэрхий толь”-оос/. Үүнээс шалтгаалан элдэв өвчин, түүний дотор халдварт өвчний нян үрждэггүй.

Гол мөрнүүд нь Хойт мөсөн далай, Номхон далайн усны хагалбарт багтдаг. Өөр улсаас Монгол орныг дайрч урссан гол мөрөн байхгүй. Ийм учраас Төв Азийн өндөрлөгийн ус агаар цэвэр ариун.

Монгол нутгийн тухай их зохиолч В.Инжиннаш ийн бичжээ. “Манай монгол газрын муут гаргаж тоочваас тэргүүнд, газар орон нь шороон хөрсгүй, салхи дэгдвээс шар хомог /тоос–С.И/ хийсэн дэгдэж тэнгэр газар нийлнэ, бас уул нь оройгүй, хад нь үндэсгүй, хаврын шуурга улайтал шуурч өөр газарт дэвшин эчмой /шилжинэ–С.И/. Хоёрдугаарт, усан урсгалгүй, зуны хурын ус ч битүү нуур тунамалд хурмой. Гуравдугаарт, цагийн амьсгал нь хүйтэн жихүүн, дөрөвдүгээрт, нарны ээлт хол алс, цас хяруу эрт, үрс жимс ургахгүй” гэхчлэн бичжээ. Төв Азийн өндөрлөгийн төв хэсэг – Монгол нутгийг их зохиолч В. Инжиннаш ингэж төсөөлсөн байх юм.

Хур бороо элбэгтэй, үржил шимтнй газар нутагтай, ой мод, ургамал элбэгтэй Хятад оронд өсч бойжсон Инжиннаш төрөлх Монгол нутгаа хараад сэтгэл дундуур байсан бололтой.

Төв Азийн өндөрлөгийн Гүн Галуутай нутгийн хүү Д. Нацагдорж:

Хэнтий, Хангай, Саяны өндөр сайхан нуруунууд
Хойт зүгийн чимэг болсон ой хөвчин уулнууд
Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд
Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон


Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд
Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд
Хөвсгөл, Увс, Бойрын гүн цэнхэр нуурууд
Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд

Энэ бол миний төрсөн нутаг


Монголын сайхан орон... хэмээн шүлэглэсэн нь Инжиннашаас илүү

зөв тусгасан хэрэг болжээ.

3. Агаар хэрхэн хөдөлгөөнд ордог вэ? Дэлхий агаарын бүрхүүлтэй, түүнийг агаар мандал /атмосфер/ гэдэг. Агаар мандал байнга хөдөлгөөнд оршдог. Учир нь нар агаарыг экватор орчимд ихээр, 2 туйл хавьд багаар халаадаг. Үүнээс агаарын



хөдөлгөөн үүсдэг. Зураг дээрх А, Б хоёр сав дээгүүр доогуураа холбоотой. А савыг халаахад ус дээшээ, Б савыг мөсөн дотор хийхэд хөрч доошлон усны эргэлт үүсгэдэг /Зураг 2/. Мөн энэ маягаар агаарын эргэлт үүсдэг. Үүнийг салхи гэнэ. Салхи шулуун замаар үлээдэггүй, уул нуруу зэрэг элдэв хөдөлгөөнд ордог. Үүнийг циклон гэдэг. Их халсан газрын агаар их даралттай болж дээшилдэг. Бага халсан газарт даралт багасч



саадаас болж эргэх


доошилдог. Их даралттай үед /В/ үед салхи гадагш салхилдаг. Үүнийг антициклон, бага /Н/ даралттай үед дотогш салхилдаг. Үүнийг циклон гэдэг. Энэ бол агаар хөдөлгөөнд орох эхний хэлбэр юм /Зураг 3/. Хоёрдахь



хэлбэр нь дэлхийн эргэлтээс шалтгаалдаг. Тухайлбал, А байрлалаас хойт зүг рүү чиглүүлэн пуужин харвахад хэсэг хугацааны дараа В байрлалд ирсэн байна /Зураг 4/. Энэ нь дэлхийн эргэлтээс болжээ.

Ийнхүү дэлхийн эргэлтээс болж бүх агаар мандал баруунаас зүүн тийш урсдаг. Үүнийг агаарын урсгал гэнэ. Агаарын дээд давхаргад агаар жигд урсдаг бол доод давхаргад циклон үүсгэдэг /Зураг 5/. Агаарын урсгал, салхи хоёр ямарваа орон нутгийн, түүний дотор Төв Азийн өндөрлөгийн уур амьсгалыг бий болгодог. Үүний тухай хойно өгүүлэв.


4. Төв Азийн өндөрлөгт хур түнадас хаанаас ирдэг вэ? Уур амьсгал судлаач Л.Н.Гумилевын бичсэн номыг уншаад ойлгосон хэмжээгээрээ тайлбар зураг хавсаргав. /Зураг 6/.



Хур тундас, газрын хөрсний үржил шимтэй байдлаар нь Төв Азийн өндөрлөгийг Их Хянганы нуруунаас баруун, зүүн тийш хэмээн хоёр хуваалтай. Хянганы нуруунаас баруун тийш орших Их талд хур тундас, зүүн талд ердөө 1000 км-ийн цаана байх Шар тэнгисээс бус 10,000 км-ийн цаана байгаа Атлантын гадаад далайгаас ирдэг аж.

5. Соёл иргэншлийн тухай товчхон: Хүн төрөлхтний түүхэнд одоогоос 5000 – аад жилийн тэртээ Тигр, Евфрат хоёр мөрний хөндий - Месопотамид /1/, Нил мөрний савын адаг - Миссир оронд /2/, Инд мөрний хөндий - Энэтхэгт /3/, Шар мөрний савын доогуур, дунд биеийн Нанхиадад /4/ анхны соёл иргэншил (civilization - хотын соёл) үүсчээ. Одоогоос 4500-3100 жилийн өмнө Европ дахинд Эллад оронд, 2700 жилийн өмнөөс Ром гүрэнд дамжин хөгжих болсон. Азид, Шар мөрний доод, дунд хэсгийн соёл иргэншил цаашид хөгжиж одоогоос 3400 жилийн тэртээд өндөр соёлт Инь хэмээх боол эзэмшигчдийн улс байгуулагджээ. Инд мөрний хөндийн Жагар оронд одоогоос 4500-3500 жилийн тэртээд Хараппын соёл иргэншил үүсэн хөгжжээ /Зураг 7/. (The Larousse Desk Reference. Page 312).

Эдгээр дөрвөн агуу их соёл иргэншлийн голомтоос салбарлан:



- Тариачны соёл иргэншил (Египет, Энэтхэг, Хятад)
- Хотын соёл иргэншил (Вавилон, Эртний Афин, Ром)
- Далайн соёл иргэншил (Венец, Голланд, Испани, Англи)
- Нүүдлийн соёл иргэншил (Түүрэг, Монгол, Араб) гэх мэт.

Мөн газар нутгаар нь

- Долоон голын (Балхаш нуурт цутгасан долоон голын нутгийн угсаатнууд)
- Өмнөд Америкийн Инкачуудын гэх мэтээр олон салбар соёл иргэншлийг дурдаж болно.

Нүүдлийн соёл иргэншлээс Төв Азийн өндөрлөг дэх Их талын Монголчуудын нүүдлийн иргэншлийг онцгойлон нэрлэж болох юм. Учир нь энэхүү соёл иргэншил нь бэлчээрийн МАА, ан агнуур, дээрмийн дайн гэсэн “тулгын гурван чулуу”-н дээр тулан үүсэж хөгжин Евразийн 3/4 дээр “Монгол мандал”-ыг цогцлоон байгуулсан түүхтэй. Чингэтэл, Төв Азийн агуу их нүүдлийн соёл иргэншил хаанаас үүссэн нь одоог хүртэл шийдэгдээгүй асуудал. Энэ талаар олон янзын тайлбар, таамаглал буй. Тухайлбал, хятадын түүхчид нүүдлийн иргэншлийг Шар мөрний хөндийн соёл иргэншлээс салбарлан үүссэн гэж үзсээр ирсэн. Монголын шинэхэн үеийн түүхч, эрдэмтэн, улс төрийн зүтгэлтэн Анандын Амар (1886-1941) Энэтхэгийн Инд мөрний хөндийд нутагтай арийчуудаас гаралтай гэж шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт хийжээ. Сүүлийн үед Тигр, Евфрат мөрний хөндий байгаа Наян Наваа нутгаас үүсэлтэй гэж батлах хүмүүс бий боллоо. /эдгээрийн тухай дээрх өгүүллээс үзнэ үү/.

Тайлбар: агаарын урсгал, салхи хоёр бол өөр өөр ойлголт. Агаарын урсгал дэлхийн эргэлтээс, салхи атмосферийн температураас тус тус хамааран үүсдгийг дээр дурдсан билээ. Пиренейн хойг, хойт Африкийн баруун талд Атлантын далайд үүссэн борооны үүл агаарын урсгалыг даган зүүн тийш урсана. Ингэхдээ Пиренейн уулсын систем, Альп, Апенин, Балкан, Карпатын уулсын систем, Кавказын уулс, Ил Тарвагатай, Алтайн нуруунд ихэнх хур тундасаа бороо болгон алдаад багахан хэсэг нь Их талд чийг авчирч ногоо ургаж, мал сүрэг таргалж, өвсөн тэжээлт зэрлэг ан амьтад үржин олширдог. Энэ нүүдэлчид тайван тухтай амьдардаг. Харин зүүн Европын төв, хойт хэсэгт ган болж, Ижил, Урал мөрний ус татарч жижиг гол горни ширгэснээс Каспийн тэнгисийн усны түвшин доошилдог. Атлантын далайн чийгтэй агаар хойгуур Төв Европ, Сибирийг дамжин урсахад ширгэсэн гол горхи, Ижил, Урал мөрөн үерлэж Каспийн тэнгисийн усны түвшин дээшилдэг. Харин Их талд хур тундасгүй ган болдог. Ган болоход Их талын нүүдэлчид мал хунараа туун урагшаа Тангад, Цагаан хэрэм баригдаагүй байхад Цинь, Хань улсын нутаг руу, зүүн тийш Хянганы нурууг даван Зүрчдийн нутаг руу бэлчээр хайн нүүдэллэхэд нүүдэлчдэд угаасаа дургүй нутгийнхан тэднийг хөөж, улмаар цуст мөргөлдөөн үүсдэг байв.

Хянганы нуруунаас зүүн тийшхи тал нутагт хур тундас хажуудах Шар тэнгис, Япон тэнгисээс ирэх учир хур бороо элбэгтэй, харьцангуй зөөлөн уур амьсгалтай, үржил шимт хөрстэй.

Атлантын далайгаас зүүн тийш чиглэсэн хур тундастай агаарын урсгал 300 жилийн давтамжтайгаар хойш урагш болдог гэж Л.Н.Гумилев тэмдэглэжээ. Үүнээс үндэслэн тэрбээр, “*нүүдэлчид цусанд дуртайдаа хөршүүдтэйгээ дайтаж байдаг бус амьдралын шаардлагаар дайн хийдэг*” гэж сонин дүгнэлт хийжээ. Энэ дүгнэлт

сонин боловч эргэлзээтэй мэт санагддаг. Газар нутаг булаалдаснаас болоод дайн дажин үүсэхийг алийг тэр гэх вэ? Харин 300 орчим жил болоод л их дайн болж байсан гэдгийг судалгаагаар батлах хэрэгтэй.

6. Нүүдлийн соёл иргэншил: Дэлхийн 5 тивийн олон газар оронд нүүдэллэн амьдардаг угсаатан олон. Төв Азийн нүүдэлчид бол бусдаас онцгой бөгөөд бэлчээрийн МАА, ан агнуур, дайн тулаан гэсэн “тулгын гурван чулуу”-н дээр оршиж байдаг. Халимагийн түүхч Эренжен Хара-Даван “Цэргийн соёл иргэншил” гэж нэрлэжээ. Мөн алив хэргийг төрийн Их хуралдай дээр хэлэлцэн шийдвэрлэдэг, хааныг их хуралдайгаар сонгодог байсан зэрэг нь ардчиллын хэлбэр байсан учир Л.Н.Гумилев Төв Азийн нүүдэлчдэд “Цэргийн ардчилал” байсан гэж бичжээ.

Хааны орд, Нийслэл хүрээ нь хүртэл Хангайн нурууны зүүн суга – Орхон голын сав, Хэнтийн нурууны баруун суга – Хэрлэн голын сав энэ хоёрын хоорондох уужим талд нийслэл хүрээ, хааны ордны хамт нүүж явдаг байжээ. Энэ бүхэн нь дэлхийд хосгүй Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийг бүрдүүлж байжээ.

Хосгүй нүүдлийн иргэншлээ сэргээе гэж ярьж байгаа хүмүүст хандаж хэлэхэд өнөөдөр МУ-ын хүн амын 1/3 – ээс илүү нь ганцхан Улаанбаатарт, 2/3 нь бусад том жижиг хот суурин газар суурьшин амьдарч байна. Ан агнуур, дайн дажин эдийн засагт нөлөө үзүүлэхээ больсон одоогийн нөхцөлд нүүдлийн соёл иргэншлийг сэргээх тухай ярих нь утгагүй л дээ.

Төв Азийн “Нүүдэлчин Монгол” гэдэг системийн дэд системүүдийг тус тусад нь товч өгүүлбэр.

Билчээрийн МАА: халуун хүйтэн, эрс тэс уур амьсгалтай, жилийн дөрвөн улиралтай Төв Азийн өндөрлөгт нүүдэлчдийн адгуулдаг таван хошуу мал нь тэжээлээ өөрөө олж иддэг зэрлэг амьтны шинж чанартай, жижиг биетэй. Том биетэй малын биеийн гадаргуу мөн л их байх учир хүйтэнд гадагш дулаан алдах талбай ихэсдэг. Иймд Төв Азийн нүүдэлчдийн мал нь өвлийн хүйтэнд, түүнчлэн идэш тэжээл хомс хаврын хавсрагатай үед дулааны алдагдал багасгах жижиг биетэй, эдэлгээ даах биеийн тэнхээ сайтай байдаг.

Эх орны дайны ахмад дайчин, Зөвлөлтийн армийн хошууч, их бууч Юрий Николаевич Кладухин үүнийг бичигчид: “Миний үхэр бууг өвлийн хүйтэнд Карпатын уулан дээгүүр Монгол морь л чирж гаргасан. Манай сайн угсааны том морьд хүйтэнд даараад хамрын ханиад хүрээд нус нь гоожно. Бас олон шуудайтай овъёосыг нь авч явахгүй бол өлсөөд үхнэ. Харин монгол морь бол хүйтэнд тэсвэртэй, урд хөлөөрөө цас мөс цавчаад дороос нь өвс хагд олоод иднэ. Гуядаад байхад бүх хүчээ шавхан зүтгэж чадна. Үнэхээр дэлхийг байлдан дагуулах унаа юм гэдгийг мэдэрсэн” хэмээн ярьж билээ.

Монголчууд хонины арьс элдэж дулаан дээл хувцас оёдог. Үхрийн арьсыг элдэлгүй хатааж бэгтэр хуяг хийдэг. Хонины ноосоор гэрийн эсгий, ширдэг оёдог. Мах, цагаан идээг хүнсэнд хэрэглэдэг. Удаанаар хадгалахад үл муудах борц, шар тос, хуурай сүү, ааруул, хурууд хийдэг. Нэг үгээр хэлэхэд иргэдийн ба цэрэг дайны хэрэгцээг бүрэн хангах бүтээгдэхүүн бэлтгэдэг. Энэ талаар Монголын эрдэмтдийн судалгаа арвин их бий.

Ан агнуур: Төв Азийн өргөн удам нутаг эртнээс нааш элдэв ан амьтнаар арвин баялаг байлаа. Адгуус амьтдыг ганц нэгээр болон хомроглон авлаж амин зуулгадаа нэмэрлэх явдал нь нүүдэлчдийн амьдралын салшгүй хэсэг болдог байв. Төрийн ав хомрогын үед тулалдааны дохио тэмдгийг ашиглах сургууль хийлгэдэг. Ер нь

Чингис хааны “дайсны 10 цэрэгтэй тэнцэх 1 цэрэг, 100-тай тэнцэх 10 цэрэг” хэмээх цэргийн урлагийн нэг нууц нь тулалдааны дохиог гарамгай ашиглаж шуурхай удирдлагыг сайн зохион байгуулдагт оршиж байжээ.

Дайн дажин: том жижиг дайн тулаан нь Төв Азийн нүүдэлчдийн аж төрөх ёсны салшгүй нэг хэсэг болж ирсэн ба дайны олз омог нь ялагчдын орлогын чухал хэсгийг бүрдүүлдэг байв.

7. Хор, Хори, Монгол, Буриад: Буриадын тухай анхны мэдээг Сибирийг эзлэн дагуулагчид 1609 онд хүлээн авчээ. Сибирийг эзлэн дагуулагчид, тэдний араас нүүн ирж суурьшигчид Байгалийн баруун, зүүн биеийн номхон хүлцэнгүй оршин суугчдыг “браты”, “братские”, “братские люди” гэхчлэн нэрлэдэг байсан. Чухам үүнээс “Буриад” гэдэг нэр үүсчээ. Түүнд “Буриад ястан бүрэлдсэн нь” гэдэг гарчигтай, XVII зууны газрын зургийг хавсаргажээ. (2.173, 179)

“Буриад” гэдэг шинэ угсаатны “түлхэлт” болж байгаа бол олон жижиг омог, аймгаас бүрэлдсэн байх ёстой. Зүүн талдаа Их Хянганы нуруу хүртэл, баруун талдаа Ил Тарвагатайн нуруу хүртэл, урд талдаа Их Цагаан хэрэм хүртэл, хойт талдаа Байгал нуурын зүүн баруун бие, Енисей мөрний эхэн хүртэл өргөн уудам нутагт оршин тогтнож асан Хүннү гүрэн МЭ I зуунд задран унахад түүний орыг залгаж Сяньби, Жужаан, Түрэг зэрэг улсууд ээлж дараалан байгуулагдаж иржээ. Чингэхдээ, Түрэгүүд өмнөх угсаатнуудаасаа өндөр соёлтой байсан учир одоо хүртэл мэдэгдсээр буй гүн ул мөрийг үлдээжээ. Энд, Түрэг гаралтай газар усны нэрийг дурдая.

Алтай – Алт+тау – алаг уул /тау-уул. Түрэг хэлээр/

Хэнтэй – Кен-тау – баялаг уул

Хянган – Кыйни – аадарт

Байгал – бай-куль – баян нуур /куль-нуур. Түрэг хэлээр/

Хөвсгөл – коп+су+куль – их уст нуур

Увс – Уп+су – гашуун ус

Хяргас – кыргы+су – хөдөөний ус

Тайлбар: “ус”-ыг уйгуржин монгол бичгээр “усу” гэж бичдэг. Халх Монгол хэлээр эцсийн “у”-г авч “ус” гэдэг бол Түрэг хэлтнүүд эхний “у”-г авч “су” хэмээдэг.

Байгалын баруун, зүүн биед амьдарч байсан омогт: хориуд, эхирисүүд, хонгодорууд (*өөрсдөө бид Хонгирад аймгаас гаралтай гэдэг. Эдгээр гурван аймаг хоорондоо угсаа гарвалын холбоотой. Үүнийг хойно тодорхой дурьдна*), баргууд, хамнигад, сонгоолууд, үзөөнгүүд, ашавгад, алайрууд, боохонууд зэрэг олон омог аймаг амьдран сууж 1207 онд Их Монгол улсын бүрэлдэхүүнд багтаж байгаад 1691 онд Өндөр гэгээн Занабазар тэргүүтэй Ар Монголын ноёд ихэс Манж Чин гүрэнд дагаар ороход, тэр үес нэн нэн хүчирхэгжин мандах болсон хаант Орос улс Сибирийг эзлэн дагуулах болсон үеэс буюу XVII зуунаас “Буриад” (Брат) гэгдэх болжээ. Иймд, XVII зуунаас өмнөх Монголын түүх судлалд “Буриад” гэх нэрийтгэл нэр үгийг хэрэглэхгүй байх нь үнэнд нийцэх буй заа.

8. Түүхэн баримт: I. Монголчуудын дээд үе хэн байв? Буриад улсын “Угай зам” /2006. 6.16/ сонинд түүхийн ухааны доктор Б. Дашибаловын бичсэн “Откуда вышли предки Монголов” гэсэн өгүүлээс доорх ишлэл авъяа. Түүнд, “монголчуудын гарал үүслийн тухай: анх үүсч буй болсон газар нутагтаа байгаа “автохтонууд” (язгуур нутгийн хүн ам-С. И.), Төв Азийн өндөрлөгт өөр газраас

шилжин ирж суурьшсан “аллохтонууд” (шилжин суурьшсан хүн ам-С.И.) гэсэн хоёр янзын таамаглал байдаг. Энэ хоёрын аль нь зөв болохыг археологи, антропологи, аман зохиол судлал, хэл шинжлэл зэрэг олон шинжлэх ухааны ололтыг генетикийн судалгаатай хослуулан судалж дээрх асуудлыг шийдэх хэрэгтэй. Монголчуудын түүхийг анхлан судалсан эрдэмтэд Төв Ази бол Монголчуудын уугуул нутаг гэж үзэж байв. XIX зууны эцэст Монгол орноос олдсон Руни бичгийн дурсгал, гэрэлт хөшөө, хүн чулуудын дурсгалаас үзэхэд тус оронд нэгэн цагт Түрэгүүд амьдарч байжээ. Их талын газар нутгийн болон ан амьтдын нэрсийн нилээдийг Түрэг хэлээр нэрлэсэн болох нь тогтоогдсон. Үүнээс үзэхэд Монголчууд Их талыг Түрэгүүдээс сүүлд эзэмшсэн болох нь батлагдав” гэхчлэн бичжээ.

Монголчуудын дээд үе хэн байв? гэх асуултанд орчин үеийн угсаатны онол тодорхой хариулт өгч чадаж байгаа. Тухайлбал,

- Хүн хүнээсээ төрдөг лүгээ нэгэн адил алив угсаатан угсаатнаасаа л төрдөг
- Хүн төрж, өсөж, нас бие гүйцэж, хөгширж, зөнөж үхдэг лүгээ нэгэн адил угсаатан төрж, өсөж, мандан бадарч, хөгширч, зөнөж, депопуляци /өөр угсаатан/ болж сөнөдөг.
- Хүн хамгийн их нь 130 орчим, дунджаар 70 жил насалдаг бол угсаатан хамгийн дээд тал нь 1500, дунджаар 1000 жил насалдаг.
- Нэг эхээс ах дүү олуул төрдгийн адил нэг томхон угсаатан депопуляци болоход олон угсаатан төрдөг.

Угсаатны энэхүү онолд тулгуурлан Монголчуудын дээд үеийг тогтоох оролдлого хийж үзье. А.Амарын “Монголын товч түүх”-д дурьдсан нэгэн сонирхолтой санааг энд ишлэе. “...Грум-Гржимайлогоос өгүүлсэн нь: Чингис хааны үеэс урьд хоёр мянган жилийн үед Азийн дотор олон улс, олон аймгууд ээлжлэн халалцсаар ирсний дотор Монгол хэлээр хэлэлцэгч овог аймгууд магад оролцон явсан нь сэжиггүй үнэн хэрэг хэмээвэл зохино” гэжээ. Үүнд, Төвдийн нэрлэдэг “Хор” /манай түүхчид “Хор Монгол” гэдэг. С.И./, нанхиад нарын хэлдэг “Ху” нь /”Ху” буюу Хүннү/ нэг төрөл угсаатан болох нь дамжиггүй. Монгол үндэстэн /Монголын өвөг-С.И./ мөн хэмээн таньж, Монголын түүх бичихдээ үүгээр үндэс болгож зохиосон байнам. Энэ ч мөн аргагүй үнэнтэй хэрэг бөгөөд Дорнод Азийн түүх судруудад тэмдэглэгдсээр ирсэн гэрч баримт бүхүй хэрэг мөн болно.

Үүнд, Монгол үндэстэн нь дээр дурьдсан олон нэр ба ялангуяа “Ху” /Хор-С.И./ хэмээх нэрээр нэрлэгдэж хэдэн мянган жилийн өмнөөс эхлэн Дорнод Азийн түүхэнд тэмдэглэгдсээр ирсэн явдал нэгэнт илт болох тул одоо Монголчууд чухам хаанаас үүсэн гарсан болохыг олж мэдэх хэрэгтэй болно. Үүнд, хоёр зүйлийн өгүүлэл байдаг бөгөөд нэг нь: Монголыг Нанхиадаас гаралтай гэдэг ба нөгөө нь баруун зүг Энэтхэг буюу Түрэгээс /Түрэгээс гэдгийг орхиж болно-С.И./ гаралтай гэдэг ажээ. Энэ хоёр саналыг одоо хүртэл шалган боловсруулж тасалсангүй, адил бусаар өгүүлсээр бөгөөд энэ тухай мөн ч шууд таслан өгүүлэх аргагүй боловч олон түүхэн дэх аман үг дээрх зарим өгүүлүүдийг авч улам улмаар шинжлэн боловсруулахад хэрэглэгдэхүүн болсугай хэмээн дорх зүйлүүдийг бичивэй.

1. Нанхиад нар бол дээр дурьдсан Хуньюй ба Шуньвэй зэрэг олон аймгуудыг Нанхиадаас гаралтай гэх учир Монголыг тийнхүү Нанхиадаас гаралтай гэдэг ажээ. Үүнд, тэдгээр олон аймгуудыг нанхиадууд тэр үед цөмийг гадаад улс гэж үзэж

байсан нь тэдний түүх судруудад тодорхой бөгөөд, үүний тухай ганц нэг зүйлийн баримт авч өгүүлбэл, тэдгээр аймгууд Нанхиад улсыг ямагт довтлон сүйтгэх тул тэр үед Вэй ван цэрэг бэлтгэж, тэдгээр гадаад улсыг сэргийлэх бөлгөө гэснээс илэрхий болно. Нанхиад нь Хуан Ди хааны үрс олныг авч, умард газар очоод Монголтой нийлэв гэсэн бол ... тийнхүү Монгол үндэстэн болов хэмээх нь хараахан сэжигтэй байна.

Үүнд, Монгол үндэстэн зүс царайны байдлаар хэдий Нанхиадтай төсөөтэй мэт боловч хэлний талаар бодвоос чанх өөр. Монгол үндэстэн хэрэв тийнхүү Нанхиадаас тасарсан нь үнэн ахул эрхбиш хэлний талаар ойр дөхөм байх агсан бөгөөтөл огт ойртохгүй байхаас гадна, анхан үедээ Нанхиад хэлтэй байгаад эцэстээ мартав хэмээн болох боловч, бас Монгол хэлийг сүүлийн үед шинээр зохиож сурав хэмээж үл болно. Учир иймийн тулд эрт балар цагаас нааш Монгол хэлээр хэлэгч нэгэн хэсэг үндэстэн байсан нь илэрхий хэрэг тул Монгол үндэстнийг тийнхүү Нанхиадаас тасран гарав хэмээх нь хараахан ташаа өгүүлэл болох мэт санагдана.

2. Монгол ийнхүү Нанхиадаас гаралтай бус болбоос өөр чухам хаанаас гаралтай вэ? гэвэл эртнээс нааш Монгол үндэстний аман өгүүлэл ба өөрсдийн түүх зохиолууд дотроос Монголын уг гаралыг баруун зүгээс ирсэн хэмээдэг хийгээд бас ч Чингис хааны хориод үеийн дээд өвөг Бөртэ Чино баруун зүгээс ирэв хэмээсэн байх бөгөөд Түвэд, Энэтхэг хаадын үр салбар мөн хэмээжээ /үүнийг хойно тодруулав-С.И./. Үүнд, Бөртэ Чиног чухам Түвэд, Энэтхэгийн хаадын удам угсаа мөн гэж итгэх баримтгүй боловч тийнхүү баруун зүгээс ирсэн хэмээх бөгөөд Энэтхэг угсаатай гэж хэлдэг нь эрхбиш нэг учир шалтгаантай байж болох амуй.

Грум-Гржимайлогийн зохиолын дотор эртний балар цагт биеийн дүрс хэлбэрийн төлөв нь өдгөөгийн Монгол аймгийн хүнтэй төсөөтэй нэгэн аймаг улс Сэлэнгэ мөрөнг уруудан орж ирсэн байна хэмээжээ /ишлэл төгсөв/.

Тайлбар: Тэднийг Энэтхэг, Түвдээс шилжин ирж байгаа хүмүүс гэж үзэх түүхэн баримт ч алга, логик үндэслэл ч мөн бага. 714 оны Түрэг-Уйгурын дайнд ялагдсан Уйгурууд, Хорууд Түргийн хаант улсын цэргийн жанжны төв өргөө рүү хойшоо зугтаахгүй, харин 742-748 онд Уйгурууд, Карлукууд, Басмалуудын довтолгоонд ялагдсан /зураг үз/ Түрэгүүд л Сэлэнгэ, Орхон голыг уруудан зугтаасан байх магадлалтай. /ишлэл төгсөв/. Тэд нар Хангайн нуруунд амьдарч байсан Түрэгийн үлдэгдэлүүдтэй нийлж Найман аймаг болсон байх ч магадлалтай. Цааш, А.Амараас ишлэлийг үргэлжлүүлье. Үүнд, Монгол үндэстэн /Сэлэнгэ мөрнийг уруудсан аймгийг хэлж байна-С. И./ эрхбиш баруун зүгээс ирсэн байж болзошгүй бөгөөд энэ тухай манай дорно дахины олон түүх ба аман үг дээр байдаг зүйлүүдээс авч өгүүлэхэд Энэтхэг, Түвэд нар бол Монголыг эртнээс нааш Хор буюу Согбуу /Түвэдүүд Монголчуудыг бас ийн нэрлэдэг/ хэмээн нэрийднэ. Тэрхүү Хор буюу Согбуу хэмээх үндэстэн нь Энэтхэгийн баруун хойно бүхий Моугал хэмээх нэгэн аймгаас тасарч зүүн зүгт очиж суусан гэдэг бөгөөд энэ тухай зохиолуудад Түвдийн баруун хойт “Арий” хэмээх орон ба Ладаг хэмээх их цаст уулыг өнгөрвөл Энэтхэгийн дотор багтсан Монгол аймгуудын Их Ху хан гэгч байсан орон бөгөөд түүнд Энэтхэг (Жагар) хийгээд Хор, Сог хэмээх Монгол үндэстэн холилдон байсан ба мөнхүү Арий Ладагаас баруун зүгт Гамгари хэмээх их усны дэргэд Сема Хэ хэмээх мусульманы их хот байсан бөгөөд түүний зүүнд Могал ба Сог хэмээх Монголын их орон байв. (ишлэл төгсөв. 24. 22, 24). Энэ ишлэл ба уг номын

нэгдүгээр бүлгийг дуустал Түвд хэлээр бичсэн түүхийн номоос А.Амар авч бичсэн болох нь тодорхой.

Дэлхийн аль ч оронд, ялангуяа их гүрнүүдэд түүхийг гуйвуулах явдал байсаар байгаа. Шарын шашин ноёрхож байхад Чингис хааныг Очирваанийн хувилгаанд ч бид дэвшүүлж байлаа. Социалист хэмээх тогтолцооны үед анги намаар туйлширч дарлагч ангийн “алуурчин” гэдэг тодотголыг ч хэрэглэж үзлээ. Одоогийн ардчилсан хэмээх тогтолцооны үед Монголчууд бид, Чингис хаан дээд тэнгэрээс гаралтай гэж ярих болсон нь үндэсний дээрэнгүй үзэл рүү халтирч байгаагийн шинж мөн.

Түүхч, эрдэмтэн А.Амар “...дээрх зарим өгүүллүүдийг авч улам улмаар шинжлэн боловсруулахад хэрэглэгдэхүүн болгосугай хэмээн доорх зүйлүүдийг бичвэй” гэж хойч үедээ зориулан бичсэн Монголын түүхийн талаар анхаарал татсан асар их мэдээг агуулсан энэ жижиг номд бид зохих судалгаа хийхгүй байна уу даа гэж бодмоор.

Үүнийг бичигч надад А.Амарын “Монголын товч түүх”-ийг Нууц товчооны дэргэд тавимаар санагддаг. Нууц товчоо бол он дараалсан түүх – уран зохиолын төрлийн бүтээл бол А.Амар, Монголын түүхэнд шинжлэх ухааны үндэстэй хандах анхны оролдлого хийсэн. Тэр хэлэхдээ: “ер аливаа нэгэн түүх хэмээгч нь аль нэг мэргэн өгүүлэгч ба мэргэн зохиогч хүний оюун саналаас зохиогдон гарах бус, чухам түүний явсан явдал мөрийг өгүүлэх хэрэг болой” гэжээ. Энэ бол Монголын түүхийг бичихдээ шинжлэх ухааны үүднээс хандахыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Монголын түүх судлалын шинжлэх ухааны үндсийг тавигч гэж үзэх бүрэн үндэстэй.

Тэгвэл, Монголчууд Энэтхэгийн “Арий”-аас гаралтай гэж А.Амарын дэвшүүлсэн саналыг тал талаас нь судлах нь чухал байна. Арийчууд гэдэг нь Энэтхэг Европын, эн тэргүүнд Энэтхэг Ираны хэлний бүлэгт багтдаг ард түмэн Энэтхэг, Пакистан, Түвдийн нутгаар урсдаг Инд мөрөн, түүний баруун гарын Шайок, зүүн гарын Панжинад цутгалангуудын хөндийн эхэн хавийн нутагт эртний Арий нар оршин нутаглаж байв. Хожмоо Германы фашистууд Арийчуудыг Германчуудын өвөг дээд үндэстэн гэж үзэх болсон төдийгүй дээд зэргийн цэвэр арьстан гэдэг үзэл баримтлал боловсруулан хэрэгжүүлж байв.

Айл болгон өөрийн угийн бичгийг хөтөлдөг, хүн бүрт унасан газар угаасан ус – тоонот гэж байдаг. Тэгвэл угсаатан бүрт угийн бичиг хөтөлж анх үүссэн “тоонот” нутгийг тогтоож болох нь ээ. Монгол угсаатны угийн бичиг, угсаатан болгоны нь бүрэлдэн үүссэн газар нутгийг тогтоохыг оролдъёо.

1. Хүн төрөлхтний соёл иргэншлийн нэгэн өлгий Инд мөрний эхэн хэсэгт орших Арий нутгийн Арийчууд (А.Т. Ө хэддүгээр зуун бэ?)

2. Түвдийн өндөр уулсын системийн ар бэл, Төв Азийн Их говийн урд захад орших Алашаа /Алашань/ нутгийн Заян Наваа, Наян Наваа хоёр уулын бэл, Бада Ёго голын хөндийд А. Т.-ын II-III зууны үед үүссэн Хорууд.

3. Хар /Амар/ мөрний баруун гарын цутгалан Эргүнэ голын хөндий, түүний зүүн гарын цутгалан – Үлирэнгэ голын адаг дахь “Эргүнэ хун”, тэнд VIII зуунд үүссэн Хиад, Урианхай нар.

4. Хэнтийн нурууны зүүн суга, Онон голын баруун гарын цутгалан “Монг” гэдэг голын хөндийд VIII зуунд нүүн ирж нутагласан Бөртэ Чино, Гуа Маралаас үүдэлтэй Монголчууд.

Үүнийг дараалан бичвэл:

1. Инд мөрний эхэнд орших Арий нутгийн Арийчуудаас гарвалтай, Заян Наваа, Наян Наваа хоёр уулын хормой, Бада Ёго голоор нутагтай Хорууд /ойролцоогоор Хүннү гүрний задарч байсан үе болох II зууны үе байх/

2. Хороос гарвалтай Хиан, Нүхүүсээс удамтай бөгөөд Эргүнэ хунд нутагтай Хиад, Урианхай аймаг.

3. Хороос гарвалтай, Хёлго, Ингэдэй нутагтай Хорийнхон.

4. Хороос гарвалтай Солонгосын хойгт нутагтай Когурё /одоогийн нэрээр Жү Чаэ Хио/ хэмээх шинэ угсаатан үүсчээ.

Энэхүү санааг эрдэмтэн доктор, профессор Б. Сумьяабаатар анх дэвшүүлжээ.


9. Монгол хэдийд хаана үүсэв? Хиян, Нүхүт хоёр гэргийн хамт дайн тулаанаас зугтаж Эргүнэ хун гэдэг газар нүүн ирж нутагласан.

Асуулт: ямар аймгуудын хооронд хэдийд хаана болсон дайн тулалдаан бэ?

Хариулт: Буриадын эрдэмтэн Дорж Банзаровын “Монгол гэдэг нэрийн үүслийн тухай” гэдэг өгүүлэлд (24.94) “Илинжэ гэдэг хүнд Монгол, Татар гэдэг хоёр хүү төрж Монгол, татар /эсхүл Түрэг/ гэдэг хоёр үндэстний өвөг дээдэс болжээ. Энэ хоёр үндэстэн ураг төрлийн холбоотой байсан хэдий ч хоорондоо муудалцаж цус урсгасан дайн хийж монголчуудыг хядахад Нэгүс, Каян /Хаян/ хоёр эмэгтэйн хамтаар үлдэж Эргүнэ голын хөндий /Эргүнэ Хон/-д зугтан очиж нуугджээ” хэмээн мусульман шашинт түүхчдээс ишлэн бичсэн байна.

Сайшаал, Рашид ад Дины “Судрын чуулган”-аас ишлэж “...эрт урьдын цагт Монгол үндэстэн өөр үндэстэн өөр үндэстэн лүгээ ихээр дайтаж бүх цэргээрээ мөхсөн гэнэ. (Үүнийг Тунгус ван болон Хүннүгийн Медео цэн Иои-гийн хооронд болсон тулалдаан гэж түүхчин То Жи дурьджээ.) Ингээд Нуху (“Судрын чуулган”-д Нүхүс-Нүкүз гэж, “Өмнөд Монголын эх адаг”-т “Нохо” гэхчлэн тэмдэглэсэн байх аж)”. “Түрэгийн хаант улс гэдэг” зургийн хэсгээс 120-р тал.

Зураг 8




Түрэгийн хаант улс бол VI-VIII зууны үед Төв Азид тогтнож асан феодалын түрүү үеийн улс юм. Түрэг аймгууд 552 онд Жужаныг бут цохиж Буман /Түмэн/-аар толгойлуулсан Түрэгийн хаант улсыг байгуулж 555 онд Төв Азийг бүхэлд нь эзэлж худалдааны их замд ноёрхлоо тогтоон улмаар Хятан, Умард Зүрчид, Енисейн Киргизыг байлдан дагуулжээ. Түрэгийн хаант улсын төв нь Орхоны эхэнд байсан ба 558 оны дайнаар нутаг дэвсгэрээ улам өргөтгөж Солонгосын хойгоос Амударьяа хүртэл, Цагаан хэрмээс Байгал нуур хүрч байв. Ан гөрөө, газар тариалан, уран дархан, гар урлалыг зонхилон эрхэлж байжээ.

Түрэгийн үеийн олон зуун хүн чулуу, бусад дурсгал Төв Азид, манай оронд элбэг. Түрэгүд Согд үсэг хэрэглэж байгаад дараа нь этрний түрэг үсэг хэрэглэсэн.

VI зууны эцэст Түрэгийн хаант улс баруун, зүүн гэх хоёр хэсэгт хуваагджээ. Цэргийн жанжин Культегины /685-731/ на барсны дараа өөр хоорондоо тэмцэлдэн хямралдсаар зарим аймаг нь салан тусгаарлаж, улмаар хүчин доройтсоор 745 онд мөхсөн түүхтэй.

Түрэгийн хоёрдахь хаант улс 124-р талд.



Инд мөрний дунд бие-Гурван голын билчир орчим нутаглаж байсан Арийчуудаас зарим нь баруун тийш Иран руу, зарим нь Инд мөрнийг өгсөж Гималайн нурууны баруун төгсгөлийг давж /200-аад км/ Яркенд, Тарим голыг уруудан МЭӨ VI-V зууны үед Алшаа нутагт нүүдэллэн ирсэн гэх таамаглалыг дэвшүүлнэм.

Ямар аймгуудын хооронд тулалдаан болов?

Зохиол, зохиогч	Нэг талаас	Нөгөө талаас
“Монгол” гэдэг нэрийн үүсэл. Д. Банзаров	Татар эсхүл Түрэг	Монгол /ялагдсан/
Судрын чуулган. Рашид адДин.	?	Монгол /ялагдсан/
То Жи	Түнгүс ван	Хүннүгийн Медео цэн Иои
Монгол улсын түүх. А. Амар	Түнгүс	Хүннү
Эрэгцүүлэл	Тулалдаан Алашаа нутагт	Хүннү нарын дунд жижиг

Буриад судлал №1 (001)

	болсон. /үүнийг хойно тодруулна/ Түнгүс, Татарууд Алашаагаас 2000 км-ийн цаана байгаа учир Алашаад тулалдсан байж таарахгүй.	угсаатан Хорууд байсан байх. Монгол угсаатан үүсэх болоогүй байсан үе. Иймд энэ талд Хүннү Хор хоёр Түрэгтэй тулалджээ.
--	------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэ тулалдаантай холбоотой түүхэн баримтыг цуглуулах ажлыг үргэлжлүүлэх хэрэгтэй.

Дүгнэлт: Энэ тулалдаан нэг талаас нэн хүчирхэг болж буй Түрэг, нөгөө талаас задарч байгаа Хүннү, түүнээс үүссэн Хорууд /зохиогчийн таамаглал-С. И./ оролцож Түрэгүүд ялж их яргалал хядлага явуулжээ. Энэ сүрт тулалдаанд нэг Түрэгүүд байсан нь магадтай. Түрэгийн хаант улс 552 онд Хүннүг ялж хүчирхэг хаант улсаа байгуулаад 745 онд уйгуруудад цохигдсон билээ.

Асуулт: Тэгвэл уг сүрт тулалдаан хаана болсон бэ?

Буриадын түүхч С.Чагдуноваас нэгэн ишлэл авъяа. “VII зууны үед буюу 661-662 онд Түвдийн хаан Гар Монгол-Түргийн 200 мянга /?/ шахам хүнийг хиар цохисон тухай түүхэнд тэмдэглэсэн байдаг. Эрт дээр үед болсон тэр аюулаас зугтаж Буриадын зарим ясны бүлгүүд өөрсдийнхөө анхны төрсөн нутаг тийш зорин гарахдаа Байгал далай хүртэл нүүж ирсэн юм”. /”Буриад үнэн”. 29 ноябрь, 1991./ гэж бичжээ.

Өвөр Монголын Их сургуулийн профессор Даваадагва С. Чагдуровын санааг үргэлжлүүлж ийн бичсэн байна. “дээрх түүхээс үндэслэн үзэхэд буриадын зарим ястны бүлгүүд Хөх нуур тийш нүүж очсон нь үнэн байна. Сонирхолтой учир нь гэвэл, буриадын домогт дуунд гардаг /энэ дууны тухай цаашид тодруулах болно/ Бада (н), Ёго, Зая (н), Нава (н) гэдэг газар усны нэрс бүг тэндэх (Хөх нуур, Амдо – С. И.) болой”.

1. Сүмбэ хамба Ишбалжирын зохиолд “Хөх нуураас хойш долоо, найман өдрийн замын эцэст Бадунг /Ба-етонг/ гэдэг нэртэй гол байдаг. Эндээс Хятадын Су жу дүүрэг орох замд Шар гэрт хааны аймаг нутаглаж байжээ. Энэ Шар гэрт хааны аймаг гэдэг нь Шар Ёгор юм” гэхчлэн бичжээ. Энд дурдагдсан Бадунг гэдэг нь Хори-Буриадын домогт дуунд гардаг. “Бадан” мөн. Буриадын өвгөд настнууд “Баданг”-ийг голын нэр хэмээдэг нь ч мөн таарч байна.

2. Мөн энэ дуунд байгаа “Ёго” гэдэг нь Шар Ёгорын нэрийн “Ёго” мөн.

3. Зая (н) гэдэг нь уул хадны нэр гэж өвгөд ярьдаг. Монголын түүхч Дармадалхын зохиосон “Цагаан лянхуагийн эрхэс” хэмээх шашны шаштирт “Зарийн уулын орчим Цагаан гэрт хааны улаан ором бий” гэснийг проф. Х. Дамбийжалцан бичжээ. Тэрхүү “Зари” гэх уул нь Заян гэдэг уул байж болох юм.

4. Гэлэлхамын бичсэн “Гэсэр вангийн тууж”-д “Хор”-ын тухай өгүүлэлд “Нүбхор” гэдэг нэртэй аймаг байсан тухай бичжээ. Энэхүү Нүбхор гэх үгний “Нүб” гэдэг нь Түвэд хэлний “баруун” гэсэн утгатай үг аж. Иймд, буриад дууны “Нава (н)” гэх үг ч байж болмоор.

5. С. Чагдуровын зохиолд гардаг “Найжин гол, Хөх шил” гэдэг газар усны нэр нь “Най мөрөн” гэсэн үг болой. “Най”-гийн “ай” гэдэг нь хос эгшиг /дифтонг/ биш “ауй” гэж “т+с+г” гэдэг үеэр дуудагддаг. Иймд, “Ная(н) гэдэг нь Науй буюу Найжин голын эртний дуудлага байсан бололтой.

Дээр буриадуудын тухай товч өгүүлсэн билээ. Буриадууд нь Хори, Барга, Хамниган, Сонгоол зэрэг олон угсаатнаас бүрддэг. Тэгвэл дээрх дууг Хори Буриадаас бусад буриад дуулдаггүй.

Хиан, Нүхүс хоёрын оролцсон тулалдаан ямар аймгуудын хооронд хаана хэзээ болсон тухай дээр дурдсан баримтуудыг цуглуулав. Цаашид ч энэ талаархи илүү чухал баримт сурвалжлан хайж судалгааны эргэлтэнд оруулах шаардлагатай юм.

Монгол аймаг VIII зуунд, буриад аймаг XVIII зуунд үүссэн нь магадтай учир VIII зуунаас өмнөх түүхэнд “Монгол” гэдэг нэрийг, XVIII зуунаас өмнөх түүхэнд “Буриад” гэдэг нэрийг оруулахгүй байх нь түүх судлалд нийцнэ. Мөн Хятан нар Монгол хэлтэн байсан гэж бичиж байгаа нь үзэгдэх юм. Монгол угсаатнаас өмнө үүссэн угсаатан Монгол хэлээр ярьж байх учиргүй. Тэрчлэн Төв Азийн бүх аймгуудыг Хүннү гаралтай хэмээн үзэж /А. Амар ба бусад/ байгаа нь зөв. Иймд, Хүннү гаралтай хэлтэн гэвэл түүх судлалд нийцнэ.

Дэд гарчигт тавьсан “Хэрэв Буриадууд Манжид дагаар орсон бол яах байсан бэ?” гэдэг асуултанд бүрэн үндэстэй хариулт өгч болно. Шинэхэн Монгол улсын хурц оюунт сэхээтэн, үүнийг бичигчийн нэн хүндэлж биширч явдаг хүн, МУ-ын анхны ерөнхийлөгч асан П.Очирбат “Тэнгэрийн цаг” номондоо: “Монголын нэгдсэн төр дараа нь задарч улс гүрний тусгаар тогтнол нэг биш удаа хүнд нөхцөл байдалд орж төрийн алтан залгамж тасрах байдалд хүрч байв. 1206 оноос өнгөрсөн 790 жилийн хугацаанд Монгол улс баттай оршин тогтнохдоо төрийн тусгаар тогтнолоо алдахгүйн төлөө урнаар тэмцэж байсныг 1691, 1911, 1921, 1990 оны үйл явдлууд бэлхнээ гэрчилнэ. Жишээ нь монгол аймгуудын хамгийн аюултай дайсан гэгдэж байсан Зүрчдийн Алтан улсын суурин дээр үүсч хүчирхэгжсэн Манжид эзлэгдэх аюул тулгарахад дагаар орж нутаг усаа бүтнээр нь, хүн ардаа цэврээр нь, мал хөрөнгөө бүхлээр нь авч үлдсэн төрийн нарийн ухаан байна. Ингэж нэг улсыг дамнуулан нөгөө улсад дагаар орсон нь /булаан эзлэгдээгүй/ Хятадын аюулаас Манжаар 200 жил хамгаалуулж чадсаныг урван тэрсэлсэн явдал гэж үзэх нь хэр үндэстэй бол? Төр шашны хос ухаан чухам тэр үеэс л өнөөг хүртэл улбаалжээ”.

556 онд нэг талаас Түрэг, нөгөө талаас Хүннү, Хорын дунд болсон сүрт тулалдаанаас зугтаж гарсан Хүннү, Хор хүмүүс-Хиан, Нүхүс хоёрын нэр 1500 гаруй жилийн туршид түүхэнд үлдэснийг бодоход тэд яавч энгийн цэргүүд биш, язгууртан, цэргийн нэрт жанжид байсан байх ёстой. Тэгвэл, тэд хоёр эмэгтэйтэй /зарим зохиолд 10-аад хүн гэдэг/ зугтсан байж таарахгүй. Ийм цөөхөн хүн бол Шар мөрний том тохойн хойгуур үргэлжлэх модтой уулын сархиагт нуугдах амархан. Ноён, жанжин хүмүүс байсан учир бие хамгаалагч цэргүүдтэйгээ, их яргалал хядлагаас амьд үлдэгсэдтэй цуг зугтсан байх ёстой. Хойноос нь Түрэгүүд хөөсөн байх. Тэднийг эсэргүүцэх цэргийн хүчтэй байж таараа. Ийм олон хүн уулын сархиагт нуугдах аргагүй. Урагшаа зугтах аргагүй, Цагаан хэрмээр хаалттай. Хойшоо зугтах арга бас үгүй, тэнд хүчирхэг Түрэг улсын засаг захиргааны төв буй. Ингэхээр ганцхан чиг үлдэж байна. Энэ нь зүүн хойш зугтаж Түрэгийн хаант улсын нутгаас гарах явдал байв. Олон хоног ядарч зүдэж явсаар Эргүнэ голын хөндий, түүний зүүн гарын цутгалан – Үлирэнгэ голын адаг – Эргүнэ хун гэдэг эзлүүд нутагт нутаглах болжээ /Эргүнэ хун гэх нэрийг тэд өөрсдөө чөгсөн байх талтай/.

Нүкүс /Д.Оссоны “Монголчуудын түүх”-д “Тэгүс” гэжээ/, Хиан гэдэг хоёр хүн, хоёр эмэгтэйтэйгээ үлдэж Эргүнэ Хун гэх өн шимлэг билчээр ус сайтай, аглаг бартаат уултай газар нүүж нутаглан амьдарчээ” гэсэн байна.

Харин А. Амарын “Монголын товч түүх”-д: “Жинхэнэ Хор Монгол хүн Хүннү хүний толгойг Нанхиадад гэрээгээр тушааж байв хэмээсэн тухайд бодвол, тэрхүү отгийн дарга гэгч нь Монгол Тобагийн хүн мөн байсан эсэхийг мэдэх аргагүй ба хэдүй Монгол мөн хэмээвч тэр мэт харь этгээдтэй дотуурлан нийлэлдэж овог үндсээ сүйтгэгчид одоо ч байгаа”. Энэ ишлэлд “Хор Монгол” гэдэг үндэстэн /аймаг-С. И./ байсан гэдэг нь л сонирхол татаж байна. Хоруудын үед “Монгол” гэдэг нэр ч, угсаатан ч үүсэх болоогүй байсан учир нэн шинэ үеийн түүхчид тодотгол болгон нэмсэн гэж үзэх бүрэн үндэстэй учир цаашид “Хор Монгол” гэдэг хоршоо томъёололоос “Монгол” гэдгийг хасав.

“Буриадын түүх соёлын атлас”-ыг сөхөж үзье. /2.122-123/. Агуу их Түрэгийн хаант улсын газрын зураг дээр Алашаа нутаг, Хөх нуур луу 556 онд Түрэгүүдийн хийсэн довтолгоог сумаар заажээ. Үүнийг үндэслэн энэ тулалдаан Алашаа нутгийн орчим болсон гэж үзэх үндэстэй.

Одоо Алашаа нутагт болсон гэдгийг батлах хэрэгтэй.

Хүннү гаралтай Түрэг угсаатан ихэд хүчирэгжин 552 онд Жужааныг бут цохисноор өөрийн төрт улсаа байгуулсан түүхтэй. Энэ тулалдаан Цагаан хэрмийн ард, өмнөд Хүннүгийн нутагт болсон нь түүхэнд тэмдэглээстэй. Иймд Алашаа нутаг-Заян Наваа, Наян Наваа болсон гэж үзэх үндэстэй.

Түрэгийн хаант улс байгуулагдсны дараа 556 онд ба мөхөхийн өмнөхөн 706 онд Культегин, 708 онд Мочур, мөн 729 онд тус тус болжээ /2/.

Энэ хоёрын сүүлчийн тулалдааны үед гэвэл: нэгд, Түрэгүүд хүч нь суларч задрахын өмнөх үе. Хоёрт, энэ тулалдаанд ялагдсан Хиан, Нүхүс нар Эргүнэ Хунд зугтан очиж VIII зууны сүүлийн хагаст нутагтаа багтахтаа байгаад Бөртэ Чино, Гуа Марал нар нутгаасаа нүүж Бурхан Халдун уулнаа нүүж ирсэн гэх нь бодит байдалтай нийцмээргүй. Тэгвэл, Түрэгийн хаант улс хүчирхэгжин мандаж байсан үес буюу 556 он гэвэл энэ онд ялагдаж Эргүнэ Хунд зугтаж очоод 200-аад жилийн дараа VIII зууны дунд үед Хорууд олширч Онон, Ингэдэй, Бурхан халдун, Бойр нуур, Дорнодын их тал, Солонгосын хойг руу нүүсэн гэвэл бодит үнэнд нийцмээр гэж үзэх, нөгөө талаар сөнөж байгаа урд Хүннү, бүрэлдэн тогтож байгаа Хоруудын хооронд 556 онд болсон гэж тогтов.

“Эргүнэ Хун” гэдэг нэрийн тухайд гэвэл, Сайшаалын таамаглалд: “Хун” гэдэг нь Хүннү хэлээр “хадан цохио” гэсэн үг. Хайлаар голын хойт талд 20-30 м өндөр Хадан цохио одоо ч бий. Түүний нэрээр нэрлэсэн гэж бичжээ. Харин Хори зон өөрсдийгөө:

Хун шувуун гарвалтай

Хусан модон сэргэтэй гэдэг.

Үүнтэй холбогдуулан зохиогч таамаглалаа дэвшүүлнэм. Эрт дээр үед зүүн баруун гараас нь олон гол горхи цутгасан Эргүнэ голын эзлүүд хөндийд хун шувууд олноороо зусаж үүрээ засаж, өндгөө дарж, дэгдээхэйгээ өсгөж намрын сэрүү ороход чимээгүйхэн хоёр хоёроороо нисэж урин дулаан өмнөд нутгаа зорьдог байсан биз ээ.

“Хүүхэд залуучуудын нэвтэрхий толь”-д хун шувууны тухай “хаврын цэлмэг тэнгэрт цайвалзах, гялалзах хун шувуудыг харсан хүний сэтгэл сэргэх шиг болно. Насан туршдаа хоёр биенээсээ уйдаж хагацдаггүй үхэвч, сэхэвч хамт явдаг хос хун шувууг хүн төрөлхтөн эрт дээр үеэс үнэнч шударга хайр сэтгэл, гоо үзэсгэлэнгийн тэмдэг болгон хүндэлсээр ирсэн түүхтэй. Хун шувуун үүр өндгөө хамгаалан нэг

нэгийгээ өмөөрөхдөө махчин шувуу төдийгүй үнэг чоныг ч дайрч далавчаараа унатал савж чаддаг зоригтой шувуу юм. Монголчуудын хууль цаазны бичигт XIII зууны үед хунг дархалсан тухай дурдсныг үзвэл энэ нь манай орны хамгийн эртний дархан цаазат шувуу болно” гэж бичжээ.

Түүхийн олон зууны туршид хөөгдөж, хэлмэгдэн зовж явсан Хор-Хиад, Хор-хори зонд хун шувууны цэвэр ариун цагаан өнгө, хоёр биеэсээ хагацдаггүй үнэнч ариун чанар, дайсантай учрах үед гарах түүний мятрашгүй эрэлхэг зориг нь хязгааргүй таалагддаг байсан нь дамжиггүй.

Хун шувууд цугларсан эх нутаг - Эргүнэ Хунгаасаа хувь тавилангийн эрхээр нүүн явахдаа Хори зонд хунт нутгаа санагалзаж Хун шувуугаар тотем хийж Ага, Хёлго нутаг руу нүүсэн биз ээ.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

*Лэглүүд хүгдүүд Б.Лувсанцэрэн
Дорнод аймаг Дашбалбар сум,
ахмад багш, АБТА*

ХЭЛЭ СОЁЛОО ДЭЭДЭЛЭЭ

*Хүн болохо баганаа гэжэ
Хэн бүхэн хэшээжэ ерэнэн
Эльбэрэлтэ найхан буриад ёһо
Элэнхэндэ шэнгэхэ уһан бэшэ*

Буриад түмэн гарбал түүхээрээ эртэнэй монгол хэлэтэнэй нэгэн тулдаа буриад хэлэ аялгахадаа монгол хэл бэшгэйгэй худлалда шухала хэрэгтэй болохо ушарһаа мүнөөгэй буриад зон үндэһэнэйнгээ буриад хэлэ аялга, үб соёлоо хадагалжа, наһатан буурлуудһаа үблэжэ абажа шадажа байнагдий үгы гү гэдэгтэ ултай һууритай хандаха шаардлагатай болоо. Энээндэ “Алтаргана” наадан шухалһаа шухала үүрэгтэй.

“Алтаргана” наадан дуу хуур уралигыг эрхимлэхэхээ гадна буриадай ёһо заншал, хувсаһа хунар, ажа байдал, хэл соёл, мал ажа ахы, байгаали дэлхэйдээ хандаха хандлага, шашин шүтлэгэ зэргэ үргэн ехэ асуудлыг хамаржа, хурал хутаар, һанал, бодлоо хөөрөлдөхө уулзалта, буриадай урданай ба мүнөөнэй амидарал ахыг харуулһан үзмэри үзүүлэх хэрэгтэй байна.

Дэлхэйд 500,000 буриад бий гэхэн тойм байдагһаа үнэндээ яг буриад ёһо заншал, хэл соёлоо һайн мэддэгын хэды бэлэй. Миний һанахада Ородой буриад ород тал уруугаа, илангаяа Байгалай саадхи буриад ороджоһон, Монголой буриад монгол тийшээ болоһон байхашэнди. Тийхэдэ Шинэхэндэ байгаа буриад буриадаараа үлэхэн һанагдана.

Ородой буриад ехэ гүрэнэй бодлогоор ороджоһон, гурав таһаржа һаланди амидаржа байна. Монголой буриадай гол зонхинь Дорнод аймагай Дашбалбар, Баяндун, Баян-Уул, Сагаан-Овоо, Эрэнсав, Хэнтий аймагай Дадал, Биндэр, Батширээт нютагта ажа һуужа байна. Мүн Сэлэнгэ, Хүбсэгэл, Булган, Төв аймагта бий. Эд буриадуудай ехэнхи барагинь хэлмэгдүүлэлтийн үеһээ буриад гаралаа нюужа, аймшагт он жэлнүүдыг туулахадаа буриад хэл соёл, хувсаһа болон бэшэ олон юмээ мартажа бүдэгэрһэн байна.

Дашбалбар, Баяндун, Баян-Уул, Сагаан-Овоогой буриад энэ талда хэбээрээһаа һүүлэй үеын залуушуулнай хэлэ аялга мартажа монголжохо болжо байна. Гээһаа хэлээ ор таһа мартаагү гэхэдэ арайш үгы, харин яриха һонирхол үгы байх шэнди. Энэнд юн нүлөөлнөв гэхэдэ оршон, мэдээсэл, һургуули гэх зэргэ болно.

Ородой буриадууд буриад хэл аялгаараа намуун удаан ярияашһаа 10 үгэнэй хахадыни ород байшна. Шэнэхээн буриад л яг буриад хэлэ аялгаараа яридаг гэжэ би боддогби. Үгын һүүл бага зэрэг ондоо.

Ород, Монгол, Шэнэхээнэй буриадай наһатайшуул уһан буриадаараа ярижа байна. Залуушуулнай тиймэ бэшэха.

Даяаршлал /глобальчлал/ гээшэмнэй хэтрээһаа бага яһатанай хэл хүнэхэ аюултай, ехэ үндэһэтэндэ бага нь уусажа хүнэдэг дэлхэйн түүхэ бэлэн бий. Уусажа хүнэхэ мүхэхэ үгын тулда юун туһалхав гэхэдэ хэл соёл, ёһо заншлаа гээхэ хаяха үгы, мартаха үгы байх хамагһаа шухала тэргүүнэй зорилто.

Манжа үндэһэтэн 200 гаран жэлдэ хятад, монголые эзлэн хүштэй байһаншһаа һүүлэй һүүлдэ тэрэ манжа хэлэ хятадта уусажа хүнэһэн бэлэй. Манж бэшэг түүхын архивт үлэһэн бэлэй. Хэлэ соёлоо мартаһаа улад гүрэншье хүнэхэ мүхэхын үлигэр манжхаям. Ийм гашуун түүхэ бэдинэй хажууда байгаае һанаха л хэрэгтэй. Түрэлхи хэлэ гээшэ тэр үндэһэтэн яһатанай тэнгэрын тамга юм.

Би нэгэн жэшэе хэлэхэм. Нэгэн эхэ хари холо ябаад ерэһэн нютагайнгаа хүнтэй уулзажа һонин һоримой хөөрөлдөхөд саадхи хүнийнь

-Францад танай хүбүүнтэй уулзаав. һайн һайхан амидаржа байһанан. Эжытэйм уулзажа хэлээрэй гээһэн гэхэдэ нь эхни ехээр баярлажа:

-Миний хүбүүн шамтай ямар хэлээр яринаб. Түрэлхи авар хэлээр ярьяа гү гэбэха, саадхи нь:

-Танай хүбүүн намтай францаар ярьяһан гэхэдэ хүгшэн эх уурлан сухалдажа:

-Тэрэшни миний хүбүүн бэшэ. Миний хүбүүнһаа авар хэлээрээ яриха ёһотой гээд ябашһан гэжэ Расул Гамзатов бэшэе. Энээнһээ харахада түрэлхи хэлэн ямар шухалань ойлгогдоно.

Ийм ушарһаа Д.Нацагдоржи “Үдэхэхэе һураһан түрэлхи хэлэн, Мартажа болохо үгы соёл” гэж дуулжа, Б.Ринчен “Шихнү шэмэг болоһон монгол хэлэн, Шин зоригто үбэгэ дээдсэйм үб ехэ эрдэни” гэһэн бэлэйл. Түүхэтэй үүхтэй буриад түмэнэйм түрэлхэ хэлэн түмэн үедэ мартагдаха ёһо үгы. Хүн түрэлхитэнэй хүгэжэлэй хурдаһаа, хүрдэһээ гээгдэжэ үлэжэ болохо үгыни ойлгосотой. Урданайнгаа юмэнһээ абахыени абажа, гээхыени гээхэ зүб. Гээжэ мартажа болохо үгыни хэл соёл /суял/ бэлэй.

Энэ ушарһаа:

1. Буриад зон өөһөд хоорондоо, гэртээ заалһаа буриадаар яриха
2. Хойшо үедээ омог ураагаа мэдүүлхэ
3. Буриадай атлас олон хэлээр бэшэжэ гаргаха
4. Үхи хүбүүдээ багаһаани сэбэр буриадаар яриулжа хургаха
5. Буриад һомоной хургуулида буриад хэлэ зааха
6. Хүүгэд, залуушуулай дунд буриад дуу, шүлэгэй тэмсээн урилдаан хэхэ

һаналаа та бүхэндэ хүргээд:

Заян набаагаа бэдирэжэ
Зүдэрэжэ тэнэһэн буриадни
Бадан ёгоо зорижо
Будлижа нүүһэн буриадни
һартай нартай хурбаада

Һарнижа зутарһан буриадни
Хуби заяанай шуурганда
Хахасажа һалаһан буриадни
Эдэрээтэй түүхын тальхида
Элдүүрни ханаһан буриадни
Эрин сагай нугашаада
Эрини хүсэһэн буриадни
Абал ээжынгээ һургаалые
Андуу үгыгээр дахахавди
Арадхан зонойнгоо гуримые
Абажал хододоо ябахабди
Хүхэ мүнхэ тэнгэридээ
Зальбаржа мүргэжэ байял
Хүриһэтэ алтан дэлхэйгээ
Хүндэлжэ шүтэжэ ябаял
Уг гаравал түүхээ
Мартажал яажа боллолтойв
Унаһан үдэһэн нютагаа
Орхижол яажа хаялтайв гэжэ дуулнав

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

Лэглүүд хүгдүүд **Б.Лувсанцэрэн**
*Дорнод аймаг Дашибалбар сум,
ахмад багш, АБТА*
Л.Цэрэнчимэд
*Дорнод дээд сургуулийн багш,
Докторант*

УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХ УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

Буриадын уг гарвал үүх түүхийг олон эрдэмтэн судалсан бүтээлд элэнц хуланц, эцэг өвгөдөө мартагчийн тулд өвөг дээдэс маань уг шагаа олон янзаар уламжлан бичиж ирсний нэгээхэн хэсэг болох угийн бичиг чухал байр эзэлдэг юм. Уг удмаа мэдэхгүй хүнийг мал адгуус, сохор номин, ойд төөрсөн сармагчин лугаа адилтган, үр хүүхдэдээ хар багаас нь омог удмыг цээжлүүлэн тогтоолгож хүмүүжүүлдэг байжээ. Амар мэндээ мэдэлцэн танилцах, анд нөхөд бололцох, бэр хүргэнээ сонгох зэрэгт уг гарвал омгоо мэдэлцэх шаардлагад угийн бичиг гол үүрэгтэй байсан бөгөөд энэ нь цус ойртохоос хамгаалж, хойч үед эрүүл саруул, оюун билэгтэй үр хүүхэд төрөхөд чиглэгдсэн ардын маань ариун сайхан уламжлал, арга ухаан байжээ. Ахмадууд бага балчир хүүхэдтэй уулзахдаа ямар омгийн, хэний хүү, охин билээ гээд цааш хэдэн үеийг тоолуулдаг байлаа. Энэ уламжлал тусгай бодлогоор тасарсныг одоо сэргээж буй нь чухам нүдээ олсон буянт үйл билээ.

Эртний энэ сайхан угийн бичиг, гэрийн түүх тасраагүйсэн бол эдүгээ бие биенээ энд тэндхийн эрлийз хурлийзаар элдэвлэн дуудахгүй байсан бизээ. Буриадын дээд элэнц Баргабаатар Илиүдэй, Буриадай, Хоридой хэмээх 3 хүүтэй, Илиүдэй Алтай Хангайгаар, Буриадай Соёны уулс, Байгалын баруугаар, Хоридой Байгалын өмнөд нутаг, Хэнтийн Бурхан Халдунаар нутаглан өнөржсөн хэмээн домоглон өгүүлдэг бүлгээ. Хоридой мэргэний Баргажингоогоос Алунгоо төржээ. Дараах гэргий Шаралдайн төрүүлсэн

1.Галзуудаас:

- а. Доргош
- б. Сарвад
- в. Жэнхэн
- г. Дааганхан
- д. Хабагаш
- е. Эршэм
- ё. Онход
- ж. Дэлдгэр
- з. Хатайл
- к. Нохой ураг

и. Чоно

л. Ользон нийт 12 хүүхүүр

2. Хуацайгаас:

- а. Бариушхай
- б. Бэгтэр
- в. Боохой
- г. Онгор / Хонгор/
- д. Тогтор / Товтор/
- е. Цагаан малгайт
- ё. Баавгар
- ж. Харилхан

з. Тавхал нийт 9 хүхүүр

3. Хүгдүүдээс:

- а. Улаалзай
- б. Төмөрчин
- в. Бариухай
- г. Нохой ураг
- д. Байтай
- е. Лэглүүд
- ё. Хавшигтай нийт 7 хүхүүр

4. Гучидаас:

- а. Мэргэн шар
- б. Бөх хар нийт 2 хүхүүр

5. Шарайдаас:

- а. Худанц
 - б. Ахайд
 - в. Долоод
 - г. Тоботой
 - д. Дэлдэй
 - е. Хагшууд
 - ё. Сүнид нийт 7 хүхүүр
- Удаах гэргий Нагатайгаас төрсөн

6. Харганаас:

- а. Моотгон харгана
- б. Хүхнэд
- в. Хуран
- г. Онход
- д. Тангад
- е. Авхан
- ё. Бариахай

ж. Баатархаан /Баатаржаан/

з. Хоодой нийт 9 хүхүүр

7. Худайгаас:

- а. Кудуй
- б. Хар тулуй
- в. Хонтон
- г. Бийсхэй
- д. Залгиур
- е. Зэмхэн
- ё. Михан
- ж. Алгуй нийт 8 хүхүүр

8. Бодонгуудаас:

- а. Суурь бодон
- б. Оргодой бодон нийт 2 хүхүүр

9. Халбингаас:

- а. Гутаар
- б. Хуригай
- в. Мэнгэй
- г. Жирхэн нийт 4 хүхүүр

10. Цагаанаас:

- а. Тунхин 1 хүхүүр

11. Батнайгаас

- а. Догшид
- б. Заямха
- в. Шалдан
- г. Бухай
- д. Хэдгэнэ
- е. Малаан нийт 6 хүхүүр

Ийнхүү Буриадын 11 эцгийн 67 хүхүүр зон болжээ. Буриадын угийн бичиг Баргабаатараар эхэлдэг бөгөөд уг хүн нь түүхэн хүн үү? домгийн хүн үү? гэдэг нь тодорхойгүй асуудал. Түүнийг Монголын Түмд улсынх, Бөртэ чонын дүү, Төвдийн Алтан хааны түшмэл, Тогоонтөмөрийн хүү, Буриадын элэнц эцэг, омгийн ахлагч гэх мэтээр бичиж иржээ. Зарим эрдэмтэд Баргабаатарыг 10-р зууны үеийн хүн гэсэн байдаг. Юутай ч буриадын элэнц эцэг нь үнэн болов уу? Урьдын түүхчид ялангуяа шашны түүхчид монголын хаад, суут хүмүүсийг Энэтхэг, Төвдийн ийм тийм хааны удам гэж бичдэг байсан. Буриадын 11 эцгийн үүсэл манай эриний үед ч юмуу? бүр эртний байж ч магадгүй. Одоогийн 11 эцгээр омог хүхүүрээ бүртгэж ирсэн нь уламжлалаа хадгалсан түүхэн үнэн ч орчин үеийн шаардлагыг төгс хангахгүй болжээ. Иймд омог хүхүүрийн бүртгэлийг улам боловсронгуй болгон эхнэр нөхөр хоёуланг айлын хос баганаар үзэж хоёулных нь омог хүхүүрийг, эцэг эхийн талынхныг бүртгэж хаана амьдарч буйг тэмдэглэсэн гэрийн судартай болох хэрэгтэй. Ингэх нь удам угсаа, ясан цусан төрлөө үр хүүхдэдээ мэдүүлж, хожмын болзошгүй цус ойртолт, оюуны хомсдолтой хойч үе төрөхөөс сэргийлэх зорилготой билээ.

Ц.Дамдинсүрэн гуайн зохиол “Хачин хурим” шиг болохоос болгоомжлоход тустай. Угийн бичиг гэрийн судраа хуучнаасаа дэлгэрүүлэн хөтөлж, ясан цусан төрлөө яаж тэмдэглэхийг жишээ болгоё.

Абхан харгана Дондог, суурь бодонгууд Дулам нарын хүүхдүүд

1. Дондогийн Бор- абхан харгана

2. Дондогийн Цэцэг- суурь бодонгууд /эхээ дагаж ирсэн учраас/ гэж хөтлөхөөс гадна

Дондог миний аавын хамаатан.....

ээжийн хамаатан.....

Дулам миний аавын хамаатан.....

ээжийн хамаатан.....

гэх мэтчилэн аль сум, аймаг, хотод байгааг тодорхой бичиж “Тэрийн судар” хэмээн уламжлан хадгалж байх хэрэгтэй. Өрх толгойлсон эхчүүд хаяад явсан, салаад одсон эрчүүдээр хүүхдээ овоглох хэрэггүй санагдана. Үүний оронд эхээс л хүн төрөхөөс хойш өөрөөрөө омгоо бичих нь зүйтэй. Угийн бичигт эмэгтэйчүүдийг орхидог буруу. Хүүгүй хүний омог удам тасрахгүйн тулд басгадаа өөрийн омогтоо хөвгүүдийн нэгэн адил бичиж, удам залгуулан хөтөлбө. Хүүгүй айл удам судраа таслахгүйн тулд айлаас хүү үрчилж авдаг нь юуны буруу байхав. Гэхдээ үрчилсэн хүү нь өөр яс цусны хүн шүү дээ. Иймд өөрийн мах цусны тасархай охин үрээрээ удам залгуулан угийн бичигт бичих нь зүйтэй. Оюунтай эцэн олон эмэгтэйчүүд улс орныхоо төлөө, удам угсааныхаа төлөө гавьяат үйл бүтээснийг судар шастирт тэмдэглэн үлдээснийг бид мэднэ. Эмэгтэй хүнийг угийн бичигтээ оруулдаггүй нь эм хүн эрийн боол, гэрийн зарц гэж үздэг балар бурангуйн ёс бөгөөд үүнийг өөрчлөх цаг нэгэнт болжээ. сумын хэмжээнд хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэйчүүд олон, төрсөн хүүхдийн дийлэнх нь охид, ахмад настны олонх нь хөгшид, өвгөд цөөн байна. Энэ юуг өгүүлдэд байна вэ? гэвэл:

1. Хүйсийн харьцааны тэнцвэрт байдал алдагдаж байгааг

2. Хүүгээрээ удам залгуулна, хүү төрөөсэй гэсээр байтал удам тасрах зам руу дөхөж явааг харуулж байна.

Яг үнэндээ үр хүүхэд, ар гэр, эр нөхрийн өнгөтэй өөдтэй, цэвэр цэмцгэр явахын гол зүтгэлтэн бол эмэгтэйчүүд, эхчүүд мөнөөс мөн. Ялангуяа залуу үеийнхэн нөхөр нь нөхөр шиг, эхнэр нь эхнэр шиг байж ирээдүйн эцэг эхчүүд болох үр хүүхдээ ёс журамтай хүмүүжүүлж, удам судраа зааж сургадаг байя. Одоогийн хүүхдүүд өвөө эмээ гэхээс бус нэрийг нь мэдэхгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Ургийн алтан хэлхээ болсон угийн бичгээ удам дамжуулан хөтлөх нь ухаант хүмүүн, улс үндэстний умартаж болшгүй өв соёл. Энэ эмхэтгэлдээ Дашбалбар суманд 2006 онд оршин буй Ага буриадын 8 омгийн хүмүүсийг хүхүүр, дээд үетэй нь багтаахыг зорьсон ч зарим хүн омог, хүхүүр, дээд үеэ сайн мэдэхгүйгээс орхигдсон буруу болсон зүйл байхыг үгүйсгэхгүй. Өрхийн нэрийг багийн засаг дарга нарын хүн амын бүртгэлийг гол болгов. Дээд үе омог хүхүүрийн нэрийг уулзсан хүн бүрээс шахам асууж бичсэнээс гадна Улаанбаатарт 1966 онд хэвлэгдсэн Сумьяабаатарын “Буриадын угийн бичээс”, Агад 2001 онд хэвлэгдсэн Самбуев Лхасран Самбуевичийн “Родословное письмо Шарайтского рода Агиснких бурят” зэрэг ном, Дашбалбар сумын иргэн Бавуудоржийн Батмөнх, Базаргүрийн Батмөнх, Аюушийн Батмөнх, Лхасүрэний Александр нарын хувийн угийн бичгийг үзэж ашигласнаа дурдъя.

Энэхүү угийн эмхэтгэлийг урьдын угийн бичгээс ойлгоход хялбар болгохыг зорьсон билээ. Миний олж үзсэнээр угийн бичгийг хөтөлж ирсэн нь модны мөчир маягаар бас шугаман хэлхээсээр залгуулан бичсэн байдаг. Энэ нь олон хуудас дамжуулан тусгай дугаар тавьж хөтөлдөг нь хүн бүхэн авсаар ойлгоход бэрхшээлтэй санагдсан учир энэ угийн бичгийг орчин үеийн болгон, омог хүхүүрээр нь ялган бичихдээ дээд үе, одоо байгаа айл өрхийн дугаар, өрхийн хүмүүсийн нэрс (эрэгтэй, эмэгтэй) гэсэн хүснэгтээр үзүүлэв. Уг өрхийн дугааргүй хүснэгтэд бичигдсэн хүмүүс бол хадамд гарсан эмэгтэйчүүд болно. Тухайлбал:

Хүгдүүд

1.Лэглүүд хүгдүүд

Дээд үе	Өрх ¹	Өрхийн гишүүдийн нэр	
Баргабаатар Хоридой Хүгдүүд Лэглүүд Долдой Таанаг һандгай Эрхин Амхай Сэсэг Шэрэм Улам һартаха Хабрушка Бадага Базар Мэхий Халзан Холхоонт Адууч Цонхоо Санжмятав 1.Бүд 2.Хоньчин ↓ Дугарсүрэн	1.	Бүдийн Лувсанцэрэн Л.Цэрэнчимэд	
	2.	Д.Ганхуяг Г.Содмэргэн Г. Цогтмэргэн Г. Гэрлээ	
		3.	Д.Батхуяг Б.Номин-Эрдэнэ Б. Гармаа Б. Батхишиг
			4.
	5.		
		6.	
	7.	Дашийн Дашдорж Д.Дашжаргал Д.Дашжавхлан Д.Цэрэндулам	

Буриад судлал №1 (001)

хандгай Эрхин Амхай Сэсэг Шэрэм Улам хартаха Хабрушка Бадага Базар Мэхий Халзан Санхир Данжин Жаргал Даш	8.	Дашийн Дашдаваа Д.Энхцэцэг Дашдаваагийн Даваажаргал
Баргабаатар Хоридой Хүгдүүд Лэглүүд Долдой Таанаг хандгай Эрхин Амхай Сэсэг Шэрэм Улам хартаха Хабрушка Бадага Базар Мэхий Халзан Санхир Данжин Жаргал	9.	Жаргалын Чимэддорж Ч.Дэмид Ч.Дэжидмаа Ч.Чимэдмаа Ч.Мөнхцэцэг

гэх жишээтэйгээр бусад омгуудыг бичсэн.

Өвөг дээдсийнхээ нэрийг монгол бичгээр бичсэнийг уншиж ойлгохдоо буруу ухаарсан тал байна гэж үзээд зассанаа хаалтад бичлээ. Жишээлбэл:

Малчин гэснийг Мэлзэн (Халзан гэсэнтэй адил үг). Бухиан гэснийг Бүхээн, Шүлхий гэснийг шүлөөхэй, Мэлхий гэснийг Мэлхээ (Мэлһээ) галын тэнгэр гэсэн үг хэмээн ойлгож бичив.

Энэхүү угийн бичгийг тулгуур болгож ураг төрөл, удам угсаагаа дээдлэх, өрх гэр бүр цаашид үргэлжлүүлэн хөтлөх, үр хүүхдэдээ дээд үе, төрөл саднаа мэдүүлэх зэрэг ажлыг хийнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлье.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

*Бодонгууд Намдагийн Лхагвадорж,
МАН-ын Эрдэм шинжилгээний
хүрээлэн, сэдвийн удирдагч, Ph.D.*

ЗАЯН НАВАА БУРИАД ДУУ БА БУРИАДУУДЫН УГ ГАРВАЛ

Товч хураангуй. Заян Нава эртний буриад дуугаар Буриадуудын уг гарвалыг судлан тодорхойлов.

Түлхүүр үг. Буриад дуу, уг гарвал

Оршил

Эртний дууны үгээр угсаатан, үндэстний уг гарвалыг этнографи, этногенезийн шинжлэх ухааны үүднээс шинжлэн судлах нь чухал юм.

Судалгааны ажлын зорилго: Заян Нава эртний буриад дууны үгээр Буриадуудын уг гарвалыг судлах зорилго тавив.

Судалгааны ажлын арга зүй: Нэн эртний гэж үзэж болох Заян Нава буриад дууг сонгон, дуунд байгаа Заян ба Нава хоёр үгийг дэлхийн хүн төрөлхтөний түүхэн хөгжил, Соёл иргэншлийн анхдагч голомт нутгийн нэршил, нэр зүйн хайлтын судалгаан дээр үндэслэн, эрт, эдүгээгийн судар бичгийг шүүн судалгаа хийв.

Өөрт археологи, этнографи, жинхэнэ антропологи гурвал ухааныг багтаасан антропологи ухааны арга зүй, аргачлалыг баримтлав.

Судалгааны ажлын үр дүн: Заян Нава хоёр бадаг Буриад дууны үгийг Кирилл-Монгол бичгээр Төв Монгол аялгад хөрвүүлбэл:

1. Заяа заяа заяана л
Заян Нава миний л
Заян Нава хоёр нь л
Жааханы минь л аялга.
2. Байдаг байдаг байдал нь л
Байдаг Ёс миний л
Байдаг Ёс хоёр нь л
Багаханы минь л аялга.

Дуунд буй Заян үг нь арабаар Zaiyan, кириллээр Зайян бөгөөд Нил мөрний адаг хөндий, Арабын Бүгд Найрамдах Египет улсын нийслэл Кайр хотоос баруунаа хойт өргөргийн 31°24', зүүн уртрагийн 31°30' орших газрын нэр /1/ болно.

Дуунд байгаа Нава үг нь арабаар Nawa, кириллээр Нава бөгөөд Нил мөрний адаг хөндий, Арабын Бүгд Найрамдах Египет улсын нийслэл Кайр хотоос баруунаа

Заян газраас баруун тийш 14 минутын зөрүүтэй хойт өргөргийн 30⁰14¹, зүүн уртрагийн 31⁰ 16¹ орших газрын нэр /1/ болно.

Одоогийн Ухаант хүн, *Homo sapiens* Эх дэлхийн зөвхөн нэг л цэг Африк тивийн Төв хэсгээс голомтлон үүссэн /2/ бөгөөд Хүн төрөлхтөний соёл иргэншлийн анхдагч голомт нь Африк тивийн Нил мөрний адаг хөндий /2/ одоогийн Арабын Бүгд Найрамдах Египет улсын нутаг дэвсгэр болно.

Ухаант хүн голомтлон үүссэн Африк тивийн Төв хэсэгт тухайлбал: Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын Дээд Конго мужийн Исиро хотоос зүүнээ эх авч, Непоко голтой нийлэн Конго мөрөнд цутган урсах Нава нэртэй гол /3/ байгаа нь бидний дэвшүүлж буй таамаглалыг баталж, одоогийн Буриаддууд нь Ухаант хүн голомтлон үүссэн бүс нутгийн нэр болон Хүн төрөлхтөний Соёл иргэншлийн анхдагч голомт нутгийн нэрээ эрт өнийн дуундаа өвлөн үлдээжээ гэж нэгтгэн дүгнэж байна. Ухаант хүн голомтлон үүссэн Африк тивийн Төв ба Зүүн хэсгээс Африк тивийн Нил мөрний адаг хөндийд Хүн төрөлхтөний Соёл иргэншлийн анхдагч голомт үүсч, эндээс тархан нүүдэллэж, одоогийн Бүгд Найрамдах Хятад улсын төв хэсэг, Монгол улсын нутаг дэвсгэр дээр Хоёрдогч угшлийн дорнод голомт бий болсон бөгөөд Өвөг Буриаддууд уг гарвалын нутгийн нэрээ дуундаа шингээн, зүүн хойшлон их нүүдэллэхдээ шинэ газар орныг нэрлэн, түүхэнд бичиглэн үлдээжээ. Тухайлбал: Нил мөрний адаг хөндийгөөс их нүүдэллэхдээ хойшлон Бага Ази Арабын Бүгд Найрамдах Сири улсын нутаг дэвсгэрт газар зүйн солбилцолын хойт өргөргийн 32⁰ 53¹, зүүн уртрагийн 36⁰ 03¹ орших газрыг Нава /1/, зүүнчлэн Ирак улсын төв муж /4/, зүүн хойшлон БНХАУ-ын Төвдийн өндөрлөг, Амдогоос хойш, Тянь-шань, Тэнгэр уулын хормойг /5/ Заян Нава гэж нэрлэн түүх бичлэгт үлдээжээ.

Хүний дээд өвөгт хамаарах 23-16 сая жилийн өмнө амьдарч байсан

Hominoidea: Proconsueids: Кени улсын баруун нутгаас, Хүний овогт хамаарах 3,8-3 сая жилийн урьд амьдарч байсан *Hominoidea Australopithecines afarensis* Танзани улсын хойд нутгаас, Хүний төрөлд хамаарах 2-1,6 сая жилийн өмнө амьдарч байсан *Homo: Homo habilis* Кени улсын зүүн нутгаас, Хүний зүйлд хамаарах 300,000-35,000 жилийн урьд амьдарч байсан *Homosapiens: Archaic Homo sapiens* Африк, Европ, Ази тивээс, хүний зүйлд хамаарах 100,000 жилийн өмнө амьдарч байсан *Homo sapiens sapiens* /2n=46/ Эх дэлхийн 5 тив бүрээс археологийн олдвор байдлаар олдож /6/ хүний гарал үүсэл хувьсалыг тодорхойлогч түүхэн материал болсон юм.

Монгол улсын нутаг дэвсгэрээс эртний доод чулуун зэвсгийн палеолит дэд эрин, эртний палеолитын Шелль буюу Аббевиль үеийн 400,000-100,000 жилийн өмнө амьдарч байсан эртний өвөг хүн-Архантрон археологийн олдвор /7/ олдсон.

Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Цагаан агуйгаас олдсон 800-750 мянган жилийн өмнөх түүхэн дурсгал болох халтар манан чулуун эдлэл нь хийц болон урлах арга барилаар эртний доод чулуун зэвсгийн палеолит анхдагч эрин, эртний палеолитын Шеллийн урьдах буюу Олдувай үеийнхтэй ижил байсныг /8/ тогтоосон нь Ухаант хүн голомтлон үүссэн.

Африк тивтэй Төв Ази, Монгол улсын нутаг дэвсгэрээс олдсон архелогийн эд өлгийн зүйл хүн холбоотойг давхар илтгэж байна. Хүн төрөлхтөний анхдагч соёл иргэншлийн голомт Хойт Африк, Египетэд МТӨ 3110 онд, эдүгээгээс 5120 жилийн тэртээ үүссэн ба Эртний Египетийн 3-р гүрэн болох Хүн улс, Hunu МТӨ 2638-2615

онд нийтдээ 23 жил оршин тогтноод Египетийн 4-р гүрэнд улс төрийн байр сууриа тавьж өгсөн бөгөөд Монгол улсын нутаг дэвсгэр дээр МТӨ 202-176 онд /9/ эдүгээгээс 2210 жилийн тэртээ Төв Азид Соёл иргэншлийн анхдагч голомт нутгийн Хүн улстай /10/ ижил нэртэй дэлхийн анхны нүүдэлчдийн гүрэн Монгол угсааны Хүн улс оршин тогтож байсан нь улс гүрний нэршил хүйн холбоотойг илтгэнэ. 1240 онд зохиогдож бидэнд хятад үсэг, монгол хэлээр уламжлагдан ирсэн “Монголын Нууц Товчоо” /11/ түүхэн зохиолд бүх Монголчуудыг Бөрт Чоно, Гоо марал хоёроос үүссэн гэж бичсэнээс улбаалан Тэмүүжин Чингис хаанаас урьдах удмын үеийг сэргүүлэн тооцож үзвэл, МТ 658±5 онд Монгол угсаатан, үндэстний хувьд бүрэлдэн бий болсон гэж үзэж болох юм.

Энэ дүгнэлт нь бүхэлдээ одоогийн Монголчуудын антропологи хэвшил бүрэлдсэн этногенетик, краниологи судалгаагаар /12/ давхар батлагдаж байна.

Шүүн хэлэлцэхүй. Заян Нава дууны өөр хувилбарыг А.Оюунтунгалаг 2004 /13/, Б.Ширнэн 2005 /5/, Г.Гантогтох 2005 /14/ нар болон бусад судлаач эрдэмтэд дурьдсан байдаг бөгөөд одоогоос 2100 жилийн тэртээ, МТӨ 90 онд зохиогдсон /5/ гэж үзсэн байдаг.

Дорнод аймгийн Баяндун сумын нутаг Адуунчулуун гэдэг газар Заян Нава буриад дууны монгол бичгээрх 2 бадаг дууны үг, ая нотыг сийлсэн гэрэлт чулуун хөшөө сүндэрлэж байдаг.

Угсаа гаралаа өнө эртний дуундаа өвлөн үлдээсэн Дэлхий дээрх одоогоор мэдэгдэж буй цорын ганц Монгол угсаатан нь Буриад зон болох нь бидний судалгаагаар тогтоогдов.


Дуунд гарч буй Заян болон Нава дууны үг нь араб бичгээр Ухаант хүн голомтлон үүссэн Төв Африк болон хүн төрөлхтөний анхдагч соёл иргэншлийн голомт Хойт Африк, Нил мөрний адаг хөндийн гол болон газрын нэршлээр хадгалагдсан үлдсэн байна. Заян Нава дуу нь эдүгээгээс 4623 жилийн тэртээ зохиогдсон гэх үндэслэл байна. Африк тивийн Танзани улсын Олдувайн чулуун зэвсэг урлах арга барилтай ижил байгаа нь бидний дэвшүүлж буй шинжлэх ухааны таамаглалыг давхар баталж байна.

Дүгнэлт

1. Дуунд гарч буй Заян ба Нава гэдэг үг нь угтаа Хүн төрөлхтний Соёл иргэншлийн анхдагч голомт нь нутгийн нэр байна.

2. Буриадууд угсаа гарвалаа өнө эртний дуундаа өвлөн үлдээсэн байна.

3. Одоогийн Буриадууд нь Монгол угсаатны язгуур угшил болно.



Summary

1. The words Zaiyan and Nawa in the song are name of a primary hearth place of Human kind civilization
2. Buriads inherited the history of their own origin in the song of immemorial period
3. Current Buriads are forebears of Mongolian nation

Ашигласан хэвлэлийн жагсаалт

1. Словарь географических названий Арабских стран. В дух томах. Т 1. Москва. Наука . 1973. 358 с. с.199, 324
2. В.П.Алексеев 1985. Человек. Эволюция и таксономия . Некоторые теоретические вопросы Москва. Наука. 286 с .с.108
3. Атлас Мира. Африка , Москва . ГУГК 1982.38 с .с.33
4. Д.Жаргалсайхан 2006. ТҮ 25 телевизийн Би нэвтрүүлгийн 12-р сарын 16-ны өдрийн ярилцлага
5. Б.Ширнэн 2005. Буриадын нүүдэл-хэл аялгууны учир. Түүх хэл шинжлэл. УБ Admon. 162 х. х.11,17
6. С.Р.Kottak 1994. Anthropology. The Exploration of Human diversity NY.Mc Graw – hill. 604 p. p.121
7. Д.Дорж 1990. Каменный век Монголий. Диссертация. Новосибирск. ИИФФ СО АН СССР 37 с. с, 32
8. С.Бадрал 2001 Монголын эртний чулуун баримлын судалгаа. Зэрэг горилсон зохиол. УБ. МУБИС. 174 х
9. Сэр-Оджав 1971. Древняя история Монголии. Автореферат диссертации. Новосибирск. СО АН СССР 27 с. с.15
10. The Encyclopedia Americana.v.10.Egypt-Falsetto. Danbury. Crolier. 2000. 862 p. p.33
11. Монголын нууц товчоо. УБ. Мөнхийн үсэг. /1240/ 2005. 287 н. н. 7
12. Д.Түмэн 1985. Вопросы этногенеза Монголов в свете данных палеоантропологи и. Диссертация .Москва. ИОЭБ АН МНР. 175 с .с.159
13. А.Оюунтунгалаг 2004. МУ-ын Буриадууд. УБ. Урлах эрдэм. 262 х. х.220
14. Г.Гантогтох 2005. Дашбалбар, дашбалбарынхан. Нутгийн тайлбар толь. УБ. Өнгөт хэвлэл. 240 х. х.77
15. Х.К.Баранов 1970. Арабско – Русский словарь. Книга 1, 2. Около 63 тыс. слов. Москва. СЭ. 1173 с.

BURIAD STUDIES

I Боть

11 (001)

2008

Осорова С.Г.,
к.ф.н., доцент БГУ

МҮНӨӨ ҮЕЫН БУРЯАД УРАН ЗОХЁОЛ: ОРШОН БАЙДАЛЫЕ ШЭНЖЭЛГЭ

Һүүлшын жэлнүүдтэ боложо байгаа гүрэн түрын хубилалтанууд бүхы ажабайдалай ябасада нүлөө үзүүлһэниинь эли. Уран зохёол шэнжэлдэг эрдэм ухаан шэнэ шэглэл баримталан һонин асуудалнуудые элирүүлхые оролдоно.

